



СОЁЛЫН ЖИМЭЭР
THE CULTURAL WAY

ЭРДЭМ

ШИНЖИЛГЭЭ

ᠰᠣᠶᠣᠳᠣᠨ
ᠰᠣᠶᠣᠳᠤ
ᠰᠤᠮᠤᠨᠵᠢᠯᠭᠡᠭᠡ



ᠰᠣᠶᠣᠳᠣᠨ
ᠰᠣᠶᠣᠳᠤ
ᠰᠤᠮᠤᠨᠵᠢᠯᠭᠡᠭᠡ

Эрхэлсэн: Э.Итгэл



СОЁЛЫН ЖИМЭЭР
THE CULTURAL WAY

ISSN: 2791-1446

БОТЬ IV (№4)

Редакцын зөвлөл:

Доктор (Sc.D)	Д.Бадамдорж	(Монгол)
Доктор (Ph.D)	Л.Чулуунбаатар	(Монгол)
Доктор (Ph.D)	Н.Мягмар	(Монгол)
Доктор (Ph.D)	Л.Хурцбаатар	(Герман)
Доктор (Ph.D)	Л.Хасбаатар	(БНХАУ)
Доктор (Ph.D)	Б.Болд	(Япон)
Доктор (Ph.D)	Залгаабаяр	(БНХАУ)

“СОЁЛЫН ЖИМЭЭР” Соёл Судлалын Төвийн

Эрдэм шинжилгээний редакцын зөвшөөрлөөр хэвлэх, улирал тутмын сэтгүүл

Улаанбаатар 2022

ISSN: 2791-1446

© Sodon Soyod Publishing, Mongolia



СОЁЛЫН ЖИМЭЭР
THE CULTURAL WAY

ISSN: 2791-1446

VOLUME IV

Editorial board:

Doctor (Sc.D)	Badamdorj. D	(Mongolia)
Doctor (Ph.D)	Chuluunbaatar. L	(Mongolia)
Doctor (Ph.D)	Myagmar. N	(Mongolia)
Doctor (Ph.D)	Qurčabaatar. L	(Germany)
Doctor (Ph.D)	Qasbaatar. L	(China)
Doctor (Ph.D)	Bold. B	(Japan)
Doctor (Ph.D)	Zalgaabayar	(China)

Edited by: Itgel. E

THE CULTURAL WAY
CENTER FOR CULTURAL STUDIES
Printed with permission of editorial board
A quarterly journal of research
Ulaanbaatar 2022

ISSN: 2791-1446

© Sodon Soyod Publishing, Mongolia



СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

ГАРЧИГ

1. ЦЭРЭНЖАВ. Б, БАТБЯМБА. Т
*“МОНГОЛ АДУУНЫ НЭВТЭРХИЙ ТОЛЬ”-ИЙН ҮГИЙН САНГИЙН
ДАВТАМЖИЙН СУДАЛГАА.....1*
2. ПАНЬ ВЭНЬЧИ
*МОНГОЛ БИЧГИЙН БОЛОВСРОЛЫН ҮҮСЭЛ, ХӨГЖЛИЙГ НЯГТЛАХ
НЬ.....9*
3. ОЮУНТОЛЬ
*ХОРЧИН ЗҮҮН ГАРЫН ХОЙД ХОШУУНЫ ГАЗРЫН НЭРИЙН ДОМГИЙН
ҮҮСЭЛ.....15*
4. ШҮРЭЭ. Ү, БАТБЯМБА. Т
*ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ЦАХИМ СУРГАЛТЫГ НИЙГЭМ ХЭЛ
ШИНЖЛЭЛИЙН ҮҮДНЭЭС ТОДРУУЛСАН НЬ.....30*
5. УЯНГА
*МОНГОЛ УЛСЫН ОРЧИН ҮЕИЙН УРАН ЗОХИОЛЫН ДУНДАД УЛС ДАХЬ
СУДАЛГААНЫ ТУХАЙ ТОВЧ ӨГҮҮЛЭХ НЬ (ХОЁР).....41*
6. ОДЗАЯА. Л
*УРИАНХАЙН ХОШУУДЫН ГАЗАР НУТГИЙН ТҮҮХИЙН
АСУУДАЛД.....51*
7. АНЬ НИН
*ЧИН УЛСЫН ДУНД ҮЕИЙН ХӨВӨӨТ ШАРЫН СҮРЭГ БА ЦАХАР ХӨВӨӨТ
ШАР ХОШУУНЫ НУТГИЙН ХИЛИЙН ШИНЖЛЭЛ.....61*
8. КАНЬ ХАЙ ИН
*ШИНЭ ЭРИНЭЭС НААШ ДУНДАД УЛСЫН ОРЧИН ҮЕИЙН УТГА
ЗОХИОЛЫН МОНГОЛ УЛАМЖЛАЛЫГ ХҮЛЭЭН АВАХ ОРЧИН АХУЙН СОНГОЛТ БА
НӨЛӨӨ ТУСГАЛ.....77*
9. ИТГЭЛ. Э
*ХӨВСГӨЛ ДАЛАЙ БҮРЭНХАН УУЛЫН ХОШУУНЫ ТҮҮХЭНД ХОЛБОГДОХ
НЭГЭН БАРИМТЫН ТУХАЙ ТОВЧ ӨГҮҮЛЭХ НЬ.....95*
10. МӨНХЦЭЦЭГ. А, ТҮВШИНБАЯР. Ц
*МОНГОЛ УЛСЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ,
ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ.....101*
11. ЛХАГВАЖАВ. Б
*САЖА БАНДИДА МОНГОЛ БИЧГИЙГ ЗОХИОСОН ТУХАЙ ДОМГИЙГ
ДАХИН АВЧ ҮЗЭХ НЬ.....107*
12. И БО РАНЬ
*ХЯТАНЧУУД УМАРД ЦЭРГИЙН ЯВДЛЫН ХҮРЭЭЛЭНГ БАЙГУУЛСАН БА
ДИЕЛА ОВОГ ХУВААГДСАН ЗЭРЭГ ҮЙЛ ЯВДЛЫН ХАМААРЛЫГ ТОВЧ ӨГҮҮЛЭХ
НЬ.....117*



СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

CONTENT

1. Tserenjav. B, Batbyamba. T
Vocabulary frequency study of “Encyclopedia of mongolian horses”.....1
2. Wenqi Pan
Trying to argue for the emergence and development of Mongolian writing education.....9
3. Oyuntoli
On the source of legend story of Kezuohouqi’s placename.....15
4. Shuree. U, Batbyamba. T
Examining e-education during the covid-19 pandemic from the sociolinguistic aspect.....30
5. Uyanga
On the study of modern Mongolian literature in China (2).....41
6. Odzaya. L
Issues local history of Uriankhai headland.....51
7. An Ning
The study on the boundary of bordered Yellow banner pasture and Chahar bordered yellow banner in the middle of Qing dynasty.....61
8. Kan Hai Ying
The context choice and influence of modern Chinese literature’s reception of Mongolian translation since the new period.....77
9. Itgel. E
About a fact related to the history of Khuvsgul Dalai Burenkhan Uul.....95
10. Munkhtsetseg. A, Tuvshinbayar. Ts
Media independence in Mongolia, it’s legal regulation.....101
11. Lkhagvajav. B
Reconsidering the legend of Saja bandida’s creation of Mongolian script.....107
12. Yi Bo Ran
Analysis of relationship between Khitan's establishment of the northern privy council and Diela department.....117



СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

ЭРХЛЭН ХЭВЛҮҮЛЭГЧИЙН ҮГ

Энэ удаагийн дугаарт ШУА-ийн Хэл Зохиолын Хүрээлэн, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Дотоод Хэргийн Их Сургууль, Өвөр Монголын Их Сургууль-Монгол Судлалын Дээд Сургууль, Шаогуань Их Сургууль, Хаалган хот дахь Удирдлагын Сургууль, Барилгын Политехник Коллеж зэрэг эрдэм шинжилгээний байгууллагуудын эрдэмтэн багш, судлаач, докторант, магистрантуудын өгүүллүүд багтлаа. Эрдэм шинжилгээний үйл хэргийг чин сэтгэлээсээ дэмжин, зөвлөгөө шүүмжээ харамгүй хайрладаг номын садан, нөхөддөө ихэд баярлаж байна. Аливаа судалгааны ажил бүхнийг хүч хөдөлмөр, хөрөнгө санхүүгүйгээр төсөөлөхийн аргагүй билээ. Тус дугаарыг хэвлүүлэхэд онцгой дэмжлэг үзүүлсэн эрхэм анд “Их Хаадын Цуваа” ХХК-ий захирал Өлзийхүүгийн Дашдаваа, эрхэм номын ах, анд нөхөр Шаогуань ИС-ийн багш Жян Юань нартаа машид талархаж буйгаа энд тэмдэглэе.

Эрдэнэхуягийн Итгэл
ӨМИС-ийн Хятадын түүх судлалын докторант
2022 оны 12 сар

**“МОНГОЛ АДУУНЫ НЭВТЭРХИЙ ТОЛЬ”-ИЙН ҮГИЙН САНГИЙН
ДАВТАМЖИЙН СУДАЛГАА**

Б.Цэрэнжав*

Т.Батбямба**

ХУРААНГУЙ

Сүүлийн жилүүдэд дэлхийн томоохон нийгмийн сүлжээ, хайлтын системийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд мэдлэгийн графикайг нэвтрүүлж, өөрсдийн үйл ажиллагаагаа өргөжүүлж байна. Бид ч мөн “Монгол адууны нэвтэрхий толь”-ийн мэдлэгийн график (knowledge graph KG)-ийг байгуулахаар ажиллаж, энэхүү зорилгынхоо хүрээнд юуны урьд судлаач Д.Баянбатын санаачлан, 2016 онд эмхэтгэн хэвлүүлсэн “Монгол адууны нэвтэрхий толь”-ийн боть I, II-ийн үгийн санг бүртгэн, бүрэн цахим санг үүсгэлээ. Улмаар уг сандаа тулгуурлан Японы Васеда Их Сургуулийн Шинжлэх ухаан, инженерчлэлийн факультетын профессор Лоренс Антонын боловсруулсан AntConc¹ программыг өгөгдөл боловсруулах томъёотой хослуулан толийн нийт үгийн тоог бүртгэж, давтамжийг нь тооцоолов.

“Монгол адууны нэвтэрхий толь”-ийн I, II ботийн үгийн сангийн давтамжийг тооцоолж, харьцуулан үзэж, тусгай мэргэжлийн судлаачдад гарын авлага болгон ашиглах боломжтой тоо баримтад суурилсан судалгааны үр дүнгээ тайлбарлан өгүүлэв. Энэ нь толь бичгийн үгийн санг тооцоо хэл шинжлэлийн үүднээс шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлахын ач холбогдлыг тодруулахад чиглэсэн болно.

Түлхүүр үгс: *Тооцоо хэл шинжлэл, мэдлэгийн график, үгийн сан, үгийн давтамж*

УДИРТГАЛ

Мэдлэгийн график нь аливаа ухагдахууны ойлголт, нэгж, харилцаа, үйл явдлын харилцан уялдаатай тайлбаруудын цуглуулга бүхий мэдлэгийн загвар юм. Мэдлэгийн график гэх нэр томъёог 1972 онд хичээл сургалтад зориулсан “Модуль сургалтын системийг хэрхэн бий болгох тухай” хэлэлцүүлэгт анх

* ӨМИС-ийн МСДС-ийн докторант, tserenjav1247@gmail.com, 91063337

** ШУА-ийн ХЗХ-ийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбарын ЭША, batbyamba_t@mas.ac.mn, 94881022

¹ <https://www.laurenceanthony.net/software/antconc/>.



THE CULTURAL WAY

дурджээ². Мэдлэгийн графикууд нь холбоос болон семантик мета өгөгдлөөр дамжуулан өгөгдлийг бичвэрт оруулдаг бөгөөд ингэснээр өгөгдлийг нэгтгэх, ангилан ялгах боломжтой хүрээг бүрдүүлдэг.

Мэдээллийн шинжлэх ухаан болон хиймэл оюун ухаанд мэдлэгийн графикийг дараах байдлаар ашигладаг. Тэдгээрээс төлөөлүүлэн дурдвал,

- Мэдээллийн эх сурвалжид хандах, сурвалжуудын мэдээллийг нэгтгэж боломжийг хөнгөвчлөх;
- Машин сургалт, гүн сургалт (deep learning) зэрэг өгөгдөлд суурилсан бусад хиймэл оюун ухааны арга техникүүдэд бичвэр болон нэмэлт мэдээллийг нэмэгдүүлэх;
- Хэрэглэгчдэд зориулсан тодорхой, ойлгомжтой агуулга бүхий тайлбарыг бий болгох;
- Хүн-машин хоорондын харилцан ойлголцох гүүр болгох³ гэх мэт болно.

Иймд мэдлэгийн графикийг хайлт, чатбот, зөвлөмжөөс эхлээд машин сургалт, эх хэлний боловсруулалт зэрэг янз бүрийн ухаалаг системд туслах боломжтой хэмээн үздэг.

Түүхийг сөхөн үзвэл, 1980-аад оны сүүлчээр Гронинген ([University of Groningen](#)), Твенте ([University of Twente](#)) нарын их сургуулиуд хамтран мэдлэгийн график нэртэй төслийг эхлүүлсэн бөгөөд 2007 онд Dbpedia⁴ (Лейпцигийн их сургууль болон Манхаймын их сургуулийн хамтран хөгжүүлсэн төсөл) ба Freebase⁵ (Америкийн программ хангамжийн Metaweb компани) нь ерөнхий мэдлэгийн санд суурилсан мэдлэгийн графикийг байгуулсан хэдий ч үүнийгээ "Мэдлэгийн график" гэж тодорхойлоогүй. 2012 онд Google нь өөрсдийн байгуулсан мэдлэгийн графикаа⁶ танилцуулсан Google мэдлэгийн график нь Google доторх мөрд суурилсан хайлтын амжилттай нэмэлт хэрэгсэл болж, сүлжээгээр алдаршсанаар "мэдлэгийн график" хэмээх нэр томъёо түгээмэл хэрэглэгддэг болсон. Үүнээс хойш Facebook, LinkedIn, Microsoft, Amazon⁷ зэрэг хэд хэдэн үндэстэн дамнасан технологийн компаниуд өөрсдийн мэдлэгийн графикийг сурталчлан таниулснаар "мэдлэгийн график"-ийн ач холбогдол улам өссөн юм. Улмаар 2019 онд Institute of Electrical and Electronics Engineers (IEEE) нь жил бүр зохион байгуулдаг "Big Knowledge",

² Edward W. Schneider. 1973. Course Modularization Applied: The Interface System and Its Implications For Sequence Control and Data Analysis. In Association for the Development of Instructional Systems (ADIS), Chicago, Illinois, April 1972

³ <https://www.turing.ac.uk/research/interest-groups/knowledge-graphs>

⁴ Лили, Хай Ин Хуа, *Монгол хэлний мэдлэгийн сан байгуулах арга туршилагын тухай өгүүлэх нь*, Хэрэглээний хэл шинжлэл сэтгүүл, Боть IV(19), Дэвтэр 15, 117 тал.

⁵ Мөн тэнд.

⁶ Singhal, Amit (May 16, 2012). *"Introducing the Knowledge Graph: things, not strings"*. Official Google Blog. Retrieved 21 March 2017.

⁷ <https://www.ontotext.com/knowledgehub/fundamentals/what-is-a-knowledge-graph/>



THE CULTURAL WAY

"Data Mining and Intelligent Computing" гэсэн олон улсын бага хурлуудыг нэгтгэн “Мэдлэгийн графикийн олон улсын бага хурал”⁸ болгосон.

Хөгжлийн шинэ шатандаа яваа мэдлэгийн график нь монголд хараахан танигдаагүй байгаа шинэ зүйл юм. Харин Өвөрмонголын их сургуулийн докторант Ли ли “Монгол соёлын мэдлэгийн зургийн цогцлолт ба судалгаа” сэдвээр докторын зэрэг горилсон нэг сэдэвт өгүүллээ бичсэн нь монгол судлалын түүхэнд энэ онол арга зүйг нэвтрүүлсэн анхны бүтээл болсон билээ.

Цахим санд тулгуурлан өгөгдлүүдийг боловсруулан, мэдлэгийн графикийг байгуулахад үгийн сангийн давтамжийн судалгаа нэн чухал байдаг. Иймээс бид Монгол улсад хэвлэгдсэн нэвтэрхий толиудаас “Монгол адууны нэвтэрхий толь”-ийг сонгон авч, уг толийн үгийн санд давтамжийн судалгаа хийж, нэвтэрхий толийн үгийн санг тооцоо хэл шинжлэлийн үүднээс судлах ажилд өөрсдийн саналыг нэмэрлэхийг зорив. Энэ төрлийн судалгаа нь “Монгол адууны нэвтэрхий толь”-ийн хэл найруулгад ашиглаж буй үгийн хэрэглээний байдал, үгийн сангийн баяжилт, найруулгын онцлог, мэдлэгийн графикийн тулгуур үг зэргийг тодруулахад ач холбогдолтой юм.

Судалгааны үндсэн хэсэг

Монгол хэлний үгийн сангийн цахим сан байгуулах ажлыг өнгөрсөн зууны наяд оноос эхлэн Өвөр Монголын Их Сургуулийн Монгол хэл судлах газар “Монгол хэлний мэдээлэл боловсруулалт (mongolian information processing)-ын ажлаар эхлүүлсэн”⁹ бөгөөд хагас зуун жил хүрэхгүй хугацаанд хүн машин хоорондын харилцан үйлчлэлийг бий болгох зорилгын хүрээнд монгол хэлийг тооцоо хэл шинжлэлийн үүднээс судлах ажлыг их бага боловч ямар нэгэн түвшинд хийж, тодорхой үр дүнг гаргаж, хэрэглээнд нэвтрүүлсээр байна.

Цахим технологид шилжиж байгаа дэлхийн улс орнуудын туршлагад үндэслэн хэрэглэгчдэд ном хэвлэлийн бүтээгдэхүүнийг уншиж судлах, танин мэдэхэд нь олон талт боломжийг олгох нь нэн тэргүүний шаардлагад зүй ёсоор тооцогдож байна.

Иймд бид зорилгынхоо хүрээнд “Монгол адууны нэвтэрхий толь”-ийн үгийн сангийн цахим санг байгууллаа. Учир нь тус тольд адууны соёлд хамаарагдах адууны эдлэл хэрэглэл, адууны тухайт эд өлгийн зүйлс, адууны дэл сүүл, арьс ширээр үйлддэг төрийн хар цагаан сүлд тугаас аваад морин хуур хөгжим, бусад гар урлал, уран зураг, хөшөө баримал зэрэг биет соёлын өвүүд, адууг маллаж арчилж ирсэн, амьдралаас урган гарсан, мянга мянган жилийн хур мэдлэг туршлага, Монголчуудын ёс заншил, аман зохиолын бүхий л төрөл

⁸ ["2021 IEEE International Conference on Knowledge Graph \(ICKG\)*". KMedu Hub. 2017-07-09. Retrieved 2021-03-22](#)

⁹ С.Насан-Урт, *Монгол хэл бичгийн сураг занги боловсруулах онол практикийн зарим асуудал*. Уб., 2004, 3 тал.



THE CULTURAL WAY

зүйлд шингэсэн адууны тухайт зүйлс, уламжлалт үг хэллэг, морийг таньж шинжиж, судалж ирсэн монгол ухаан, түүнийг тэмдэглэж туурвисан Монгол судар шастир, адууны элдэв өвчин, гэмтэл, согогийг анагаан эдгээж ирсэн ардын уламжлалт арга ухаан, дом засал, эм эмчилгээ зэрэг оюуны соёлын далай их өвийг¹⁰ бүгдийг багтаажээ.

Уг нэвтэрхий толийн бүрэн цахим сан болон нэг, хоёрдугаар боть тус бүрийн хүрээнд байгуулсан цахим сангийн үгийн санг хэл зүйн нөхцөлөөр хувилсан үгсийн хүрээнд тооцоолж үзвэл дараах байдалтай байна. Үүнд,

Хүснэгт № 1. Цахим сангийн үгийн сангийн байдал

№	Цахим сангийн нэр	Нийт үгийн тоо	Хэл зүйн хувилалтай үгийн тоо
1	“Монгол адууны нэвтэрхий толь” Боть I	207.882	29.291
2	“Монгол адууны нэвтэрхий толь” Боть II	142.728	14.509
3	“Монгол адууны нэвтэрхий толь” бүрэн цахим сан	350.610	34.545

Хүснэгтээс үзвэл:

- “Монгол адууны нэвтэрхий толь”-ийн нэгдүгээр ботид хэл зүйн хувиллаар хэлбэржсэн 29.291 үг, давтагдсан тоогоор нийт 207.882 үг,
- “Монгол адууны нэвтэрхий толь”-ийн хоёрдугаар ботид хэл зүйн хувиллаар хэлбэржсэн 14.509 үг, давтагдсан тоогоор нийт 142.728,
- “Монгол адууны нэвтэрхий толь”-ийн бүрэн цахим санд хэл зүйн хувиллаар хэлбэржсэн 34.559 үг, давтагдсан тоогоор нийт 350.610 үг тус тус бүртгэгдэв.

Хэл зүйн хувиллаар хэлбэржсэн 34.545 үгийн утгыг мэдэж байхад дээрх нэвтэрхий толийг чөлөөтэй ойлгох боломжтой гэсэн үг юм.

“Монгол адууны нэвтэрхий толь”-ийн бүрэн цахим сангийн үгийн давтамжийг тооцоолж, үр дүнг аравт, зуут, мянгатаар ангилснаа дараах хүснэгтээр үзүүлбэ. Үүнд:

Хүснэгт № 2. Бүрэн цахим сангийн үгийн сангийн давтамж

Давтамжийн тоо	1	2	3	4	5	6	7	8	9	10
Нэгж үгийн тоо	16674	5347	2681	1750	1106	867	669	545	464	408
Нийт үгийн тоо	16674	10694	8043	7000	5530	5202	4683	4360	4176	4080
Хувь	4,75%	3,05%	2,29%	1,99%	1,57%	1,48%	1,33%	1,24%	1,19%	1,16%

¹⁰ Д.Баянбат, *Монгол адууны нэвтэрхий толь*, Боть I, 3 тал.



THE CULTURAL WAY

Давтамжийн тоо	11-20	21-30	31-40	41-50	51-60	61-70	71-80	81-90	91-100
Нэгж үгийн тоо	1739	665	384	229	162	133	95	70	58
Нийт үгийн тоо	25332	16370	13574	10396	8950	8686	7168	5985	5584
Хувь	7,22%	4,66%	3,87%	2,96%	2,55%	2,47%	2,04%	1,70%	1,59%

Давтамжийн тоо	101-200	201-300	301-400	401-500	501-600	601-700	701-800	801-900	901-1000	1001-2000	2001-3000	3001-4000
Нэгж үгийн тоо	246	103	49	17	23	9	8	11	5	20	5	3
Нийт үгийн тоо	3987	25391	16960	7596	12423	5963	6044	9225	4664	26819	11699	10944
Хувь	9,69%	7,24%	4,83%	2,16%	3,54%	1,70%	1,72%	2,63%	1,33%	7,64%	3,34%	3,12%

Бүрэн цахим сангийн үгийн сангийн давтамжийг харуулсан хүснэгтээс үзвэл:

1-10 удаа давтагдсан 70.442 үг нь нийт үгийн сангийн 20.49%-ийг,
 11-20 удаа давтагдсан 25.332 үг нь нийт үгийн сангийн 7.22%-ийг,
 21-30 удаа давтагдсан 16.370 үг нь нийт үгийн сангийн 4.66%-ийг,
 31-40 удаа давтагдсан 13.574 үг нь нийт үгийн сангийн 3.87%-ийг,
 41-50 удаа давтагдсан 10.396 үг нь нийт үгийн сангийн 2.96%-ийг,
 51-60 удаа давтагдсан 8.950 үг нь нийт үгийн сангийн 2.55%-ийг,
 61-70 удаа давтагдсан 8.686 үг нь нийт үгийн сангийн 2.47%-ийг,
 71-80 удаа давтагдсан 7.168 үг нь нийт үгийн сангийн 2.04%-ийг,
 81-90 удаа давтагдсан 5.985 үг нь нийт үгийн сангийн 1.70%-ийг,
 91-100 удаа давтагдсан 5.584 үг нь нийт үгийн сангийн 1.59%-ийг,
 101-200 удаа давтагдсан 33.987 үг нь нийт үгийн сангийн 9.69%-ийг,
 201-300 удаа давтагдсан 25.391 үг нь нийт үгийн сангийн 7.24%-ийг,
 301-400 удаа давтагдсан 16.960 үг нь нийт үгийн сангийн 4.83%-ийг,
 401-500 удаа давтагдсан 7.596 үг нь нийт үгийн сангийн 2.16%-ийг,
 501-600 удаа давтагдсан 12.423 үг нь нийт үгийн сангийн 3.54%-ийг,
 601-700 удаа давтагдсан 5.963 үг нь нийт үгийн сангийн 1.70%-ийг,
 701-800 удаа давтагдсан 6.044 үг нь нийт үгийн сангийн 1.72%-ийг,
 801-900 удаа давтагдсан 9.225 үг нь нийт үгийн сангийн 2.63%-ийг,
 901-1000 удаа давтагдсан 4.664 үг нь нийт үгийн сангийн 1.33%-ийг,
 1001-2000 удаа давтагдсан 26.819 үг нь нийт үгийн сангийн 7.64%-ийг,



THE CULTURAL WAY

2001-3000 удаа давтагдсан 11.699 үг нь нийт үгийн сангийн 3.34%-ийг, 3001-4000 удаа давтагдсан 10.944 үг нь нийт үгийн сангийн 3.12%-ийг тус тус эзэлжээ.

Бүрэн цахим санд “эрэмбэ”, “эрсхэн”, “харвуул”, “нян”, “булуу”, “бултайх”, “ачлага” зэрэг 16.674 үг зөвхөн нэг удаа бүртгэгдэж, нийт сангийн 4.75%-ийг эзэлж байна. Харин хамгийн олон давтамжтай “уяач” үг нь 3979 удаа давтагдаж, нийт сангийн 1,13%-ийг бүрдүүлжээ.

Хүснэгт № 3. Хамгийн их давтамжтай үгс

	A	B	C	D	E	F	G	H
1	Group	Freq	uf_1	Cumulative frequency	Cumulative percent	Zipf Score(R*F)		
2	уяач	3979	3979	12021	3.35	7958		
3	их	3515	3515	15536	4.33	10545		
4	морь	3450	3450	18986	5.29	13800		
5	улсын	2534	2534	21520	5.99	12670		
6	сумын	2472	2472	23992	6.68	14832		
7	оны	2444	2444	26436	7.36	17108		
8	онд	2206	2206	28642	7.97	17648		
9	төв	2043	2043	30685	8.54	18387		
10	наадамд	1964	1964	32649	9.09	19640		
11	азарга	1816	1816	34465	9.59	19976		

Бүрэн цахим сангийн үгийн давтамжийн тооцооллоос үзвэл, “уяач”, “их”, “морь” гэх мэт дээрх хүснэгтэд үзүүлсэн 10 үг нь 26.423 удаа давтагдаж, нийт сангийн 7.53%-ийг эзэлж байна.



THE CULTURAL WAY

ДҮГНЭЛТ

Бид “Монгол адууны нэвтэрхий толь”-ийн нэг, хоёрдугаар ботийн үгийн сангаар бүрэн цахим сан бүрдүүлэн, үгийн давтамжийн судалгааг хийж, дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

- 350.610 үг бүхий “Монгол адууны нэвтэрхий толь”-ийн бүрэн цахим санг байгууллаа. Тус санд давтагдаагүй тоогоор 34.559 хэл зүйн хувиллаар хэлбэржсэн нэгж үг бүртгэгдлээ. Бүрэн цахим санд хамгийн цөөн буюу нэг удаа давтагдсан 16.674 үг нь нийт сангийн 4.75%-ийг эзэлж байгаа бол, хамгийн олон давтамжтай “уяач” үг нь 3979 удаа давтагдаж, нийт сангийн 1,13%-ийг эзэлж байна. Энэхүү тооцооллын үр дүн нь тус нэвтэрхий тольд адууны гарал угсаанаас эхлээд эдлэл хэрэглэл, нас, зүс, явдал, адууны соёлтой холбоотой тамга, тэмцээн, уралдаан, дуу, шүлэг, судар зэрэг олон талт өргөн хүрээний мэдлэгийг багтаасныг харуулж байна.
- “Монгол адууны нэвтэрхий толь”-д цахим сангийн үгийн сангийн давтамжийн судалгааны үр дүнг ашиглаж, түлхүүр үгсийг оновчтой тодорхойлсноор “Адууны соёлын нэвтэрхий толийн мэдлэгийн график”-ийг байгуулах суурь бүрдлээ.
- Цаашид “Монгол адууны нэвтэрхий толь”-ийн нэг, хоёрдугаар дэвтрийн цахим сангийн үгийн санг харьцуулахын зэрэгцээ бусад ерөнхий нэвтэрхий толиудад тусгасан адуутай хамаа бүхий мэдлэгүүдийг нэгтгэн, хайлтын системд оруулах зэргээр энэ чиглэлийн судалгааг өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай болно.



THE CULTURAL WAY

ABSTRACT

In recent years, the world's major social network and search engine companies have adopted knowledge graphs and expanded their operations. We are also working to create a knowledge graph (knowledge graph KG) of the "Encyclopedia of Mongolian Horses", and within the framework of this goal, the vocabulary of volumes I and II of the "Encyclopedia of Mongolian Horses" compiled and published in 2016 by D. Bayanbat, a pioneer researcher has been registered and a complete electronic database has been created. Then, based on the database, the AntConc program developed by Professor Laurence Anton of the Faculty of Science and Engineering of Waseda University, Japan, was combined with data processing formulas to record the total number of words in the encyclopedia and calculate their frequency. Subsequently, research results based on the quantitative data from calculation and comparison of the vocabulary frequency of volumes I and II of "Encyclopedia of Mongolian Horses", can be used as a guide for specialized researchers. It is aimed at clarifying the importance of scientific study of the dictionary vocabulary from the point of view of computation and linguistics.

НОМ ЗҮЙ

1. Д.Баянбат, *Монгол адууны нэвтэрхий толь*, Боть I, 3 тал.
2. Лили, Хай Ин Хуа, *Монгол хэлний мэдлэгийн сан байгуулах арга туршилагын тухай өгүүлэх нь*, Хэрэглээний хэл шинжлэл сэтгүүл, Боть IV(19), Дэвтэр 15, 117 тал.
3. С.Насан-Урт, *Монгол хэл бичгийн сураг занги боловсруулах онол практикийн зарим асуудал*. Уб., 2004, 3 тал.
4. Edward W. Schneider. 1973. Course Modularization Applied: The Interface System and Its Implications For Sequence Control and Data Analysis. In Association for the Development of Instructional Systems (ADIS), Chicago, Illinois, April 1972
5. Singhal, Amit (May 16, 2012). *"Introducing the Knowledge Graph: things, not strings"*. Official Google Blog. Retrieved 21 March 2017.
6. *"2021 IEEE International Conference on Knowledge Graph (ICKG)*"*. KMedu Hub. 2017-07-09. Retrieved 2021-03-22

<https://www.laurenceanthony.net/software/antconc/>.

<https://www.turing.ac.uk/research/interest-groups/knowledge-graphs>

<https://www.ontotext.com/knowledgehub/fundamentals/what-is-a-knowledge-graph/>

МОНГОЛ БИЧГИЙН БОЛОВСРОЛЫН ҮҮСЭЛ, ХӨГЖЛИЙГ НЯГТЛАХ НЬ

Пань Вэньчи*

ХУРААНГУЙ

Монголд үсэг бичиг бий болохоос өмнө ан агнуурын үйл ажиллагаа нь хүмүүжлийн үндсэн арга байсан бөгөөд өвс зангидах, мод сийлбэрлэх, хэл ярианы илэрхийлэл зэргээр дамжуулан мэдээлэл дамжуулдаг байжээ. Монгол үсэг бичиг гарч ирсний дараа монгол үсгийг хөгжүүлэх үйл ажиллагаа эхэлж, хоёр үеийн хаадын хүчин зүтгэлээр монгол үсгийн боловсрол нь монголын ноёд, хаадаас эхлээд монголын хойч үед, улмаар тал нутгийн ард түмэнд сурган заах үйл явцыг өрнөсөөр иржээ. Монгол бичгийн боловсрол монголын тэгш өндөрлөгөөс цааш газар нутгийг хамарсан байна.

Түлхүүр үгс: *Авлах үйл ажиллагаа, монгол үсэг бичиг, боловсролын үйл ажиллагаа, дундад орны бүс нутаг*

Өгүүллийн бүтэц:

- *Удиртгал*
- *Үсэг бичиг дэлгэрэхээс өмнөх монголчуудын байдал*
- *Монгол үсэг бичгийн боловсролын үүсэл хөгжлийн явц*
- *Дүгнэлт*

Монгол бичиг гарч ирэхээс өмнө монголчууд ан агнах байдлаар цэргийн боловсрол эзэмшиж байв. Ан ав нь тухайн үеийн дайн тулаанд зохицсон, монгол дайчдыг сургах хүмүүжүүлэх арга байжээ. Цэргийн хэмжээнд мэдээлэл дамжуулах асуудал гарвал тушаал, өвсний зангилаа, модон сийлбэр, хэл ярианы илэрхийлэл зэргээр дамжуулж болно. Чингис хаан монголын тэгш өндөрлөгийг нэгтгэсний дараа энх тайван тогтож, монгол үндэстний нийтлэг бүрэлдэж эхэлсэн тул өөрийн гэсэн хэлтэй, ялангуяа Чингис хаан албан бичиг баримтад онцгой ач холбогдол өгч байв. Чингис хаан уйгур эрдэмтэн Тататунгаатай уулзсанахаа дараа, уйгур үсгээр монгол үгийг бичиж, ноёд, хаад, улмаар монгол хүүхдүүдэд заан сургах, монгол үсгийг тал нутагт алдаршуулах зарлиг буулгажээ. Өгэдэйн хааны үед Алтан улс, өмнөд Сүн улсыг мөхөөж, монголчууд Төв Азийг захирах эрхтэй болов. Иймээс тал нутагт монгол хэл, монгол үсэг бичиг өргөн дэлгэрч эхлэв. Монгол үсэг бичиг бий болсон нь монголын тэгш өндөрлөгөөс гадна ихэнх нутаг дэвсгэрт монгол соёлыг түгээн дэлгэрүүлэх, монгол үндэстний нэгдлийг бататгах, монгол соёлын нөлөөг нэмэгдүүлэхэд зохих нөлөө үзүүлсэн нь ажиглагдаж байна.

* Шаогуань Их Сургуулийн багш, МУБИС-ийн докторант



THE CULTURAL WAY

试论蒙古文字教育的产生与发展

潘文琪*

摘要：蒙古在文字出现之前以狩猎活动为主要教育方式，并通过结草、刻木及语言表达的方式进行信息传递。蒙古文字出现后，开始有了针对于蒙古文字的教育活动，通过两代可汗的努力，蒙古文字教育经历了一个从蒙古的太子诸王到蒙古儿童再到中原地区百姓的教学历程，最终将蒙古文字教育传播到蒙古高原以外的地方。

关键词：狩猎活动；蒙古文字；教育活动；中原地区

引言

蒙古文字产生之前，蒙古人一直以狩猎活动作为基本教育方式，但是在军事活动中通过何种方式传递军事信息需要找到相关史料进行论证。在蒙古文字产生后，蒙古文字教育经历了一个怎样的发展过程？这也需要通过相关的史料记载及前人研究成果进行深入的研究。本文就此类问题进行探讨研究，不当之处，还请教育史学界的同仁们多多批评指正！

一、文字出现之前的蒙古教育状况

成吉思汗在统一蒙古高原之前，蒙古高原上部落林立，各个部落之间征战不休，因此如何去提升战斗力成为每一个部落教育的必备内容。从《元朝秘史》一书中，我们会发现关于成吉思汗统一蒙古高原之前蒙古人的狩猎场景的记载。当成吉思汗战胜克烈部的王汗后，在帖蔑延草原举行了一场狩猎活动，但是这次狩猎活动被汪古部首领阿剌忽失·的吉惕·忽里所派遣的使者月忽难所带来的乃蛮部意图进攻蒙古部的军事情报所中断¹。笔者认为，成吉思汗在战胜克烈部的王汗后，打算举办一次大规模的狩猎活动来训练自己的军队，特别是训练那些在多次战争中俘获敌方的俘虏，同时狩猎活动也能使蒙古人获得充足的食物来应对接下来的战争。

出使蒙古的南宋使者赵珙也记录下了关于蒙古人狩猎活动的重要信息，据《蒙鞑备录》记载：

“鞑人生长鞍马间，人自习战。自春徂冬，旦旦逐猎，乃其生涯。故无步卒，悉是骑军。起兵数十万，略无文书，自元帅至千户、百户、牌子头，传令而行。”²

由此可见，蒙古人是经常进行狩猎活动的，他们通过狩猎活动，不仅可以获得食物和娱乐，还可以从中培养战斗能力，因为可以将一次狩猎活动看作一场战役。赵珙为我们提供了有关蒙古军队的重要信息，他们上级命令下级是通过传令的方式进行的，并非文书。那么，蒙古文字产生之前，蒙古军队除了传令方式之外还有哪些其他的传递军事信息的方式呢？

据《建炎以来朝野杂志》记载：

“鞑鞞亦无文字，每调发兵马，即结草为约，使人传达急于星火，或破木为契，

* [基金项目]2017 年国家社会科学基金重大项目“13-14 世纪波斯文蒙古史史料搜集与研究（17ZDA191）；

2020 年国家社科基金青年项目“大一统视野下的元朝汗位继承问题研究”（20CZS026）；

[作者简介]潘文琪（1993-），女，广东新丰人，蒙古国立教育大学（Mongolian State University of Education）博士研究生，韶关学院教师，主要从事高等教育、蒙古教育史的研究工作。

¹ 乌兰校勘：《元朝秘史》，北京：中华书局，2012 年，第 190-191 页。

² 赵珙：《蒙鞑备录》，载《王国维遗书》第 13 册，上海：上海古籍书店，第 12 页。



上刻数画，各收其半，遇发军以木契合同为验。”³

又据《黑鞑事略》记载：

“霆尝考之，鞑人本无字书，然今之所用，则有三种。行于鞑人本国者，则只用小木，长三四寸，刻之四角，且如差十马则刻十刻，大率只刻其数也。其俗淳而心专，故言语不差，其法说谎者死，故莫敢诈伪。虽无字书，自可立国，此小木即古木契也。”⁴

《长春真人西游记》亦有相关记载：

“俗无文藉，或约之以言，或刻木为契。”⁵

根据上面三段史料的记载可知，在蒙古文字产生之前，蒙古军队除了用传令方式传递军事信息外，还通过结草、刻木及约之以语言的方式来传递军事信息。这些方式只能够用来表达简单的意思，如遇复杂的问题，则需要利用文字书写的文书，但是在当时动荡的社会环境下，蒙古人并没有创制文字的条件，所以这件事情只有等到成吉思汗统一蒙古高原后才得以实现。

二、蒙古文字教育的产生与发展过程

文字的使用是人类进入文明社会的重要标志之一⁶，蒙古文字的出现与征服文化先进的乃蛮部有着密切的关系。据《元史》记载：

“塔塔统阿，畏兀人也。性聪慧，善言论，深通本国文字。乃蛮大斡可汗尊之为傅，掌其金印及钱谷。太祖西征，乃蛮国亡，塔塔统阿怀印逃去，俄就擒。帝诘之曰：‘大斡人民疆土，悉归于我矣，汝负印何之？’对曰：‘臣职也，将以死守，欲求故主授之耳。安敢有他！’帝曰：‘忠孝人也！’问是印何用，对曰：‘出纳钱谷，委任人材，一切事皆用之，以为信验耳。’帝善之，命居左右。是后凡有制旨，始用印章，仍命掌之。帝曰：‘汝深知本国文字乎？’塔塔统阿悉以所蕴对，称旨，遂命教太子诸王以畏兀字书国言。”⁷

从这段史料的记载可以得知，乃蛮部已经任用像塔塔统阿这样博学的畏兀儿学者掌管印章，可见其超高的文化程度⁸。虽然没有明确的史料记载表明乃蛮部已经使用文字，但是从这里可以推测，乃蛮部很有可能已经利用畏兀儿文字来书写重要的文件。这是因为乃蛮部应属于突厥语族⁹，而畏兀儿人亦属于突厥语族，并曾经同突厥人一样使用过突厥文字¹⁰，这样乃蛮人便能够轻松地掌握畏兀儿文；再者印章与文字书写的文件一般来说是配套使用的，所以笔者就此推测，乃蛮部应该使用过畏兀儿文字书写重要的文件。成吉思汗在对塔塔统阿的谈话中深刻地认识到了文字的重要性，因此最后命塔塔统阿教太子诸王利用畏兀儿字母书写蒙古语。这里的太子诸王当指蒙古贵族。可见，起初畏兀儿字母书写的蒙古文字的教育对象是蒙古统治的上层人员，

³ [宋]李心传撰，徐规点校：《建炎以来朝野杂志》乙集 19，北京：中华书局，2006 年。

⁴ [宋]彭大雅撰，徐霆疏：《黑鞑事略》，载《王国维遗书》第 13 册，上海：上海古籍书店，第 8-9 页。

⁵ [金]李志常：《长春真人西游记》，载《王国维遗书》卷上，上海：上海古籍书店，第 19 页。

⁶ 冯天瑜、杨华、任放编著：《中国古代文化史》，北京：高等教育出版社，2020 年，第 56 页。

⁷ [明]宋濂：《元史》卷 124《塔塔统阿传》，北京：中华书局，2011 年，第 3048 页。

⁸ [日]小林高四郎著，阿奇尔译：《成吉思汗》，呼和浩特：内蒙古人民出版社，1982 年，第 74 页。

⁹ 韩儒林主编：《元朝史》上册，北京：人民出版社，2008 年，第 29 页。

¹⁰ 林幹、高自厚：《回纥史》，呼和浩特：内蒙古人民出版社，1994 年，第 70 页。



THE CULTURAL WAY

并未对蒙古民众展开蒙古文字教育。

成吉思汗统治时期，蒙古贵族受教于畏兀儿人的事例亦见于其他史料的记载。据《元史》记载：

“哈刺亦哈赤北鲁，畏兀人也。性聪敏，习事。国王月仙帖木儿亦都护闻其名，自唆里迷国徵为断事官。月仙帖木儿卒，子八儿出阿儿忒亦都护年幼，西辽主鞠儿可汗遣使据其国，且召哈刺亦哈赤北鲁，至则以为诸子师。八儿出阿儿忒闻太祖明圣，乃杀西辽使，更遣阿怜帖木儿都督等四人使西辽。阿怜帖木儿都督者，哈刺亦哈赤北鲁婿也。具语以其故，于是与其子月朶失野讷驰归太祖，一见大悦，即令诸皇子受学焉。”¹¹

这段史料记载了一个博学的畏兀儿人哈刺亦哈赤北鲁，畏兀儿的亦都护曾经请他作断事官，西辽的鞠儿可汗请他教自己的儿子们，最后成吉思汗亦请他去教诸皇子，可见哈刺亦哈赤北鲁十分博学。哈刺亦哈赤北鲁曾经先后担任西辽和大蒙古国皇子的老师，这里便出现了一个问题：哈刺亦哈赤北鲁使用何种语言对这些皇子进行教育活动呢？根据亦邻真教授的《中国北方民族与蒙古族族源》一文可知，鲜卑人、室韦人、契丹人的语言是一脉相承的，而这些语言属于蒙古语¹²。因此哈刺亦哈赤北鲁很有可能利用蒙古语教授西辽和大蒙古国的诸皇子。同时也可以看出，蒙古人最初是向比自己文化先进的畏兀儿人学习的¹³。

随着蒙古文字的日趋成熟，成吉思汗也下令普及蒙古文字教育。据《世界征服者史》记载：

“因为鞑靼人没有自己的文字，他（成吉思汗——引者）便下令蒙古儿童习写畏吾文，并把有关的札撒和律令记在卷秩上。”¹⁴

这段史料是著名的波斯历史学家志费尼所作，由于他并非蒙古人或畏兀儿人，因此他必然分不清畏兀儿文字与畏兀儿字母书写的蒙古文字之间的区别，所以才误认为蒙古人使用畏兀儿文字记载自己的札撒。不过这段史料记载可以充分地证明，在成吉思汗统治时期，利用畏兀儿字母书写的蒙古文字在教给蒙古的太子诸王后，又教给蒙古的儿童。而学习蒙古文字的目的是用来书写蒙古人自己的法律——札撒。可见，利用畏兀儿字母书写的蒙古文字已经初步成熟，可以向蒙古民众推广，使他们普遍接受自己民族的文字教育。

到了窝阔台统治时期，蒙古文字教育开始向蒙古以外的其他民族推广。据《黑鞑事略》记载：

“燕京市学，多教回回字及鞑人译语。才会译语，便做通事，便随鞑人行，打恣作威福，讨得撒花，讨得物事吃。契丹、女真元自有字，皆不用。”¹⁵

¹¹ [明]宋濂：《元史》卷124《哈刺亦哈赤北鲁传》，第3046页。

¹² 亦邻真：《中国北方民族与蒙古族族源》，载《般若至宝——亦邻真教授学术论文集》，上海：上海古籍出版社，2019年，第107页。

¹³ [俄]巴托尔德著，张锡彤、张广达译：《蒙古入侵时期的突厥斯坦》，上海：上海古籍出版社，2019年，第440页。

¹⁴ [伊朗]志费尼著，何高济译，翁独健校订：《世界征服者史》上册，呼和浩特：内蒙古人民出版社，1981年，第28页。

¹⁵ [宋]彭大雅撰，徐霆疏：《黑鞑事略》，载《王国维遗书》第13册，第9页。



THE CULTURAL WAY

赵珙在成吉思汗时期出使蒙古之时应该未见过蒙古文字，他甚至猜测，蒙古并无文书¹⁶，因此当时蒙古语与蒙古文字可能并未广泛流传于蒙古高原以外的地方。但是徐霆出使蒙古之时，情况已经大不相同了。徐霆于 1235-1236 年出使蒙古，此时金朝刚刚被蒙古与南宋联合灭掉，蒙古成为中原地区的统治者，因此蒙古语与蒙古文字在中原地区的地位急剧上升，这就激发了中原地区的百姓学习蒙古语的热情，而蒙古统治者为了培养蒙古语与蒙古文字翻译所急需的人才，因此加大了对中原地区蒙古语与蒙古文字教育的力度，大办学校教授蒙古语及蒙古文字。学会蒙古语与蒙古文字后，便可以作通事即翻译，可以跟着蒙古人作威作福了。其中出现了“撒花”一词，这个词来源于波斯文 *سوغات* 或者 *سوقات*，其含义为“赠品、礼品、礼物”¹⁷。叶子奇在《草木子》一书中对于“撒花钱”的解释是“无事白要”¹⁸。这种解释与上述史料中记载的“讨得撒花，讨得物事吃”一句含义相符。

结语

蒙古文字出现之前，蒙古人通过狩猎的方式来完成他们的军事教育，狩猎是一个有利于培养蒙古勇士的教育方法，适应了当时战争频繁发生的现实状况。如果在军事上出现军事信息传递的问题，可以通过传令、结草、刻木及约之以语言的表达方式将军事信息传递出去。在成吉思汗统一蒙古高原后，结束了蒙古高原上的战乱局面，蒙古民族共同体开始形成，因此拥有自己本民族的文字显得格外重要，特别是对于成吉思汗大札撒的记录。在遇到畏兀儿学者塔塔统阿后，成吉思汗命令塔塔统阿利用畏兀儿字母拼读蒙古文字并教给太子诸王，然后再教给蒙古的儿童，使得蒙古文字在蒙古高原上得以广泛流传。到了窝阔台统治时期，金朝被大蒙古国与南宋联合灭掉，蒙古人取得了中原地区的统治权，因此蒙古语与蒙古文字在中原地区流行起来，为了培养急需的翻译人才，蒙古人在燕京地区办了许多学校，专门教授中原地区的百姓学习蒙古语与蒙古文字。中原百姓学习蒙古语与蒙古文字后，可以作通事，跟着蒙古人作威作福，取得额外的金钱和免费的饮食。可见蒙古文字的出现有利于蒙古文化向蒙古高原之外的地区传播，巩固了蒙古民族共同体，提升了蒙古文化的影响力。

¹⁶赵珙：《蒙鞑备录》，载《王国维遗书》第13册，上海：上海古籍书店，第12页。

¹⁷北京大学东方语言文学系波斯语教研室编《波斯语汉语词典》北京：商务印书馆，2012年，第1404页。

¹⁸[明]叶子奇：《草木子》卷4下《杂俎篇》，北京：中华书局，1997年，第82页。



ABSTRACT

Before the emergence of writing in Mongolia, hunting activities were used as the main way of education, and information was transmitted by means of grass making, wood carving and language expression. After the emergence of Mongolian characters, there began to be educational activities aimed at Mongolian characters. Through the efforts of two generations of Khans, Mongolian characters education experienced a teaching process from the crown princes of Mongolia to Mongolian children and then to the common people in the Central Plains, and finally spread Mongolian characters education to places outside Mongolian Plateau.

Key words: Hunting activities; Mongolian characters; Educational activities; Central China Region

НОМ ЗҮЙ

1. 乌兰校勘：《元朝秘史》，北京：中华书局，2012
2. 赵珙：《蒙鞑备录》，载《王国维遗书》第13册，上海：上海古籍书店
3. [宋]李心传撰，徐规点校：《建炎以来朝野杂志》乙集19，北京：中华书局，2006
4. [金]李志常：《长春真人西游记》，载《王国维遗书》卷上，上海：上海古籍书店
5. 冯天瑜、杨华、任放编著：《中国古代文化史》，北京：高等教育出版社，2020
6. [明]宋濂：《元史》卷124《塔塔统阿传》，北京：中华书局，2011
7. [日]小林高四郎著，阿奇尔译：《成吉思汗》，呼和浩特：内蒙古人民出版社，1982
8. 韩儒林主编：《元朝史》上册，北京：人民出版社，2008
9. 林幹、高自厚：《回纥史》，呼和浩特：内蒙古人民出版社，1994
10. 亦邻真：《中国北方民族与蒙古族族源》，载《般若至宝——亦邻真教授学术论文集》，上海：上海古籍出版社，2019
11. [俄]巴托尔德著，张锡彤、张广达译：《蒙古入侵时期的突厥斯坦》，上海：上海古籍出版社，2019
12. [伊朗]志费尼著，何高济译，翁独健校订：《世界征服者史》上册，呼和浩特：内蒙古人民出版社，1981
13. 北京大学东方语言文学系波斯语教研室编：《波斯语汉语词典》，北京：商务印书馆，2012
14. [明]叶子奇：《草木子》卷4下《杂俎篇》，北京：中华书局，1997

Тус өгүүлэл нь 2017 оны Үндэсний Нийгмийн Шинжлэх Ухааны “13-14-р зууны Перс, Монголын түүхийн материалыг цуглуулж, судлах нь” (17ZDA191), 2020 оны Үндэсний Нийгмийн Шинжлэх Ухааны Залуучууд зориулсан “Юань гүрний үеийн хааны залгамж үеийн судалгааг их нэгдлийн үүднээс судлах” (20CZS026) зэрэг сангийн төслийн ажлын хүрээнд бичигдсэн болно.

ХОРЧИН ЗҮҮН ГАРЫН ХОЙД ХОШУУНЫ ГАЗРЫН НЭРИЙН ДОМГИЙН ҮҮСЭЛ

Оюунтоль*

ХУРААНГУЙ

Хүмүүс түүхэнд суурилан өөрийн оршин амьдарч байгаа газар орноо нэрлэх дадалтай байдаг, он цаг өнгөрөхөд, эдгээр газрын нэр нь үлгэр домгийн хэлбэрээр тухайн газрын хүн ардын өдөр тутмын амьдрал дунд шингэгдэн, үе дамжин уламжлагддаг. Хорчин зүүн гарын хойд хошууны газрын нэрийн үүслийн домог ярианд, түүхэн хүн ба түүхэн хэрэг явдлаас үүсэлтэй домог яриа маш олон, түүхэн хүмүүсийн дотор Сэнгэринчин чин ван, манж чингийн хаад ба шарын шашны хамаарал бүхий хүмүүсээс үүсэлтэй домог хууч ихээхэн байр суурь эзэлнэ. Түүхэн хэрэг явдлаас, ихэнх домог нь шарын шашин хийгээд бөө мөргөлийн шашны хоорондох маргалдаан жич чин улсын сүүл үеэс нааш ард түмний эсэргүүцлийн ажиллагаанаас эхлэлтэй юм. Эдгээр газрын нэрийн үүсэл домгийн эх сурвалжийг бүрэн судалж болох мөртөө түүхийн үнэнтэй нийцэж байдаг. Хүн төрөлхтний бодгаль шинж ба цаг үеийн адилгүй байдлаас эдгээр хүн, үйл явдалд адил бус хүн адил бус хэмжээ эзэлнэ.

Түлхүүр үгс: *Хорчин зүүн гарын хойд хошуу, газрын нэрийн үүсэл, домог яриа*

Домог яриа бол ямар нэг түүхэн хүн, хэрэг, эсвэл ямар нэгэн үнэн юм бодит зүйл буюу ямар нэгэн зан үйл заншил дадлаас эш авч, уран санаанаас ургуулан зохиосон бөгөөд үе улиран ард олны дунд уламжлан яригддаг богино үлгэрийг хэлнэ¹. Домог яриа нь ердөө түүхэн хүн, түүхэн үйл явдал, байгалийн үзэгдэл ба өвөрмөц зан заншлаас үүсэлтэй байдаг. Хорчин зүүн гарын хойд хошууны газрын нэрийн үүслийн домог яриаг үзвэл ихэнх нь түүхэн хүн ба түүхэн үйл явдлаас гаралтай байна. Хэдийгээр домог яриа нь үнэн түүхтэй адилтгавал үнэмшүүлэх хүч сул боловч, тэр нь ямар нэгэн тогтсон цаг орны тогтсон хүн ардын ямар нэгэн үзэгдэлд хандсан хэлбэр байдлыг нь тэр хэвээр нь харуулж чадна.

* ӨМИС, Монгол Судлалын Дээд Сургууль, Харьцуулсан утга зохиол ба дэлхийн утга зохиол судлалын магистрант

¹ Мандах. Ардын аман зохиолын онол. ЛяҮнХХ



THE CULTURAL WAY

Нэг. Түүхэн хүнээс үүсэл гаралтай

Хорчин зүүн гарын хойд хошууны газрын нэрийн үүслийн домог ярианд Сэнгэринчин, Энх-Амгалан хаан, шарын шашинтай холбогдол бүхий хүмүүсээс үүсэлтэй нь дийлэнх хэсгийг эзэлнэ.

Хорчин зүүн гарын хойд хошууны түүхт хүн Сэнгэринчин бол боржгин овогтон, Хавт Хасарын хорин зургадугаар үеийн хойчис, Чин улсын Төр гэрэлт, Түгээмэл элбэг, Бүрэн засагт хааны үеийн монгол Ван Е, хорчин зүүн гарын хойд хошууны аравдугаар үеийн засагт Жүн ван болно. Сэнгэринчин 1825 онд хорчин зүүн гарын хойд хошууны жүн ван Содномтовзуйн суурийг залгамжлан жүн ван болжээ. Түүхнээ бодлогот Чин ван гэдэг.

Хорчины хамаарал бүхий соёл урлагийн бүтээгдэхүүнд чин ван Сэнгэринчиний тухай өгүүлсэн зүйл олонтоо тохиолдоно. Жишээлбэл, хол ойрдоо алдартай хорчин ардын үлгэрт дуу “Сэн вангийн дуу” тус дуу нь хорчин нутагт хэдэн зүйлийн хувилбараар байх мөртөө Ордост бас нэг хувилбар байдаг. Хорчин зүүн гарын хойд хошууны газрын нэрийн үүслийн домог ярианд Сэн ванд хамаатай нь “Буо вангийн хошууны домог” ба “Ганзагын домог” болно. Доор “Буо вангийн хошууны домог”-ийг үзвэл²:

Сайшаал ерөөлтийн зургадугаар онд Шарууд, Марууд, Агажууд, Гонгууд, Онгууд, Халдууд, Байрад, Ойгууд зэрэг найман тайжийн суусан говийн өмнөх монгол нутаг (одоогийн хорчин зүүн гарын хойд хошуу)-т тэнгэрийн хур тэгш бууж, дөрвөн улиралд гамшиггүй, ард иргэд энх амгалан өвчин зовлонгүй байжээ. Таван тариа дэлбэг түрж таван хошуу мал өнөр өсөж, цаг тэгширч самуун арилаад, хоттой малыг хөөх дээрэмчингүй, хөмрөгтэй малыг хөдөлгөх хулгайчгүй болжээ. Нэгэн өдөр, тэнгэрийн нар гурав мандаж үд болтол гэрэлтээд түгдгэр тайж Бэхигийн гэрт нэг хүйстэн нэмэгджээ. Энэ хүүгийн царай дөрвөлжин, чих нь аманд нь тулжээ. Уйлах дуу хэнгэрэг дэлдэх мэт хүнгэнэм яруу. Нүд усан болор мэт гэрэлтэй, хөмсөг нь хүр хэвтсэн мэт өргөн, хамар босоо, ам том. Эхийн хэвлийгээс унаж ирмэгц хатганатал инээж бүх гэрийн хүмүүсийг цочоосноор барахгүй өвч биеэс нь улаан гэрэл цацарч гэрийн оройг нэвтэлжээ. Бэхи өвгөн сандрахдаа муу сайн эсгий ширдгээр дарсан боловч гэрлийн хүчийг бууруулж чадсангүй. Энэхүү чимээ нэгээс арав, арваас зууд дамжсаар Бэхи өвгөний хөвгүүнд Гэрэлт гэдэг нэр шингээжээ. Бэхи өвгөний төрлийн дүү Содномтовзуй Сайшаал ерөөлтийн онд хорчин жүн ван сууж байсан бөгөөд хааны шадар сайд, хүргэн нь байжээ. Содномтовзуйгаас хүүхэд төрөөгүй тул хаан зарлиг буулгаж төрөл угсаанаасаа нэгийг сонгож

² Б.Насан нар. Жиримийн газрын нэрийн домог. ӨМСХХ., 2010



THE CULTURAL WAY

үндэс залга гэжээ. Содномтовзуй хааны зарлигийг хүлээгээд төрлийн ах Бэхигийн хоёрдугаар хүү Гэрэлтийг сонгож гүйцээд сүүлээр нь Төр гэрэлт хаанаас нэр гуйжээ. Хаан эзэн өршөөж Содномтовзуйн тэжээсэн хүү Гэрэлтэд Сэнгэринчин гэдэг сайхан нэр хайрлажээ. Төр гэрэлтийн тавдугаар оны долоон сард Содномтовзуй нас барсанд хаан зарлиг буулгаж Сэнгэринчинд вангийн суурийг залгамжлуулсан бөгөөд хошууны нэрийг Сэнгэринчиний бодлогот чин ванг дагуулж Буо ван хошуу гэж нэрлэжээ.

Дээрх домог яриан түүхэн сурвалжийг үзвэл:

Син Ичэнь-ий зохиосон “Сэнгэринчин” хэмээх бүтээлд “Сэнгэринчин боржгин овогтой, Сайшаал ерөөлтийн арван зургадугаар он (НТ 1811)-д төрөв. Үеийн үедээ Өвөр монголын Жирим аймгийн хорчин зүүн гарын хойд хошуу орчим нутаглаж байжээ. Эцэг нь Бижи гэдэг, дөрөвдүгээр дэсийн тайж, язгууртанд тооцогдоно. Ах дүү тавуулаас Сэнгэринчин хоёрдугаар нь болно. Бага наснаас нэгэн авгаа дагаж Цандын сүмд бичиг үзжээ. Энэ үед гэнэтийн тохиолоор хувь заяаг нь шийдвэрлэсэнээс хишиг буян нэмэгдэж хаан угсаа нь ээнэгшиж гурван үеэр сүр бадруулсан дотно харьяат шадар сайд болсон юм. Сэнгэринчиний төрлийн авга Содномтовзуй нь хорчин жүн ван суусан бөгөөд Сайшаал ерөөлт хааны эфү (хүргэн) дээрээ хааны шадар сайд байв. Хожим (гүнжээс нь үр гарсангүй) хуримлаад удтал хүүхэдгүй болохоор Төр гэрэлт хаан зарлиг буулгаж Содномтовзуйг төрөл угсаанаасаа хүүхэд сонгож үндэс залга хэмээсэнд Сэнгэринчинийг үзвээс, зүс байдал ер бус тул Содномтовзуйн голомт залгагч хорчиний засаг төрийн жүн вангийн суурины залгамжлагчаар тогтоов. Төр гэрэлтийн тавдугаар (1825) оны долоон сард Содномтовзуйн зуурмаг эцэслээд, арван нэгэн сард нь Сэнгэринчин вангийн сууринд залраад шинэ амьдралаа эхэлсэн байна”³.

Сэнгэринчийн төрсөн он тодорхой байна. Дээр дурдсан 1811 он бол нөхөр Э.Хишигтийн “Сэнгэринчиний тухай туршин өгүүлэх нь” (ӨМҮБДСЭШС, монгол хэвлэл 1984.1) гэдэг өгүүллээс эш татжээ. Харин Хүрэлша, Сэргэлэн “Хорчин ардын дууны баатрын домог намтар” гэх номд Сэнгэринчинг Сайшаал ерөөлтийн 15 дугаар (1810) оны 6 сарын шинийн 5-нд төржээ хэмээн бичив. Сэнгэринчиний вангийн сууринд суусан он сар нь ч тус бүтээлд Төр гэрэлтийн тавдугаар оны 10 сарын 25-ны өдөр (1825.12.04) гэж бичжээ. Хэдийгээр Сэнгэринчиний төрсөн он сар өдрийн тухай, вангийн сууринд суусан өдөр хугацааны тухай адил бус материалд адил бусаар тэмдэглэх боловч, дээрх “Буо вангийн хошууны домог”-т гардаг Сэнгэринчиний Бэхи өвгөний хоёрдугаар хөвгүүн нь болж заяасан,

³ Син Ичэнь. Сэнгэринчин. ӨМАХХ., 2017



THE CULTURAL WAY

Содномтовзуйд үрчлэгдсэн жич вангийн сууринд суусан нь түүхэн үнэнд нийцнэ.

Домог яриа нь түүхэн, үнэмшүүлэх шинжтэй мөртөө бас шидэт чанартай байх хэрэгтэй. Яг иймээс дээрх домог яриан дахь Сэнгэринчиний төрсөн нутаг ба дүр нь шидэт шинжтэй байдаг. Түүний төрсөн нутаг нь “Тэнгэрийн хур тэгш бууж, дөрвөн улиралд гамшиггүй. Ард иргэд энх амгалан өвчин тахалгүй. Таван тариа элбэг дэлбэг ургаж таван хошуу мал өнөр өсөж, цаг тэгширч самуун арилаад, хоттой малыг хөнөөх дээрэмчингүй, хөмрөгтэй малыг хөдөлгөх хулгайчгүй” баян тансаг, амгалан жаргалангийн орон болно. Мөн Сэнгэринчиний дүр төрхийн тухай “Энэ хүүгийн царай дөрвөлжин, чих нь аманд нь тулжээ. Уйлах дуу хэнгэрэг дэлдэх мэт хүнгэнэм яруу. Нүд усан болор мэт гэрэлтэй, хөмсөг нь хүр хэвтсэн мэт өргөн, хамар босоо, ам том. Эхийн хэвлийгээс унаж ирмэгц хатганатал инээж бүх гэрийн хүмүүсийг цочоосноор барахгүй өвч биеэс нь улаан гэрэл цацарч гэрийн оройг нэвтэлжээ. Бэхи өвгөн сандрахдаа муу сайн эсгий ширдгээр дарсан боловч гэрлийн хүчийг бууруулж чадсангүй” гэж дүрсэлжээ. Энэ нь бодит амьдралд үнэнд нийцэхгүй зүйл болно. Харин домог ярианд ингэж өгүүлсэн нь тухайн хорчинуудын нэгэн баатар чадалтан гарч тэднийг дагуулан зол жаргалт амьдрал эдлүүлэхийг хүсэн эрмэлзэж байгаа байдлыг харуулна. “Ганзагын домог”-оос үзвэл:

XVIII зууны дунд үеэр Буо ван хошууны Шонхорын сүм нь ойр орчиндоо нэр цуутай том сүм байжээ. Энэ сүм ном судар нь шалгарсан эрдэм сайтай Бөхтөмөр гэх цогчин лам байж, мөн цогчин лам гэж алдаршжээ. Нэгэн удаа шонхорын сүмийн их хурал дээр энэ шогчин шог гаргаж байгаад Буо ванд анзаарагдаж, вангийн ордонд шог баригчаар залагджээ. Тэгээд Бөхтөмөр лам вангийн ордны шогчин болж, ванг үргэлж баясгадаг шадар гоцог болжээ. Хожим нь ванд тусгайлан бичиг заах болов. Бөхтөмөр лам энэхүү ашигтай нөхцлийг завшиж өөрийн том ах Бөхдэлгэрийг Буо ван хошууны цэргийн туслагч түшмэл болгожээ. Энэ туслагч нас яваад том хүү Түвэг Гэрэлтдээ тушаалаа шилжүүлж өгөөд ах дүү дөрвүүлээ вангийн өршөөлийг олж, одоогийн Ганзага балгасны зүүн өмнө таван газарт байгаа нэгэн саруул уудам тал газар нүүдэллэн ирж суугаад, айл гэрийн нэрээ “Дэлгэрэх дөрвөн гэр” гэж нэрлэжээ. Хэдэн жилийн дараа, хорчин нутагт хур бороо тэгш бууж, таван хошуу мал өнөр өсөж, таван тариа нь элбэг ургасны дээр Бээжингийн Юн Хөгүн-д зул өргөх ламыг ээлжлэх хугацаа тулсан тул Буо ван ноён, багшаа Юн Хөгүн-д залахаар буулгажээ.

Ван өөрийн биеэр мордож багшаа залахаар очсон тул Бөхтөмөр лам ах дүү дөрвүүлээ үр хүүхдээ дагуулаад гэрээсээ зүүнш 10 газрын үзүүрт очиж хадаг татаж тосон авчээ. Ингээд энэхүү газар нь Хадагтын тал гэж нэрлэгдээд



THE CULTURAL WAY

яваандаа одоогийн Ганзага балгасны Хатуутал гацаа болно. Буо ван ноён биеэрээ дэлгэрэх дөрвөн гэрт очсоны дараа, Бөхтөмөр лам ойр орчны шогчид, дуучид, бүжигчид, сурчид, бөхчүүд, морьтдыг залж гурван өдрийн их найр наадам хийж үхэр хонь алж, ванг баясгасан бөгөөд гэртээ нэр гуйжээ. Ван ноён энэ удаа гарч ирээд зам зуураа ав шувуу тавиад алж ганзагалсан нэн их баярлаад багшдаа ихэд хүндлэгдсэн баярыг хослуулан сэтгэл нь хөдөлж: “Танай дөрвөн гэр эмээлийн дөрвөн ганзага мэт өнө үүрд миний хажууд байтугай” хэмээн зарлиг буулган, Ганзага гэж нэр хайрлажээ. Түүнээс хойш дэлгэрэх дөрвөн гэр нэрээ Ганзага гэж өөрчлөв.

Дээрх домог ярианаас Сэнгэринчин бол эрдэм номыг хүндэтгэж, багш ахмадаа хүндэтгэдэг, ард иргэнийхээ хүрээллийг олсон сайн ван гэдгийг мэдэж болно. Сэнгэринчиний нэг насандаа хийсэн хамгийн нөлөө их явдал нь гэвэл: “1 дүгээрт, Түгээмэл элбэгтийн гуравдугаар оны найман сард Тай Пин Тянь Гуо-ийн умарш дайлах цэргийг дарангуйлсан. Хоёрдугаарт, 1859 оны 6 сард англи францын түрэмгий цэргийг эсэргүүцэн цохиж, 1840 оны хар тамхины дайнаас наашхи хамгийн эхний ялалтыг олж, түүхнээ “Хоёрдугаар удаагийн Да Гү Коу-ийн байлдаан” гэнэ. Гуравдугаарт, Чингийн цэргийг дайчлан Няньюнь-тэй тулалдсан, мөн энэ удаагийн тулалдаанд Сэнгэринчин нас барсан байна. Хол ойрдоо алдартай “Сэн вангийн дуу” нь Сэнгэринчинийг нас барсны дараа түүнийг дурсахын тулд зохиогдсон байна.

Тус дуунд Сэнгэринчинийг “ноёдын түрүү, ачит богд, бат чигч, гавьяа зүтгэл үлэмж их, бодлого бүрэн, төрийн тулгуур” зэрэг үгсээр магтан дуулсан байна. Үүнээс мэдэх нь хорчинуудын ойлголтод Сэнгэринчин бол ард түмэндээ буян үйлдэж, ард түмнийхээ хүндэтгэл бишрэлийг олсон улс гэртээ ачтай ван ноён болох юм.

Гэтэл бас Сэн ванд назгай байдлаар хандаж байгаа түүх домог ч илхэн харагдана. Шонхорын уулын домогт гардаг Сэн ван бол “ховдог шунахай хошуу ван”, “тагцхүү үеийн үедээ уламжлах засгийн эрхээ хамгаалж чаддаг л юм бол хэдий чинээ хүч зарцуулсан ч хамаагүй” гэж нутгаас нь өөр баатар шидтэн гарахаас сэргийлж, хар алба татан, Шонхорын сүмийн байгуулж, нутаг усны навдаг савдагаа (лус савдаг) дарсан ховдог шунахай хошууны ван болно. Бас хуучин хийдийн талын домогт, ламын хувилгааныг үзсэн Буо ван юуг нь мэдэхгүй “мэнтүүрч” огтон гарчээ. Хууч яриан дахь Сэн вангийн багын үеийн худагт унасан ба аавтайгаа хамт эмнэг үнээг сургасан домог яриаг үндэслэвэл, Сэн ван ламын хувилгааныг үзээд “мэнтүүрч” ёс үгүй, ингэж бичсэний шалтгаан нь гэвэл ламын хүч чадал их гэдгийг товойлгох, гэвч нөгөө талаар Сэн вангийн эгэл жирийн шинжийг бас тусгасан байна.



THE CULTURAL WAY

Дээрх жишээнүүдээс мэдэх нь, Сэнгэринчин чин улсын сүүлч үеийн гавьяат түшмэл болсны хувьд бүх улсын ард түмний магтаал сайшаал, хүндэтгэл бишрэлийг хүртсэн байна. Түүний эрэлхэг баатарлаг нэг наснаас болоод хорчин зүүн гарын хойд хошуу “Буо вангийн хошуу” гэж хол ойрдоо алдаршжээ. Ихэнх хүнд авч хэлбэл тэр бол гадаадын түрэмгийлэл дотоодын самуурлыг дарсан үндэстний баатар, нутаг усныхаа нэр сүрийг өргөсөн дурсгалт хошуу ван, яг иймээс одоо хойд хошуунд Сэн вангийн нэр, зэрэг тушаалаар нэрлэсэн зам, зээл гудамж олон байдаг, хошууны төв болох гацаанд тусгайлан Буо вангийн музей байдаг. Гэтэл хүнд бүрэн хүн үгүй. Тухайн үеийн бодлоготой цаг төрийн байдал жич хувь хүний өвөрмөц чанараас болоод Сэнгэринчинд назгай байдлаар хандах хүмүүс олон байна.

Энх-Амгалан хаан, хаан сууринд сууж байх хугацаандаа гурван удаа доор бууж ардын амьдралыг шалгасан түүхтэй. Энэ явцдаа говийн өмнөх монгол оронд ч ирсэн байна. Иймээс хорчины ардын аман зохиолд Энх-Амгалан хаантай холбоотой үлгэр домог олон байдаг. Хойд хошууны Энх-Амгалан хаантай холбогдох газрын нэрийн гарлын домог яриа “Талдач айлын домог”, “Бодын айлын домог яриа”, “Алаг морины домог яриа”, “Бөгтөр модны домог яриа”-г авч үзвэл:

Эрт урьд цагт эр хүн орой дээрээ гөрмөл гээгтэй байсан үед, Энх-Амгалан хаан төрийг эзэлж түмнийг захираад, хорчин монголчуудын амьдрал дадлыг ойлгож, эрхшээлдээ оруулж, ноёрхлын сууриа бататгахаар илжиг унаж энгийн хүн шиг явж гэнэ. Хаан эзэн явсаар нэгэн өдөр одоогийн хорчин зүүн гарын хойд хошууны Шартал сумын нутагт хүрчээ. Энэ нутаг эхэндээ мод шугуй олон, бэрх бартаа ихтэй байжээ. Хаан нэгэн суурь модон доор хоножээ. Шөнө нь шарнууд чоно ирээд хааны унаж байсан эр саарал илжгийг нь бариад идчихжээ. Ингээд хаан ихэд уурлаж, дагаж явсан шадар гоцгоо зарлигдаж “энэ нэг сууриас бодоос ондоог нь бүр галдаж, шарнууд чоныг үүрээр нь устга” гэжээ. Ингээд энэ газрыг галдсанаас өмнө хойно хоёр айл гарч урд хойд галдач гэж нэрлэжээ. Шатагдсан шороо хийсэн овоорсоор манх болж, урд хойд галдачийн айлыг элс манхаар хүрээлж, энэ газрын чоныг бүгдийг нь устгажээ. Хааны хоносон бодын орчинд айл гарч, айлын нэрээ бодын айл гэж нэрлэв. Хааны унасан илжгийг чоно барьж идсэн тул хаан явган болжээ. Хаан эзэн нэг өдөр яван явсаар уудам саруул нэг талд орж гэнэ. Талын дунд нэгэн сүрэг адуу байв. Адуучин өвгөн энэ хэдэн явган хүнийг үзээд өрөвдөж хүн бүрт нэг морь өгч унуулжээ. Хаан эзний унасан морь нь алаг өнгөтэй гэнэ. Ингээд хаан эзэн үүлэн алаг морийг олсон газарт ийнхүү зарлиг буулгав: Хорчин монголчууд бүгд шулуун, элэгсэг даруу сэтгэл сайтай, хотол олонд тусламж үзүүлэн, ховдог санаа үл өвөрлөмүй, хойд өдөр хожмын цагт, хурдан хүлгийг эндээс сонгоё,



THE CULTURAL WAY

хорчин монголчуудын хойч үед, цэргийн ван гарах болтугай гэж хэлээд хаан эзэн энэ газар алаг морин тал гэж нэр хайрлажээ. Сүүлээр нь энэхүү газар айл гарч алаг морь гэж нэрлэв. Одоо алаг морь гацаа гэж дуудаж байна. Нэгэн бүгчим халуун өдөр хаан эзэн алаг морио унаад явсаар гал тавьсан газарт хүрч ирээд нэг суурь шатаж харласан модны дэргэд очиж сүүдэрт нь суухад, нарны гэрлийг халхлаж болох навч нахиагүй тул сэрүүцэхийн аргагүй. Энэ эзний бие модыг хуруугаараа зааж “нов ногоон навч нахиатай болвол сүүдэр их биш үү” гэж хэлэхэд, тэр шатаж харласан мод үнэхээр нов ногоон навч нахиатай болжээ. Морио уях газаргүй тул хаан мөн ч энэ модыг хуруугаараа зааж “вэш, энэ мод бага бөгтөр болсон бол бид морио уях газартай болно” гэхэд мод үнэхээр бөгтөр болжээ. Хаан эзэн галдаж шатсан газартаа нэг өдөр үйл там үзээд дотроо маш эвгүйрхэж гутрахын дагуу нэг атга шороо авч дөрвөн зүг найман зовхист цацаж: “нов ногоон өвс бэлчээр болтугай” гэжээ. Тэгээд хааны цацсан шороо бүхэнд нийтээр ногоон өвс ургах болов. Хожим нь хаан эзний амарсан модны орчин айл гарч, айлын нэрээ “бөгтөр мод” гэж нэрлэжээ.

Энх-Амгалан хаан бол чингийн төрийн дөрөвдүгээр хаан болно. Манж боомтод орохоос өмнө манж болон монгол хамтран ажиллах харьцаа байжээ. Харин хаан эзний үе болоход ноёрхогч ба ноёрхогдогчийн харьцаатай болсон байна. Үүнээс болж хоёр үндэстний хооронд зөрчил орших нь дамжиггүй. Яг иймээс монгол ардын аман зохиолд илэрсэн хаан эзэнд хандаж байгаа байдал нь бүрмөсөн манж жич чин гүрэнд хандаж байгаа байдлыг тусгана. Дээрх домог ярианаас үзвэл, Энх-Амгалан хаан “төрийг эзэлж түмнийг захираад, хорчин монголчуудын амьдрал дадлыг ойлгож, эрхшээлдээ оруулж, ноёрхлын сууриа бататгахаар илжиг унаж энгийн хүнээр жишиж явж, мөн морио чононл бариулсанд тухайн газрын хүн морь өгч унуулжээ, хааны шороо цацсан газар бас ховхой манх байснаасаа нов ногоон тал болжээ. Энэ нь хорчинчууд хаан эзний засаг, мөн чингийн засгийг нэлээд хүрээлж байгааг тусгана. Гэтэл домог ярианд бас хааны унасан илжиг нь чононд баригдчихжээ. Энэ нь ар хорчины “хахир голын домог яриа”-тай их төстэй байдаг. Бас хаан сэрүүцье гэсэнд таарсан мод нь навч нахиагүй сэрүүцэхийн аргагүй. Эдгээр нь цөм хорчинчуудын бусдын засаг ноёрхолд дургүйцэж байгаа байдлыг харуулна. Гэвч тухайн үеийн цаг төрийн байдлаас шалтгаалж хорчинчууд аргагүй дээрх домог ярианд гардаг “мод” шиг хааны зарлигаар навч нахиа ургаж хааныг сэрүүцүүлэн, бөгтөр болж хааны морийг уяулах чухалтай. Үүнтэй адилавтар ар хорчинд “Энх-Амгалан хаан эцгээ эрсэн домог”⁴-ийг үзвэл:

Энх-Амгалан хаан сууринд суухаас өмнө эцэг хаан нь тамгыг нь аваад явчихсан гэнэ. Хаан эзэн сууринд сууснаас сүүлээр төрийн тамгаа олохоор

⁴ Б.Насан нар. Жиримийн газрын нэрийн домог. ӨМСХХ., 2010



THE CULTURAL WAY

газар бүхэнд эцгээ эрж явав. Эцэг нь зугтааж явахдаа голын хөвөөнд тамгыг нь унагаснаар шавар дээр мөр нь ил тод үлджээ. Хаан эрж явсаар голын хөвөөний шаварт шингэсэн тамганы мөрийг үзээд том лууван дээр сийлүүлж төрдөө хэрэглэсэн гэдэг. Эцэг нь гүнбүм хийдэд хүрч лам болж, бусад лам нартаа: “өнөөгийн төр чинь тамгагүй төр шүү” гэж хэлж байсан гэнэ. Сүүлээр нь хаан гүнбүм хийд хүрээд эцгээ үзээд таньсангүй. Эцэг нь түүнд “эцэг чинь байна уу?” гэсэнд “байна” гэж хариулжээ. Гэхдээ түүнд баглаатай юм гардуулж: “үүнийг эхдээ аваачиж өг” гэв. Хаан гэртээ харьж ирээд эхдээ өнөө баглаатай юмыг өгөхөд эх нь: “тэр хүн чинь эцэг чинь шүү” гэжээ. Хожим эцэг нь төрийн тамгыг тэр хэвээр нь хаанд буцаасан гэнэ.

Энэ домог яриа нь ар хорчинчуудын чингийн засагт тун дургүйцэж байгаа байдал, нэн цаашлаад мэдрэх дургүй байдлыг илэрхийлнэ. Гэтэл цаг төрийн байдлаас заавал чингийн засгийг мэдрэх хэрэгтэй байжээ. Домог яриа нь хүн төрөлхтний оюуны амьдралыг харуулна. Дээрх хэдэн домог ярианаас мэдэх нь, чин улсын үеийн монголчууд хэдийгээр манжийн ноёрхлын доор байсан боловч энэ төр засагт дургүй байжээ. Үүнийг түүхэн үйл явдал ч харуулж чадна.

Хорчины зан үйл соёлд гүн нөлөөлсөн зүйлийн нэг нь шарын шашин болно. “Шарын шашин бол төвөдийн бурхны шашны бүлгийн хамгийн сүүлчийн мандсан том шашны бүлэг болно. Монгол хятадын ердийн дуудлагад ламын шашин гэгцгээдэг”⁵.

1578 онд Цавчаал сүмд их хурал хуралдаж, Алтан хаанаар төлөөлүүлсэн монголын баруун гурван түмний феодал ноён болон Содномжамцаар төлөөлүүлсэн шарын шашны хутагт хувилгаан хамтарч чухал тогтоол гаргасан нь баруун гурван түмэн шарын шашинд орж, монголд сүмийн шашин дэлгэрсний эхлэл болно. Өвөр монголын зүүн орон хорчинд шарын шашин дэлгэрсэн нь 17 дугаар зууны эхэн хагаст баруун орноос ирсэн Нэйж тойн хийгээд Манзушир лам зэрэг лам нараас эхэлсэн байна. Нэйж тойн Банчин гэгээнээс авшиг увдис хүртэж, Банчин гэгээний “чиний эртний ерөөгөр барилдлага дорно зүг мэт байнам” гэснийг дагаж 16 дугаар зууны сүүлч, 17 дугаар зууны эхээр дорно зүгт шарын шашныг дэлгэрүүлж эхэлжээ. Нэйж тойн хорчинд ирсний дараа тэндхийн ван, гүн, бэйл, бэйс, тайж нарыг хамгийн эхэнд шарын шашинд татаж оруулсны дараа, оюун санааны талаар бурхны ёс номлолоор мунхруулах болон аж ахуйн талаар урамшуулан дэмжих аргыг уялдуулан хэрэглэсний үндсэн дээр олон арвин сүм хийдийг байгуулж, бурхан бүтээж ном судар орчуулан, хорчины хүмүүсийг шарын шашинд оруулжээ.

⁵ Хорчин зан үйлийн судлал. ӨМСХХХ., 2003



THE CULTURAL WAY

Иймээс хойд хошууны газрын нэрийн үүсэл домог ярианд шарын шашинтай холбогдол бүхий зүйл олон байдаг. Доор “Хустай айлын домог яриа”⁶ ба “Хайсын айлын домог яриа”⁷-аас үзвэл:

Эрт урьдын цагт хорчин зүүн гарын хойд хошууны Чулуут сумын Хустай гацааны ард нэлгэр их далай мэт нуур манх байжээ. Энэ нь хүрээ хошууны тамын цагаан болон Шонхорын сүмийн арын цагаантай нийлж байв. Энэ манханд өнгөрсөн үед дээрэм тонуул олон байсан гэнэ. Нэгэн удаа, Майдар гэгээн зүүн хойд орны аюул зовлонг арилгах гээд мянган хуврагаа дагуулж бадарчлан явсаар манхны ард хүрч ирээд өлсөж ундаасахын туйл болсон тул шар майхан босгож хоног авчээ. Шөнө дундын үеэр гэнэт тэмээ буйлж морь янцгааж их үймээн болов. Майдар гэгээний мянган хувраг дэн зул асаагаад сандарч байтал хэсэгтэй мөнгө, хэлхээтэй зоос, тэрэгтэй алт, тэмээтэй дурдан нь алдагдаж ор мөргүй болов. Ингээд Майдар гэгээн энэ манхны оройд “Хунхуузтайн цагаан” гэдэг үсэгтэй чулуун хөшөө босгож тавиад бээжинд очиж эзэн зургаан яаманд заалджээ. Хожим нь энэ манхны өмнө энгэрт айл сууж, айлын нэрээ модон айл гэж нэрлэжээ. Гэтэл холын хүмүүс энэ айлыг бүр Хунхуузтайн айл гэж дуудна. Тэгээд энэ модон айлд хунхуузтайн айл гэх нэр нь үлджээ. Хятадаар хунхуузтай гэдгийг бичихдээ нэр ба утгыг нь үндэслэн дөхмийг бодож Ху Сө Тай гэж бичжээ. Хожим хятад дуудлагыг үндэслэн “энэ газар өнгөрсөндөө хус мод олон байсан тул ху сө тай гэж бичжээ” гээд Хунхуузтайн айлын нэрийг Хустай гэж орчуулан бичжээ.

“Хайс айлын домог”-т:

“Эрт цагт, өндөр уулын энгэрт ундрах булгийн ард сэр сэр үлээсэн салхины аманд, саалийн сүү сунайсан саруул талын дунд байгуулсан хувилгаан сүмийн Хожгор лам нэг шөнө унтаж байсаар түмэн айлын дуслыг хуримтлуулж, унаж мөргөсөөр Утайд очиж мөнгөн зулд тос нэмбэл үхэшгүй эрдэнийн шидийг олж, үгүйрэшгүй баян увдисыг бүтээж, өнө үүрд хувилгаан сүмийн да лам сууна гэж зүүдлээд гүйгээд босжээ. Тэгээд хожгор лам энэ зүүдээ бэлгэт зүүд гэж их л баярлаж багш ламаа хайж өтөлсөн эхээ үзэх нэрээр чөлөө гуйгаад сүмээс салж араг үүрч түмэн айлыг дуслыг гуйн явж гэнэ. Хожгор лам арагны дотор нэгэн жижиг тогоо хийж үүрээд нар гарвал зам хөөж, сар гарвал хоноглож ардыг зовоохгүй буян үйлдэж явсаар одоогийн хорчин зүүн гарын хойд хошууны Ганзага балгасны зүүн хойно гучаад газар байсан дүн хар хайлаас модон бэрхэд ирж аргаа тавьж жижиг тогоогоо гаргах гэсэн чинь тогоо нь алга болжээ. Хожгор лам их л сандарч ийш тийш харж үзэхэд хүн амьтны

⁶ Б.Насан нар. Жиримийн газрын нэрийн домог. ӨМСХХ., 2010

⁷ Б.Насан нар. Жиримийн газрын нэрийн домог. ӨМСХХ., 2010



THE CULTURAL WAY

сураг чимээгүй. Гэнэт “хи, хи, хи” гэх хүүхдийн инээх дуу ой дотроос дуулдсанд хожгор ламын зүрх нь чичирч хуйхны үс нь босож цочисхийн харж үзэхэд хайлаас модны салаан дээгүүр улаан дуу бүсэлсэн нэгэн нялх хүүхэд нааш цааш тоглож байх бөгөөд чанга дуугаар: “Хайсыг чинь авчээ, хайлаас модонд өлгөжээ, хамба ламын баал, хамрын тамхинд дурлажээ, харцын охин удайм, хатан болохыг санажээ, халцархай буур тэмээ, халгай идэхийг горилжээ, хар ламын хожгор шавь, хувилгаан болохыг зүүдэлжээ, хайсыг чинь авчээ, хайлаас модонд өлгөжээ!” гээд үсэрч харайн дуулж бүжиглэж хатганатал инээж гэнэ. Хожгор лам ихэд айж, хайс тогоогоо хаяад аргаа үүрээд эргэж харалгүй зугтаажээ. Хожим энэ газар айл суугаад хожгор лам хайс тогоо гэсэнээр “Хайсын айл” гэж нэрлэгджээ.

Хорчинд бурхан ламтай холбогдсон урлагийн бүтээгдэхүүн болон бий. Доор “Ховогтой бөөгийн домог”⁸-ийг үзвэл:

Аль эрт хорчины тал нутагт Нарагунцог гэдэг нэгэн их тайж байсан гэнэ. Түүний эхнэр нь Бинтэйбэй гэдэг, эхнэр нөхөр хоёул хүссээр байж хөвгүүнтэй болоод хөвгүүндээ Ховогтой хэмээн нэр хайрласан байжээ. Тэгээд тэр гурвуул зол жаргалтай аж төрөн амьдарч байснаа Нарагунцог тайж гэнэт өвчин олоод хэдий олон эмч домчоор засуулсан ч илэрхий болсонгүй, өдрөөс өдөр доройтож байтал нэгэн өдөр уранхай орхимж нөмөрсөн бадарч лам гэрийн үүдэнд нь ирж, хоног гуйсанд Нарагунцог сэтгэл зөөлөн хүн тул гэртээ залж их л хүндэлж зочилсон гэнэ.

Бадарч лам Нарагунцог тайжийн өвчин хүнд байхыг үзээд “өвчин чинь ийм хүнд байгаад юунд эмч залж үзүүлэхгүй юм?” гэсэн Бинтэйбэй эхнэр нь санаа алдаж: “Хай, эмч домч залсан ч тайжийн өвчин нь зүгээр болсонгүй” гэлээ. Тэр бадарч лам: “Тийм бол би засаж сайн болгоё” гээд тарни уншиж нүүр өөд нь үлээсэнд тайжийн өвчин тэр дороо хөнгөрч, явж суухад гэмгүй болжээ. Тэгээд тэр бадарч лам тайжид онцгой эрдэм ба тарни зааж өгөөд: “чи бол бөө болох шалтгаантай, үүнээс хойш бөө болж, чамтай адил өвчинтэй хүн тохиолдвол засаж яв аа” гэжээ. Нарагунцог тайж: “бурхан багшийн номын нэрээ хэн болгох вэ?” гэхэд “би бол Мял богд гэдэг” гээд наминчлан явсан гэнэ.

Дээрх хэдэн үлгэрт гарсан бурхан ба лам нь бүр хүн төрөлхтний ашиг тус үйлдэх гэж түмний дуслыг хурааж явсан буюу өвчин эмгэгийг эдгээж өгсөн зөв талын дүрээр гарчээ. Хайс айлын домогт гарсан хожгор лам нь ч хэдийгээр өөрийнхөө төлөө боловч хүн ардад хор хийсэнгүй байна. Гэвч хорчин ардын дуунд лам нарын дүр ихэнхдээ эм өгсөнд дурласан, хувинцар зальхай, алжуу

⁸ Сы Шянь, Бао Жу. Монгол ардын домог үлгэр. ӨМАХХ., 2012



THE CULTURAL WAY

залхуу зэрэг назгай байдлаар илэрдэг. Энэ нь хүн бүхэнд хоёр талын чанартай мөртөө нэг хүн нь адил бус хүнд, адил бус цаг үед адил бусаар нөлөөлдөг гэснийг илэрхийлнэ.

Хоёр. Түүхт үйл явдлаас үүсэл гаралтай

Хорчинчууд шарын шашныг шүтэж эхлэхээсээ өмнө, ард олон бүр бөөгийн шашныг шүтэж байжээ. Түүхэнд Нэйж тойн хутагт хорчинд шарын шашныг дэлгэрүүлэхдээ хорчин бөөтэй тэмцэлдэж, бөө мөргөлийг хайр найргүй дарангуйлсан байна. Яг иймээс хорчин зүүн гарын хойд хошууны газрын нэрийн үүсэл домог яриад энэхүү түүхэн үйл явдлыг тусгасан зүйл олон харагдана.

Эрт урьд цагт, Утайн таван уулын гол сүмийн их тогоо зүүн хойшоо хазайж гэнэ. Майдар гэгээн үүнийг үзээд: “зүүн хойд орны гамшиг болох гэж байна, хурдан тэндэх олон түмний дуслыг хуримтлуулж, тогоо дүүргэж, олон түмний үйл зовлонг арилгая” гэж олон шавь нараа дагуулж дусал (*бадар, гуйлга*) гуйхаар гарч иржээ. Майдар гэгээн шавь нараа дагуулж дусал гуйж явсаар одоогийн хорчин зүүн гарыны хойд хошууны Шартал сумын суугаа газарт хүрч ирээд нар орой болж амрах цаг болсон тул талын дунд майхан босгож хоногложээ. Маргааш эрт нь босоход гэгээний шар майхны бүсийг хэсэг хэсгээр урж тал дүүрэн өвс модны оройд уясан байжээ. Багш шавь нарын өмссөн хувцас малгай хүртэл урагдаж өвс модонд өлгөгджээ. Ургах нарны улбар туяанд үзэхэд тал дүүрэн шар бүснээс шижир гэрэл цацарч, зөөлөн салхинд намиран хийсэж гойд сайхан харагдана.

Тиймээс хожмын хүмүүс энэхүү талыг Шартал гэж нэрлэжээ. Сүүлд энэ талд айл гарч айлын нэрээ шартал гэв. Майдар гэгээн хуруу дарж хумс нясалж үзэхэд энэ газар нэгэн бөөгийн онгод самуурч дураар аашилж байжээ. Гэгээний майхан хувцас малгайг даруй энэ самуурсан онгод уржээ. Тэгээд Майдар гэгээн шавь нараа дагуулж энэ онгодыг дарахаар хөөв. Гэгээн тарни уншиж бие хувирч агаарт дэгдэж тэрхүү онгодыг хөөсөөр одоогийн Шартал сумын онгод айл гацааны суугаа газарт хүрч ирээд хувилгаан очироороо онгодыг цохиж унагажээ. Шавь нараа дуудаж онгодыг барьж аваад долоон хоногийн номд сууж овоо босгож дарж тавьжээ. Сүүлд нь онгодыг дарсан талыг онгодын тал гэж нэрлэв. Яваандаа энэхүү онгодын тал нь онгод тал гэж уламжлагдаж, айл суугаад айлын нэрээ “онгод айл” гэж нэрлэжээ. Энэ нь даруй одоогийн Шартал сумын Онгод айл гацаа болно.



THE CULTURAL WAY

Дээрх “Шартал сумын домог”⁹ ба “Онгод айлын домог” нь шарын шашин ба бөө мөргөлийн тэмцэлдээний үр дүнг бүрмөсөн тусгасан байдаг. Домогт Майдар гэгээн ард түмний зовлонг арилгах зорилгоор Утайгаас бууж дусал гуйжээ. Урагдаж сэмэрсэн хувцас нь улбар нарны доор шижир гэрэл цацарч, намиран хийсэх салхинд сайхан харагдана. Харин бөө мөргөл бол Майдар гэгээний арилгах гэж байгаа гамшиг, бөөгийн онгод нь гэгээн жич түүний шавь нарынх нь хувцас хунарыг урж хаясан яргачин мөртөө эцэстээ дийлэгджээ.

Үүний тухай бөө мөргөлөөр гол баатраа болгосон “Ховогтой бөөгийн домог”-т:

Нарагунцог тайжийн хөвгүүн Ховогтой бөөгийн эрдэм хүчийг ялагдашгүй сурсаны дараа, эрдэмтэй хүн хаана байхыг олж сонсвол тэнд очин устгаж тарни уншиж тэнгэр буулгаж явдаг болохоор түүнл халдах хүнгүй болжээ. Ховогтой бөөгийн алж болох нь арвидаад орчлонгийн газарт аюул гамшиг дэгдээхийг Мял богд мэдээд ихэд хилэгнэж нэгэн дусал гуйх лам болоод Бинтэйбэй ээжийн дэргэд очжээ. Энэ үед Бинтэйбэй ээж өвчтэй байсанд бөө засаж чадаагүй байжээ. Гэтэл дуслын лам тэр өвчнийг нь засаад тайлчихжээ. Үүнийг мэдсэн бөө дуслын ламтай их дайн болоод эцэстээ дийлэгдэн, дуслын ламын доор сөгдөж түүний шавь болов. Дуслын лам Ховогтой бөөгийн тангарагийг авч “хүн амьтанд хор хийж болохгүй” гээд явсан байжээ. Үүний дүнд “Ховогтой бөөгийн зарим шавь нь ламаас сурсан тул лайчин болж, бөөгөөс сурсан нь бөө болоод бөө лайчин хоёр хуваарьтай болсон гэнэ. Бөө омог сүр нь дарагдаад далан гурван шавьдаа “та нар, хорчины газарт хүн амьтан зургаан зүйлд тус хүргэж өвчин засаж яваарай” хэмээн сургажээ. Гэтэл зарим шавь нь зөрүүд зантай болохоор багшаасаа салж тарни бясалгаж явах тул хар зүгийн бөө хэмээн дуудагдаад, өвчин засаж явах нь цагаан зүгийн бөө болж хар цагаан хоёр зүгийн бөө гэх ялгаа бий болжээ.

“Өөд болсон бөө дээдсийн хүчирхэгжсэн сүнс буюу эрчим хүч, газар усны эзэд (лус савдаг) буюу байгаль дээрх эрчим хүч хоёрын (нийлбэр) нэгдлийг онгод гэнэ. Бөөгийн онгод бол сахиус шүтээний баримал дүрс хөрөг болно. Эртний бөө мөргөл анхан үе араатан амьтан, байгаль бодист мөргөж байснаасаа сүнсний дүрс ойлголт буй болохыг дагалдан тус биеэс нь салсан эзэн сахиусанд мөргөн даатгах болжээ. Шүтээнийхээ дүрс хэлбэрийг мод, чулуу, эсгий ноос, бүс, торго, хүрэл, төмөр, мөнгө, гуулийг үйлдэн бүтээж онгод хэмээн шүтэх болжээ”¹⁰. Онгодыг бөө мөргөлийн үндэс нь болно. Тус

⁹ Б.Насан нар. Жиримийн газрын нэрийн домог. ӨМСХХ., 2010

¹⁰ О.Пүрэв. Монгол бөө мөргөлийн нэр томъёоны тайлбар толь. ӨМАХХ., 2013



THE CULTURAL WAY

домог ярианд Майдар гэгээн онгодыг дарсан нь түүхэнд шарын шашин бөө мөргөлийг дарсныг төлөөлж “Ховогтой бөөгийн домог” бөө шарын шашинтай нэгдсэн нь бөө мөргөл ба шарын шашин нэг нэгнээ харилцан шингээж, хоорондоо уусалцсаныг илэрхийлнэ.

Түүхэнд Нэйж тойн хорчин нутагт шарын шашныг дэлгэрүүлэхдээ, юуны өмнө бөө мөргөлийн онгодыг хороож шатаалгахаас эхэлжээ. Үүнд хорчины зарим язгууртад, харцас онгодоо шатаалгахаас хамгаалж байжээ. Шарын шашин бөө мөргөлийг дарангуйлахдаа мөн бөө нарыг шатаах ажиллагаа явагдуулж байжээ. Үүнд галын шатаалгыг туулсан хэдэн бөө нар хорчин бөөг уламжлан хөгжүүлсэн байна.

Хорчин бөө мөргөл хийгээд шарын шашны тэмцлийн үр дүнд бөө мөргөл шарын шашинд гүн автагдаж, шарын шашин ч бөө мөргөлийн зарим зүйлийг шингээн авч, эвсэж эвлэрэх болжээ. Хорчинд шарын шашин дэлгэрэх үе шарын шарын шашинтай эвлэрсэн цагаан зүгийн бөө ба шарын шашиннтай эрс тэмцсэн хар зүгийн бөө хэмээх хоёр салбар гарчээ. Мөн лам бөө, чойжин бөө, гүртэм бөө зэрэг буй болжээ. Шарын шашин бас бөө мөргөлийн зарим зан үйлийг шингээн авчээ. Тэд сүм сангийн зарим үйлд “очироор хэц дэлдэх болж, бөө нарын золиг золио гаргахыг сурч ашиглан сур хаях болж, бөө нарын гүртэм үйлдэхийг лам нар сурч ашиглан их гүртэм хийж, бөө нарын үйлддэг янчис, алимадыг ч лам нар бас хийдэг болжээ”¹¹. Иймээс дээрх домог яриа нь түүхэн үнэнд бүтээгдсэн байна.

Чин улсын сүүлч үе эсвэл иргэн улсын эхэн үед нийгмийн байдал ороо бусгаа, дайн дажин олширч, ард түмэн гааль татвар хүндэрч мөн монгол оронд их хэмжээгээр атар хагалбарлаж, хятад иргэн олширсноос тухайн үеийн монголчууд олон арвин эсэргүүцэл гаргасан байна. Аливаа урлагийн бүтээл нь тухайн үеийн нийгмийн байдалд суурилан бүтээгддэг, яг иймээс энэхүү байдал нь хойд хошууны газрын нэрийн үүслийн домог ярианд нөлөөлсөн байна. Доор “Төвөрийн айлын домог”¹²-ийг үзвэл:

Манжийн үед Бинтийн хошууны монголчууд ав хийх гэвэл одоогийн Чулуут сумын баруунтай арваад газарт байх нэгэн өндөр дов дээр цугларна. Энгийн газраас өндөр овойж гарсан газрыг төвөр гэж хэлэх тул энэ авын цуглааны газрыг төвөр цуглаан гэж нэрлэжээ. Бинтийн хошууны Гончигсаран ван бээжинд нон арван хошууны ван нарыг цуглуулж, Юань Шикай-г эсэргүүцэх бослого гаргах гэж байсаар мэдэгдэж зугтаан гарч ирэхдээ нон

¹¹ Хүрэлша, Бай Зүйжин, Начин, Буянцугла. Хорчины бөө мөргөлийн судлал. ҮнХХ., 1998

¹² Хүрэлша, Бай Зүйжин, Начин, Буянцугла. Хорчины бөө мөргөлийн судлал. ҮнХХ., 1998



THE CULTURAL WAY

арван хошууны цэргийн туслагч нарт: “Бид бээжинд сууж Юань Шикай-г эсэргүүцэх тохиолгүй болжээ, цэргээ дагуулж ар газар мордьё, ар газар хүрээд жигүүр сөд бүрэлдэж хүчирхэгжсэний дараа дахин бээжин зүг цэрэг орж Юань Шикай-н төрийг түлхэн унагаая, манай олон цэрэг Бинтийн хошууны баруун хойно авын цуглаан болж байсан төвөрийн оройд цугларъя” гэж захиа өгөөд гарч иржээ. Нон арван хошууны хэсэг бусаг цэргийн тавь зуугаар хагас сар цуглараад бинт ван Гончигсаран хэдэн мянган цэрэгтэй болж, төвөрийн оройд цагаан морь, цагаан үхэр, цагаан хонь, цагаан тэмээ алж тэнгэр тахин, ард мордсон Гончигсарангийн цэрэг санаа сэтгэл нэгтэйгээр самууныг дарахаар буцаж орж ирнэ. Тэр өдөр төвөрийн оройд дахин цугларч тэнгэр аавыг баясгая гэж амлалдаад цэрэг морджээ. Хожмын хүмүүс энэхүү учрыг дурсгахын төлөө энд айл гаргаж айлын нэрээ төвөр гэж нэрлэжээ.

Тус домог ярианд гарах Гончигсаран бол боржгин овогтой, 1887 онд мэндэлсэн Хавт Хасарын 29 дүгээр үеийн үр ач болно. Бадаргуулт төрийн 30 дугаар буюу 1904 онд засагт төрийн бинт жүн вангийн суурийг залгамжилжээ. Бинт вангийн нас барсан шалтгаан жич он сар нь хараахан зөрөөтэй байна. Үрдэлгэр, Алтан-Очирын найруулан зохиосон “Бинт хошууны түүх тэмдэглэл” гэх номд, Гончигсаранг 1914 оны хавар монголын Жавзандаба хутагтад хорлогджээ хэмээн бичиж буй. Хүрэлша, Сэргэлэнгийн найруулсан “Хорчин ардын дууны баатрын домог намтар” хэмээх бүтээлд, түүнийг 1915 онд халхын Жавзандамбад хорлогджээ гэдэг, бас унах өвчнөөсөө болоод нас барсан ба Юань Шикай-д хорлогдсон гэх таамаглал байдаг. Төвөрийн айлын домог ярианд гарсан түүх бол түүхэн үйл явдалтай нийцнэ.

Цагаагчин гахай жилийн хувьсгал ялалт олсны дараа Юань Шикай төрийн эрхийг хулгайлж, иргэн улсын ерөнхийлөгч болж, Си тайху-тай сүлбэлдэж эзэн төрийг эзлэн, олон үндэстнийг дарлаж эхэлжээ. Энэ үед Гончигсаран эзэн журган яаманд жүн ван зэрэгтэй байж, бээжин журган яаманд алба залгуулж байжээ. Нэгэн удаагийн зөвлөлдөөн дээр бинт ван ба Юань Шикай зөрчилдөж, бинт ван нутагтаа буцжээ. Буцсаны дараа бинт ван нон хорчины арван хошууны вангуудаа цуглуулаад Юань Шикай-г эсэргүүцье гэсэнд хошуу хошууны ван нар амиа алдахаас айгаад тухайн эсэргүүцэл нь зогсохоос өөр аргагүй болов. Нэн харамсалтай нь бинт вангийн энэ ажиллагаа нь Юань Шикай-д мэдэгджээ. Тэгээд бинт ван Гончигсаран нутагтаа буцахын аргагүй болоод ар монгол руу зугтаажээ. Дээрх домог ярианд гарсан “Ар газар” нь даруй ар монголыг зааж байна.

Дээрх чин улсын домог ярианаас мэдэгдэх нь чин улсын сүүлч иргэн улсын үед монгол орон болон дотор газрын зөрчил хурцдаж, ар монгол



THE CULTURAL WAY

тусгаарласны дараа, өвөр монголын ван нар ар монголын хамгаалалтыг хайх буюу тэнд хүрч хүсэл эрмэлзлэлээ биелүүлэх нь ерийн үзэгдэл болжээ.

ДҮГНЭЛТ

Домог яриа нь ердөө түүхэн хүн, түүхэн үйл явдал, байгаль орчны түмэн бодис, өвөрмөц зан заншлаас үүсэлтэй байдаг. Хорчин зүүн гарын хойд хошууны газрын нэрийн үүслийн домог ярианд түүхэн хүн, түүхэн үйл явдлаас үүсэлтэй нь дийлэнх хувийг эзэлнэ. Түүхэн хүний дотор хойд хошууны алдарт хүн бодлогот чин ван Сэнгэринчин, ван хаад ба шарын шашинтай холбогдол бүхий хүмүүсээс үүсэлтэй нь олон байна. Түүхэн үйл явдлаас шарын шашин ба бөө мөргөлийн тэмцэлдээн ба эсэргүүцсэн үйл ажиллагаанаас үүсэлтэй нь олон байдаг. Түүхэн хүнээс үүсэлтэй гэсэнгүй түүхэн үйл явдлаас үүсэлтэй гэсэнгүй бүр түүхэн үнэнтэй нийцнэ. Гэвч хүн төрөлхтний бодгаль шинж ба цаг үеийн адил бусаас болж адил бус хүн, үйл явдалд адил бус байдал жич үйл ажиллагаа авдаг байна.

ABSTRACT

People are used to naming the places they live based on history. Over time, these place names are often passed down from generation to generation along with legends and stories in daily life. In the stories of source of place names of Kezuohouqi, legends from historical figures and historical events account for a large proportion. Among historical figures, legends from the Prince Senggerinchin, the emperor of Qing Dynasty and figures related to Lamaism account for a large proportion. In historical events, most of the legends come from the dispute between Lamaism and Shamanism and the resistance of the people since the late Qing Dynasty. The origin of these place name legends can be studied. Based on the different space and personality, people's evaluation of these characters and events are also different.

Key words: *Kezuohouqi, source of placename, legend story*

НОМ ЗҮЙ

1. Мандах. Ардын аман зохиолын онол. ЛяҮнХХ
2. Хүрэлша, Бай Зүйжин, Начин, Буянцугла. Хорчины бөө мөргөлийн судлал. ҮнХХ., 1998
3. Хорчин зан үйлийн судлал. ӨМСХХХ., 2003
4. Б.Насан нар. Жиримийн газрын нэрийн домог. ӨМСХХ., 2010
5. Сы Шянь, Бао Жу. Монгол ардын домог үлгэр. ӨМАХХ., 2012
6. О.Пүрэв. Монгол бөө мөргөлийн нэр томъёоны тайлбар толь. ӨМАХХ., 2013
7. Син Ичэнь. Сэнгэринчин. ӨМАХХ., 2017

**ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ЦАХИМ СУРГАЛТЫГ
НИЙГЭМ ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН ҮҮДНЭЭС ТОДРУУЛСАН НЬ**

Ү.Шүрээ*
Т.Батбямба**

ХУРААНГУЙ

2019 оны 11 дүгээр сард титэм вирусийн¹ цар тахал БНХАУ-ын Ухань хотод анх бүртгэгдсэн бөгөөд манай улсад 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдөр тус вирусээр халдварлагдсан анхны тохиолдол илэрсэн.

Бид энэхүү судалгаагаараа цар тахлын үед Монгол Улсын нийгмийн амьдралд хэрхэн өөрчлөлтүүд гарсан талаар, ялангуяа боловсролын салбар дахь цахим сургалтын үеийн суралцагчдын суралцахуйн байдал, сургалтад гарч байгаа өөрчлөлт шинэчлэлтийн үр дүнг тодруулахыг зорьсон. Ингэхдээ Барилгын Политехник Коллежийн цахим сургалтын үйл ажиллагааг нийгмийн хэл шинжлэлийн хээрийн судалгааны аргаар судалж, судалгааныхаа үр дүнг танилцуулж байна.

Түлхүүр үгс: *Боловсрол, цахим хичээл, виртуал лаборатори, дижитал технологи*

УДИРТГАЛ

Нийгэм хэл шинжлэл нь хэлийг соёлын хэм хэмжээ, нөхцөл байдал зэрэг нийгмийн нөлөөлөл, хэрэглэх арга зам, нийгэмд үзүүлэх нөлөөлөгч гэдэг талаас нь судлан шинжилж, тайлбарладаг орчин үеийн хэл шинжлэлийн харьцангуй шинэ салбар ухаан юм. Иймээс тус хэл шинжлэлийн салбар ухааныг бүх шинжлэх ухааныг холбогч гүүр шинжлэх ухаан хэмээдэг.

Аадрын үүл хуралдаж аянга цахилгаан буух мэт дэлхийн хүн төрөлхтөн “Ковид – 19” буюу титэм вирустэй хөл зэрэгцэн амьдарч байгаа билээ. Энэ нь бид өдөр тутмын амьдралдаа “Цахим хэрэглээг хэмнэл болгох” хэрэгцээ шаардлага урган гарч, дэлхийн өнцөг булан бүрд олон сая хүн халдвар

* Барилгын Политехник Коллежийн багш, ӨМИС-ийн докторант

** ШУА-ийн ХЗХ-ийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбарын ЭША, ӨМИС-ийн докторант

¹ Титэм вирус буюу коронавирус бол хүн бүрийн амьдралынхаа аль нэг хугацаанд халдвар авдаг вирус юм.



THE CULTURAL WAY

хамгааллын дэглэмийг чанд сахиж, хөл хорионд амьдарч байсан цаг саяхан. Энэхүү нөхцөл байдал ч монгол улсыг тойрон гараагүй бөгөөд нийгмийн амьдралын бүхий л хүрээнд ихээхэн өөрчлөлтүүд гарч, цахим хэрэглээний хэмнэлд дасан зохицох болжээ. Ялангуяа боловсролын салбарт ажиллаж буй багш боловсон хүчний хувьд цахим хичээлийг хэрхэн үр дүнтэй, хүртээмжтэй, чанартай зохион байгуулах бодит хэрэгцээ шаардлага үүссэнээр цахим өөрчлөлт шинэчлэлтийг хийх гэнэтийн, хүндхэн сорилттой тулгарсан билээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанаас "Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай хэлэлцээр"²-ийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол, Хятадын хилийн боомтуудаар нэвтрэх иргэдийн хөдөлгөөнд 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн улсын хэмжээнд хөл хорио тогтоосон³. Дээрх тогтоолтой холбогдуулан 2020 оны 02 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн манай улсын боловсролын салбарын бүх шатны нэгжүүдэд цахим сургалтыг нэвтрүүлж эхэлсэн. Улмаар Монгол Улсын боловсролын салбар цахим орчинд тэгш хүртээмжтэй сургалтын тогтолцоог бүрдүүлэхийг зорьж ажилласан. Тухайлбал: “*“Алсын хараа – 2050” Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого*”, “*Монгол Улсын боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны 2021-2030 төлөвлөгөө*” болон “*Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр*”-т “*Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлэх*” зорилтын хүрээнд “*Нийгэм болон дижитал технологийн эринд ажиллаж амьдрах, нийгмийн идэвх оролцоотой, тасралтгүй хөгжих чадамжтай, хүмүүнлэг, ёс зүйтэй иргэнийг хөгжүүлэх нь боловсролын ирээдүйн хөгжлийн төлөвлөлт юм.*” хэмээн үзсэн⁴.

Гэвч бодит байдал дээр хүүхэд бүр тэгш хүртээмжтэй боловсролыг эзэмшиж байгаа эсэх нь эргэлзээтэй асуудал юм. Тэгш хүртээмжтэй гэдэг үгийг утгын хувьд тайлбарлавал :

- тэгш - олон зүйлийн хоорондоо эн чацуу, илүү дутуугүй, адил;⁵
- хүртээмжтэй - хүртээмж сайтай, элбэг дэлбэг;⁶ гэсэн утгыг агуулж байна.

Гэтэл хүүхэд бүр цар тахлын үед тэгш хүртээмжтэй суралцаж чадаж байна уу? гэдэг асуудал урган гарч байна. Учир нь тэгш хүртээмжтэй гэдэг шалгуурт

² <https://legalinfo.mn/mn/detail/372>

³ Б.Халтар: *Замын-Үүд халдвар тархсан бүс болчихсон учраас Хятадын талаас болгоомжтой хандаж байна. Үүнийг бид хүндэтгэн үзэх ёстой*, Өдрийн сонин, 2020.12.18, Баасан, №248 (6614), V нүүр.

⁴ БШУ-ны сайд Л.Цэдэвсүрэн: *Боловсролын цахим сургалт, технологи, контентг анх удаа хуульчлах гэж байна*, Өдрийн сонин, 2020.12.30, Лхагва, №256 (6622), I нүүр.

⁵ <https://mongoltoli.mn/dictionary/detail/92384>

⁶ <https://mongoltoli.mn/dictionary/detail/118156>



THE CULTURAL WAY

хүрэхэд олон хүчин зүйл нөлөөлж байна. Тухайлбал, нийгмийн тэгш бус байдал, нийгмийн гарал үүсэл, хаана, Монгол Улсын аль аймаг, хот, сум, дүүрэг, багт оршин сууж байгаа, тусгай хэрэгцээт суралцагч буюу хөгжлийн бэрхшээлтэй хүний⁷ суралцахуйн асуудал гэх зэрэг нь хэн бүхний анхаарлыг татаж байна.

Хүүхэд бүрд ажлын таван өдөр⁸ цахим хичээлд хамрагдах дата (интернэтийн хэмжигдэхүүн өгөгдөл)⁹ хүрэлцэхгүй байна. Ингэснээр цахим хичээл нь эцэг эхчүүдээс эдийн засгийн шинэ санхүүжилт нэхэж эхэлсэн. Уг нөхцөл байдал нь Монгол Улсын хүүхэд бүрд тэгш хүртээмжтэй суралцах боломжийг хязгаарлахад хүргэсэн.

Эдийн засгийн хувьд боломжтой айл өрхийн хүүхдүүдийн хувьд интернэт орчинд суралцах боломжтой бол, эдийн засгийн хувьд боломжгүй гэр хорооллын захад амьдардаг, сүлжээгүй газар оршин суудаг малчин айлын хүүхдүүдийн хувьд цахим орчинд суралцах боломж хязгаарлагдмал байсан.

Иймд бид нийгмийн амьдралд үүссэн цар тахалтай холбогдох асуудлыг шийдвэрлэхэд тулгарч буй саад бэрхшээл, түүнийг даван туулсан арга зам, туршлагыг нийгэм хэл шинжлэлийн үүднээс тодруулан судалж, судалгааныхаа үр дүнд тулгуурлан, цаашид гэнэт тохиолдож болох эрсдэлийн хүчин зүйлийг даван туулах боломжийн талаар саналаа нэмэрлэхийг зорив.

Учир нь дэлхий дахиныг хамарсан цар тахлын дэгдэлтийн байдал өдгөө ч (2022.12 сар) намжаагүй бөгөөд урд хөрш БНХАУ хилийн хориогоо хэзээ цуцлах нь тодорхойгүй буюу зарим хотуудад хатуу хөл хорионы дэглэм үйлчилсээр байна. Монгол Улсын Засгийн Газар 2021-2024 оны үйл ажиллагааныхаа хүрээнд цахим үндэстэн болох зорилт тавьсан учраас энэ төрлийн судалгааг чухал хэмээн үзэж байна.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

“ТВ хичээлд яагаад интернэт хамааралтай гэж” хэмээн зарим хүн боддог байх. Телевизээр гарч буй ТВ хичээлийг олон хүүхэдтэй айлын хүүхдүүд ээлж дараагаараа үздэг учраас хичээлээ хийх боломж нь хязгаарлагдмал байгаа нь сургалтын үйл ажиллагааны явцад ажиглагдсан. Харин хотын төвд орон сууцанд амьдардаг хүүхдүүдийн хувьд хичээлээ хүссэн үедээ гар утас, телевиз, интернэтийн тоног төхөөрөмжийн тусламжтайгаар ухрааж үзэх боломжтой. Иймээс цахим орчинд суралцах боломж, тэгш хүртээмжийн асуудал харилцан

⁷ "хөгжлийн бэрхшээлтэй хүн" гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг; (*Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль*, Уб., 2016)

⁸ Э.Уранбилэг, *Шинэ үг хэллэгийн толь*, Уб., 2021, 40 тал.

⁹ Мөн гэнд, 118 тал.



адилгүй байна.

Бид судалгааныхаа хүрээнд


- Цар тахал сорилт уу? Хөгжлийн гарц уу? гэсэн асуултад хариулт авах,
- Цахим сургалтын чанар, хүртээмжийг тодорхойлох,
- Боловсролын салбарт ямар ямар өөрчлөлтүүд хэрхэн хийгдэж байгааг тодруулах гэсэн зорилтуудыг тавьж ажиллалаа.

Судалгааны судлагдахуунаар Барилгын Политехник Коллежийн сургуулийн багш, суралцагчдыг сонгон авч, судалгаагаа хийлээ.

1. Цахим сургалтын арга зүй

Цахим сургалтын арга зүйн судалгааг Барилгын Политехник Коллежийн багш нарын боловсруулсан ээлжит хичээлд анализ хийж тодруулсан. Ингэхэд 75% нь РРТ хэлбэрээр буюу зурагт хөрвүүлсэн байдлаар, 20% нь видео болон теле хичээл youtube сувгаар, 5% нь виртуал лабораторийг ашиглан¹⁰ хичээл сургалтын үйл ажиллагаагаа зохион байгуулсан байна. Эндээс дээрх гурван хэлбэрээр боловсруулсан багшийн заасан хичээлийн сургалтын үр дүнг судалж үзвэл дараах байдалтай байна.

График 1. Цахим сургалтын арга зүйн судалгаа



Графикаас үзвэл, сургалтын үйл ажиллагаанд ашиглаж буй РРТ хичээл, видео хичээлтэй харьцуулахад виртуал лабораториор зохион байгуулсан хичээл илүү дүнтэй болсон нь ажиглагдаж байна. Учир нь судалгааны дүнд виртуал лаборатори хичээлээр суралцагчид богино хугацаанд их мэдээлэл олж авах, бие даан бүтээлчээр ажиллах, эрсдэлгүй орчинд үнэгүй дадлагыг хийж чадсанаас гадна суралцагчдын анхаарал, ой тогтоолтод сайнаар нөлөөлсөн сайн туршлага

¹⁰ БПК-ийн Сургалтын албаны мэдээгээр баталгаажуулав.



харагдаж байна.

Харин танин мэдэхүйн түвшин хангалтгүй эзэмшсэн суралцагчдад зориулан тусгай групп байгуулж, хичээлээс ойлгоогүй үлдсэн ухагдахууныг фейсбүүк, zoom болон google meeting ашиглан, тайлбар хийж, хичээлийг бататгаж байснаар сургалтын чанар өссөн үзүүлэлттэй гарсан байна.

2. Цахим сургалтын хүртээмж

Цахим сургалтын хүртээмжийг тодруулах үүднээс Барилгын Политехник Коллежийн 10 мэргэжлийн 18 ангийн 1177 суралцагчдаас цахим хичээлийн оролцооны судалгааг авахад, 91,3% нь гар утас хэрэглэж, 8,7% нь бусад төхөөрөмжийн тусламжтайгаар сургалтын үйл ажиллагаанд хамрагджээ.

Судалгаанд оролцогчдын 73,6% нь гар утсаар хичээл хийхэд саадгүй гэж хариулсан бол 26.4% нь 128 gb хурдаар интернэтэд нэвтэрдэг байсан ба цахим хичээлийг хүлээж авахад хүндрэлтэй байсан гэж хариулсан. Иймд сургуулийн зүгээс дээрх асуудлыг zappag work application-ыг сургалтад нэвтрүүлснээр богино хугацаанд шийдвэрлэсэн байна

Zappag work application нь интернэтгүй болон сүлжээгүй газар ч ажиллах боломжтойгоороо давуу талтай юм. Цахим сургалтад zappag application-ыг ашигласан байдлын үр дүнг тодруулсан графикаар үзүүлбэл дараах байдалтай байна. Үүнд:

График 2. Цахим сургалтад zappag application-ыг ашигласан байдлын судалгаа



Графикаас үзвэл, хичээлийг zappag work application-д байршуулж, цахим сургалтаа явуулснаар сургалтын хүртээмж тэлж чанарын өсөлт гарчээ. Тухайлбал, суралцагчдын хичээлийн идэвх оролцооны хувьд тухайн өдөрт хичээлээ хийдэг суралцагчдын хувь нь 38,3% байснаас zappag application-ыг нэвтрүүлснээр 58,6%, 7 хоногийн төгсгөлд хичээл хийдэг суралцагчдын хувь нь 53,7% байснаас 87,4% болж өссөн байна.



3. Боловсролын салбар дахь өөрчлөлт

Бид судалгааныхаа ажлын хүрээнд Барилгын Политехник Коллежийн сургалтын үйл ажиллагаанд гарсан өөрчлөлт, шинэчлэлтүүдийн талаарх санал асуулгыг тус сургуулийн нийт багш нар (98 багш)-ын дунд зохион байгуулсан. Тус санал асуулгад нийт багш нарын 92 нь буюу 93.8% нь хамрагдсан. Санал асуулгын үр дүнг нэгтгэн үзвэл, багш нар цахим сургалтын үед хэрэглэсэн арга туршлагаа ерөнхий бас тусгай гэсэн байдлаар тодорхойлсон байна. Тухайлбал,

1. Ерөнхий өөрчлөлт шинэчлэлтийн хувьд

- Анги тус бүр Facebook групп байгуулсан;
- Хичээлээ Teams, Moodle программ ашиглан явуулсан;
- Байгалийн шинжлэх ухааны хичээлүүд болох физик, хими, математик зэрэг хичээлүүдийг виртуал лаборатори ашиглан явуулсан;
- Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдүүдийн суралцахуйн онцлогт нь тохирсон интеграци хичээл бэлтгэсэн;
- Суралцагчдын онцлогт тохирсон зурагт үзүүлэнг бэлтгэсэн;
- Суралцагчид өөрсдөө бие даан судлах боломжтой интерактив хичээл боловсруулсан;
- Багш нар өөрийн хичээлийг zoom, google meeting ашиглан тодорхой цагуудад хичээлийн хуваарийн дагуу зохион байгуулдаг;
- Багш өөрийн бэлтгэсэн видео хичээлийг түлхүү ашиглаж сургалтын үйл ажиллагааг зохион байгуулдаг;
- зарраг work гар утасны аппликэшн ашиглан багш нар боловсруулсан цахим хичээлээ зардал багатай хүргэх боломжийг илрүүлсэн.

2. Тусгай хэрэгцээт суралцагчийн цахим орчинд суралцах боломжийг нэмэгдүүлсэн байдлын хувьд дараах арга хэмжээг авсан байна.

Тус сургуулийн хувьд сүүлийн хоёр жилийн байдлаар мэргэжлийн боловсрол олгох сургалт (МБОС)-ын I, мэргэжлийн боловсрол олгох сургалт (МБОС)-ын II ангийн суралцагчдын 20% гаруй хувь нь ямар нэгэн хэмжээгээр тусгай хэрэгцээт суралцагч байна.

2019-2020 оны хичээлийн жилийн II хагас, 2020-2021 оны хичээлийн жилийн I хагас жилийн судалгаагаар МБОС-I, II ангийн нийт 1177 суралцагчаас нийгмийн ажилтанд гаргаж өгсөн анги удирдсан багшийн хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн судалгаа, МБОС-I, II ангид хичээл заасан багш нараас авсан судалгаагаар 215 суралцагч буюу 19% нь тусгай хэрэгцээт суралцагч байна. Үүнийг бэрхшээл тус бүрээр нь авч үзье.



THE CULTURAL WAY

График 3. Тусгай хэрэгцээт суралцагчдын бэрхшээлийн хэлбэр



Эндээс үзвэл эдгээр суралцагчдын ихэнх буюу 45% нь хэт хөдөлгөөнтөх эмгэгшил болон сургууль завсардсан суралцагчид эзэлж байгаа.¹¹ Харин 22% нь анхаарал төвлөрөлтийн болон суралцахуйн бэрхшээлтэй (унших, бичих, сонсох, ярих, учир шалтгааныг нь олох, тоо бодох гэх мэт тодорхой ур чадварыг сурахад хүндрэлтэй тулгардаг) хүүхдүүд байна. Эдгээр эмгэг нь тэдний оюун ухааны түвшин эсвэл хараа болон сонсголын бэрхшээлээс шалтгаалдаггүй бөгөөд зөвхөн бичих бэрхшээл (дисграфия), тооцоолох бэрхшээл (дискалькулиа), уншиж ойлгох бэрхшээл (дислексиа)-тэй суралцагчид юм.¹²

Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд багш нар хамгийн түрүүнд эцэг, эх асран хамгаалагч, анги удирдсан багштай хамтран, хичээлийг аль болох харааны хүртэхүүд тохирсон зурган даалгаврыг өгч тэмдэглүүлж, ажиллажээ. Мөн түүнчлэн уг асуудлыг шийдвэрлэхийн тулд тус сургуулийн нийгмийн ухааны багш нар хамтран интеграци хичээлүүдийг бэлтгэн тухайн суралцагчдад хүргэн ажилласан нь үр дүнтэй, оновчтой сайн туршлага болж чаджээ.

Гэвч суралцагчдын зүгээс

- хэт ачаалалтай байна,
- ухаалаг утасгүй байна,
- интернэт орчин хязгаарлагдмал байна,
- ТВ хичээл үзэх боломжгүй гэх зэрэг шалтгааныг тоочжээ.

Хэдийгээр нөхцөл байдлыг боломж бололцоондоо тулгуурлан шийдсэн хэдий ч улс орны түвшинд шийдвэрлэвэл зохих асуудлууд ар араасаа урган гарсаар байна.

¹¹ Хараа, сонсгол, хөдөлгөөн, хэл яриа, оюуны бэрхшээл, аутизмын хүрээний эмгэг, суралцахуйн бэрхшээл, анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэг, сургууль завсардсан хүүхдүүд. www.savethechildren.mn

¹² Суралцахуйн бэрхшээл нь дараах үндсэн гурван төрөлд хуваагдана. 1.Бичих бэрхшээл (дисграфия), 2. Тооцоолох бэрхшээл (дискалькулиа), уншиж ойлгох бэрхшээл (дислексиа) www.savethechildren.mn



THE CULTURAL WAY

Мөн суралцагчдын хичээлийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс ангийг багийн зохион байгуулалтад шилжүүлэх, хичээлийн тооцоолуур хийж ил тод мэдээлэх, идэвхийн оноогоор урамшуулах, асран хамгаалагчийн хяналтыг сайжруулах гэм мэт аргыг давхар хэрэгжүүлж ашиглажээ.

Ингэснээр

- цахим орчинд суралцагчид ойлгомжтой байдлаар хичээлийг бэлтгэх, багш нарын хувьд харилцан адилгүй мэдлэгтэй суралцагчдад тохируулан, өргөн цар хүрээнд арга зүйгээ боловсруулан хөгжүүлэх ;
- цахим хичээлийн бүрэн санг бүрдүүлэхэд, нэмж сайжруулах ;
- суралцагчид хүссэн цагтаа хичээлээ дахин судлах боломжийг хангах ;
- цаашид учирч болох гэнэтийн сорилтод бэлэн байх боломж бүрэн бүрдсэн байна.

4. Цахим сургалтын давуу ба сул тал

Барилгын Политехник Коллежийн нийт багш нараас авсан асуулгын дүнд үндэслэн танхимын болон цахим сургалтын давуу ба сул талыг харьцуулан үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

1. Танхимын сургалт нь:

№	Давуу тал	Сул тал
1	Урьдчилан бэлтгэсэн хичээлийг суралцагчдад сургалтын олон арга ашиглаж хүргэдэг.	Суралцагч тухайн хичээлд суугаагүй бол ирц, явцын үнэлгээг тооцуулах боломжгүй.
2	Багш тараах материал, зурагт үзүүлэн тараан өгч ажиллуулан, суралцахуйн зорилтыг хангаж буй эсэхэд дүн шинжилгээ хийх боломж ихтэй.	Уламжлалт болсон арга зүйгээр хичээл сургалтын үйл ажиллагааг нийтлэг явуулах хандлагатай байдаг.
3	Багш суралцагч нүүр тулан харилцан ярилцаж, тухай бүр асуудлыг шийдвэрлэн, мэдлэг ойлголтын зөрүүтэй байдлыг цэгцлэх боломжтой.	Багш ангийн дүүргэлтээс шалтгаалж, суралцагч бүрийн суралцахуйн үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөн тусалж бололцоо дутмаг байдаг.
4	Явц дундын болон улирлын шалгалтыг үнэн зөв бодитой үнэлэх боломжтой.	Багш суралцагч бүрд тэгш хүртээмжтэй боловсролын үйлчилгээ үзүүлэх боломж хязгаарлагдмал. /ялангуяа өвчтэй, чөлөөтэй, тасалсан суралцагчдад/
5	Залуу багш ахмад багш нар харилцан туршлага судлах боломж нээлттэй.	Цаг хугацаа их шаардагддаг.

2. Цахим сургалт нь:



THE CULTURAL WAY

№	Давуу тал	Сул тал
1	Багш суралцагчид шинэ олон программ сурч хичээл сургалтдаа нэвтрүүлдэг.	Суралцагчид цахим сургалтад бүрэн хамрагдаж чадахгүй байх.
2	Багшийн бэлтгэсэн хичээлийг суралцагчид давтан үзэж, ойлгоогүй үлдсэн мэдлэгээ мэдэж авах боломжтой.	Багш суралцагчид цахим орчинд бүрэн суралцаж дасан зохицож чадаагүй.
3	Тонгоруу сургалтын аргыг түгээмэл ашигладаг.	Багш суралцагчдын аль аль нь цахим орчинд ажиллах, суралцах орчин бүрдээгүй.
4	Багшийн илтгэх ур чадвар нэмэгдсэн.	Багш суралцагчдын дунд амьд харилцаа дутмаг.
5	Шалгалтыг тусгай аппликэшн ашиглан нэгэн зэрэг авч дүгнэдэг.	Суралцагчдын цахим орчны оролцоо муу, камер, дуугаа хаагаад хичээлд идэвхтэй оролцохгүй байх хандлага их.
6	Суралцагчдын дэвтрийг засахад зарцуулах цаг багассан.	
7	Багш нарт өргөн боломж нээгдсэн.	
8	Багш болгон өөрийн цахим хичээлийн сантай болсон зэрэг нь судалгааны явцад харагдаж байна.	

ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнгээс дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

1. Тус сургуулийн багш нар цар тахлын үед цахим хичээлийг үр дүнтэй, өгөөжтэй болгохын тулд сургалтын шинэ программууд дээр ажиллах чадварыг бие даан суралцсанаар сургалтын үйл ажиллагаагаа явуулах өөрийн гэсэн платформтой болж, багш суралцагчид подкаст хийх тусгай аппликэшн ашиглан өөрсдийн санал бодлоо солилцож ажиллахын зэрэгцээ уламжлалт сургалтын аргуудыг орчин үеийн шинэ арга технологиудтай хослуулан сургалтыг оновчтой зохион байгуулсан байна. Энэ нь сургалтын чанар, хүртээмж, багш сургуулийн хамтын ажиллагааны үр дүнд эерэг нөлөө үзүүлжээ.
2. Сургуулийн удирдлагын зүгээс сургалтын чанарт ахиц гаргахын тулд багш нарт сар бүр дата худалдаж авах мөнгө, зарраг work программын бүтэн жилийн эрх, багш нарыг хичээлийн бус цагаар нэмэлт сургалтад хамрагдахад нь дэмжлэг үзүүлсэн. Суралцагчдыг мобиком компаниас өгсөн 3 сарын үнэгүй дата хэрэглэх эрхээр хангаж, сургалтын үйл ажиллагаанд хамруулсан байна. Дээрх ажлууд нь хамгийн бага зардлаар цахим хичээлийг үр дүнтэй, оновчтой зохион байгуулахад



THE CULTURAL WAY

ихээхэн дэмжлэгийг үзүүлжээ.

3. Цар тахал бидний хувьд байгалийн шалгарлыг даван туулах сорилт ч болж, олон зүйлд дасан зохицож, даван туулах хөгжлийн цохилт ч болж байна. Учир нь суралцагчид цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан, шинэ техник технологийг бие даан судалж, хичээл сургалтын үйл ажиллагаандаа хамрагдаж чаддаг болжээ. Гэвч тусгай хэрэгцээт суралцагч болон багш нарын нас, сэтгэхүй, танин мэдэхүйн онцлог, мэдлэг, чадвар, амьдрах орчны ялгаатай байдал, заадаг хичээлийн онцлог зэргээс шалтгаалж, цаашид улам сайжруулах хэрэгцээ шаардлага байгаа нь судалгаанаас ажиглагдлаа.

Ер нь “Алсын хараа – 2050” Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Монгол Улсын боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны 2021-2030 төлөвлөгөө, Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасны дагуу цаашид нийгэм болон дижитал технологийн эринд ажиллаж амьдрах, нийгмийн идэвхтэй оролцоотой, тасралтгүй хөгжих чадамжтай, хүмүүнлэг, ёс зүйтэй иргэнийг хөгжүүлэх нь боловсролын ирээдүйн хөгжлийн төлөвлөлтөд нийцэхүйц иргэн болон төлөвшиж чадахуйц байгааг харуулж байгаа тул цахим сургалтын орчныг боловсронгуй болгож, хөгжүүлэх нэн шаардлагатай юм.

ABSTRACT

The COVID-19 pandemic was first reported in November 2019, Wuhan, China. For Mongolia the first case of infection with the virus was detected on March 10, 2020.

We aimed to clarify how changes occurred in the social life of Mongolia during the pandemic, especially the learning status of students in the online education in the education sector, and the results of changes in pedagogy.

In this article results of the research on the e-education was presented which had been based on the analyze of the e-education activity of Construction Polytechnic College. We used the sociolinguistic field research method on the e-education of the college.

Keywords: *online lessons, virtual laboratory, digital technology, education*



THE CULTURAL WAY

НОМ ЗҮЙ

- Э.Уранбилэг, *Шинэ үг хэллэгийн толь*, Уб., 2021, 40 тал.
- Б.Халтар: *Замын-Үүд халдвар тархсан бүс болчихсон учраас Хятадын талаас болгоомжтой хандаж байна. Үүнийг бид хүндэтгэн үзэх ёстой*, Өдрийн сонин, 2020.12.18, Баасан, №248 (6614), V нүүр.
- "Хөгжлийн бэрхшээлтэй хүн" гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг; (*Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль*, Уб., 2016)
- БШУ-ны сайд Л.Цэдэвсүрэн: *Боловсролын цахим сургалт, технологи, контентыг анх удаа хуульчлах гэж байна*, Өдрийн сонин, 2020.12.30, Лхагва, №256 (6622), I нүүр.

Цахим эх сурвалж

<https://www.google.mn>.

<https://www.meds.gov.mn>

<https://www.savethechildren.mn>

<https://legalinfo.mn/mn/detail/11711>

<https://legalinfo.mn/mn/detail/372>

<https://mongoltoli.mn/dictionary/detail/92384>

<https://mongoltoli.mn/dictionary/detail/118156>

**МОНГОЛ УЛСЫН ОРЧИН ҮЕИЙН УРАН ЗОХИОЛЫН ДУНДАД УЛС ДАХЬ
СУДАЛГААНЫ ТУХАЙ ТОВЧ ӨГҮҮЛЭХ НЬ (ХОЁР)**

-1991-2000 оны хоорондох уран зохиолын судалгааны жишээн дээр

Уянга*

ХУРААНГУЙ

Тус өгүүлэлд дундад улсын уран зохиол судлаачдын монгол улсын орчин үеийн уран зохиолын тухай туурвин бичсэн өгүүлэл шүүмжээр гол судлагдахуунаа болгож, 1991-2000 оны хоорондох монгол улсын орчин үеийн уран зохиолын дундад улс дахь судалгааны байдлыг тодруулах оролдлого хийлээ. 1991-2000 оны хооронд монгол улсын орчин үеийн уран зохиолын дундад улс дахь судалгаа нь яруу найраг, жүжгийн зохиолоор голлон шинжлэгдэж бусад судалгаагаар дагалдах байдлаар шинжлэгдэнэ. Тус хугацаанд монгол улсын орчин үеийн уран зохиолын дундад улс дахь монгол хэлэн дэх судалгаа нь өрнөлтийн шатанд орсон боловч хятад хэлэн дэх судалгаа нь харин өдрийн од мэт цөөн ажээ.

Түлхүүр үгс: *Монгол улс, орчин үеийн уран зохиол, Дундад улс*

1991-2000 оны хоорондох монгол улсын орчин үеийн уран зохиолын дундад улс дахь судалгаа нь голдуу тууж, яруу найраг, кино жүжгийн судалгаанд төвлөрч, бусад судалгаанд дагалдан судлагдаж байжээ. Өмнөх өгүүлэлд монгол улсын орчин үеийн туужийн зохиолын дундад улс дахь судалгааг тусгайлан шинжилсэн учраас тус өгүүлэлд монгол улсын орчин үеийн яруу найраг, жүжгийн зохиол ба бусад судалгаанд суурилан шинжилье. 1991-2000 оны хооронд монгол улсын орчин үеийн яруу найраг, жүжгийн зохиол ба бусад судалгаа нь ном хэвлэл ба судалгааны өгүүллээр зууч болгон шинжлэгдэж байжээ.

Нэг. Яруу найргийн судалгаа

Монгол улсын орчин үеийн яруу найргийн судалгаа нь голдуу нөлөө судлал, сэдэвлэхүүний тухай судлал, урлах аргын судалгаанд суурилан шинжлэгдэж байв.

* ӨМИС, Монгол Судлалын Дээд Сургууль, Дундад улсын хэл утга зохиол судлалын докторант



1. Нөлөө судлал

Нөлөө судлалын арга бол харьцуулсан уран зохиолын чухал нэгэн судалгааны арга болно. “Францууд анхны харьцуулсан утга зохиолын баг болно, тус судалгаанд Верман (Veerman), Фернанд Балденспергерс (Fernand Baldenspergers), Пан Тайгем (Pvan Tieghem) зэрэг олон нэрт судлаачид байж, эдгээр хүмүүс нь харьцуулсан утга зохиолын шинжилгээний салбар бий болох ба хөгжлийн явцад чухал нөлөө үзүүлжээ. Тэд нарыг нэг баг хэмээн нэрлэсний шалтгаан нь франц хүнд байгаа биш, харин нөлөө судлалыг баримталсанд оршино, иймээс францын багийг бас “нөлөө судалгааны баг”¹ гэж нэрлэнэ. 1991-2000 оны хооронд, монгол улсын орчин үеийн яруу найргийг дундад улсад нөлөө судлалын аргаар судалж байжээ. У.Чиглэлийн “Зохист аялгууны толь”-ийн хос төгөлдөр чимэг хийгээд түүний Д.Нацагдоржийн шүлэг дэх зарим илрэл”² хэмээх өгүүлэлд Д.Нацагдоржийн тус биеийн шалтгаан ба тухайн цаг үеийн нийгэм ахуйн шалтгаанаас болж, өнгөрсний бичгийн шүлэг ба энэтхэг төвөдийн шүлгийн онолын нөлөө бүхий шарын шашны чиглэлийн шүлгүүдийн нөлөөг зохих хэмжээний ухамсартайгаар хүлээн авч өөрийн зохиолдоо ашигласан байдлыг өгүүлж Д.Нацагдоржийн шүлэгт илэрсэн хос төгөлдөр чимгийн бодит хэрэглээг шинжин, анхдугаар шадын тэргүүнд байх хос төгөлдөр чимэг, эс завсардсан хоёрдугаар шадын тэргүүнд байх хос төгөлдөр чимгийн хэрэглээ, эс завсардсан гуравдугаар шадын хос төгөлдөр чимгийн хэрэглээ, эс завсардсан дөрөвдүгээр шадын эхнээ орших хос төгөлдөр чимгийн хэрэглээ, үйлдэхүй бэрх бусад орноо байх хос төгөлдөр чимгийн шадын дундах давталт, үйлдэхүй бэрх бусад орноо байх хос төгөлдөр чимгийн шадын сүүл давталт, анхны хоёр шадын эхэнд байх завсардсан хос төгөлдөр чимэг, шадын сүүлд орох завсардсан хос төгөлдөр чимэг, үйлдэхүй бэрх бусад орноо байх хос төгөлдөр чимгийн тухай шинжлэв. Үүний дагуу бас түүний яруу найргийн ардын дуу, үлгэр холбоо, баатарлаг туулиас шим хүртсэн байдлыг задлан шинжилжээ. Тус судалгаа нь харьцуулсан уран зохиолын нөлөө судлалын аргыг сайн хэрэглэсэнээрээ онцлогдоно.

Үүнээс гадна бас энгийн харьцууллын талын судлал ч ажиглагдана. У.Чиглэлийн “Дөрвөн цаг болон Манай монгол дөрвөн улирлын үзэмжийг адилтгах нь”³ гэх өгүүлэлд монгол улсын алдарт зохиолч Д.Нацагдоржийн “Дөрвөн цаг” ба Өвөр монголын орчин үеийн уран зохиолч Сайчунгаан “Манйа монголын дөрвөн улирлын үзэмж” хэмээх зохиолыг энгийн харьцуулан судлах

¹杨乃乔：《比较文学概论》，北京大学出版社，2005年5月，173页。

² У.Чиглэл. Зохист аялгуун толийн хос төгөлдөр чимэг хийгээд түүний Д.Нацагдоржийн шүлэг дэх зарим илрэл. МХУЗ., 1999 №2 т 46

³ У.Чиглэл. Дөрвөн цаг ба Манай монголын дөрвөн улирлын үзэмжийг адилтгах нь. ӨМБИСЭШС., 1999 №3 т 105



THE CULTURAL WAY

аргаар адилаватар шинж ба өвөрмөц онцлогийг тодруулах оролдлого хийжээ. Тус өгүүлэл хоёр зохиолын зохиогдсон цаг, гарчиг, агуулгын адил тал ба хэл хэллэг дүр дүрслэлийн ялгаа, хэлбэр бадаг бүтцийн ялгаа, хэв намба /хэв маяг/-ын бүтээлтийн ялгааг харьцуулан шинжилжээ.

Монгол улсын орчин үеийн яруу найргийн судалгаанд харьцуулсан уран зохиолын нөлөө судалгаанаас гадна бас монгол аман зохиолын бичгийн уран зохиолыг нөлөөлсөн судалгааны өгүүлэл ч илэрсэн байна. Монгол аман зохиол нь монгол бичгийн уран зохиолын чухал сурвалж мөн. Бичгийн уран зохиол бий болсноос өнөөдөр хүртэл аман зохиол нь яруу найргийг адил бус хэмжээнд нөлөөлсөөр ирэв. Дундад улсад монгол улсын орчин үеийн яруу найргийг шинжлэн судалсан судалгааны өгүүлэл бага бус байна. Алтангадасын “Монгол ардын аман зохиол хорь гучаад оны монгол улсын шинэ шүлгийг нөлөөлсөн нь”⁴ хэмээх өгүүлэлд уламжлалт соёл, шарын шашин нь монгол улсын шинэ шүлгийн агуулга, үзэл санаа, аяс айзам, мөр бадаг, үгэнд нөлөөлснөөр барахгүй магтаал дуу, бөө мөргөлийн дуудлага, баатарлаг туульс нь монголын шинэ шүлэгт чухал нөлөө үзүүлсэн гэж дүгнэв.

2. Сэдэвлэхүүний тухай судалгаа

Монгол улсын орчин үеийн утга зохиолд эх оронч сэдэвт яруу найраг цөөн бус ажиглагдана. Ч.Эрдэнэбаярын “Монголын орчин үеийн эх орон сэдэвт яруу найргийн хөгжлийн товч”⁵ гэх өгүүлэлд монгол улсын орчин үеийн эх оронч сэдэвт яруу найргийн хөгжлийг магтаалын шинжит, хөгжлийн шинжит, бодлын шинжит гэх дарааллаар яруу найргийн хөгжлийн түүхийг шинжлэсний хамт энэхүү хөгжлийн дарааллаас монгол улсын бүх яруу найргийн хөгжлийн жам ёсыг гаргахаар хичээжээ. Тус өгүүлэл нь монгол улсын орчин үеийн яруу найрагчийн зохиол бүтээлээр жишин тайлбарлаж, монголын улсын яруу найргийн хөгжлийн байдал ба тэдний бичлэгийн онцлогийг хураангуйлан гаргаснаар онцгойрно.

Л.Хасбаатарын “Эмэгтэйчүүдийн чөлөөлөлт хийгээд Р.Чойном”⁶ хэмээх өгүүлэлд Чойном жич түүний “Үнэртэн, оо тэргүүтний тухай”, “Би эхнэр авахгүй”, “Монгол бүсгүй”, “Нанчидын ширээний хавьд уншсан зохиол” зэрэг шүлгүүдэд суурилан түүний бүсгүйчүүдэд хандах үзлийг хураангуйлан, ирээдүйн эмэгтэйчүүд үнэт соёл үсэг бичгээ нандигнан явахыг уриалав.

⁴ Алтангадас. Монгол ардын аман зохиол 20, 30-аад оны монгол улсын шинэ шүлгийг нөлөөлсөн нь. БХҮндСЭШС., 1993 №3 т 57

⁵ Ч.Эрдэнэбаяр. Монголын орчин үеийн эх орон сэдэвт яруу найргийн хөгжлийн товч. ӨМИСЭШС., 2000 №1 т 78

⁶ Л.Хасбаатар. Эмэгтэйчүүдийн чөлөөлөлт хийгээд Р.Чойном. Алтан гарди., 1996 №4 т 67



THE CULTURAL WAY

Л.Хасбаатар бас “Чойном судлал хийгээд түүний шүлэг” гэх судалгааны бүтээлээ 1996 онд ӨМСХХ-оос 1000 дэвтэр хэвлүүлэн тархаав. Тус бүтээл бол яруу найрагч Чойномын намтар, уран бүтээлийг системтэй шинжилсэн тусгай судалгааны бүтээл болно. Тус бүтээл нь дундад улсын уншигчдад Чойномын тухай ойлголтыг гүнзгийрүүлснээр барахгүй түүний яруу найргийн дундад улс дахь тархалтад ихэд нөлөөлжээ.

3. Урлах аргын судалгаа

Ямарваа зохиол бүтээл нь адил бусын урлах аргыг сайн хэрэглэж байж уншигчдын сонирхлыг татаж чаддаг. С.Өлзийбатын “Монголын яруу найраг дахь байгалийн дүрслэлээс сонирхох нь”⁷ гэх өгүүлэлд Ц.Дамдинсүрэнгийн “Монгол нутаг”, С.Дашдооровын “Их говийн өглөөн зураг”, Б.Явуухулангийн “Нуга дахь зуны өглөө”, “Намрын нуур руу чулуу юунд шидлээ”, Б.Доржпаламын “Хил дээр бичсэн шүлэг”, Д.Нямаагийн “Шөнийн талд адуу янцгаана”, Д.Урианхайн “Бороотой үүрийн зураг”, “Цэцэг халууцах зун”, “Одод холдох өвөл” зэрэг яруу найрагт илэрсэн ялгам сайхан байгалийн өнгө будаг, амьд хөдөлгөөнт хэлбэр төрх, олон янзын чимээ авиан тухай шинжилжээ. Үүнээс монголын яруу найрагчид монголын өвөрмөц байгаль орчноо илтгэх өвөрмөц арга барилыг өөрөө шүүн олсныг таньж болно.

Ч.Чойдандарын “Д.Нацагдоржийн Дөрвөн цаг шүлгийн тухай”⁸ хэмээх өгүүлэлд “Дөрвөн цаг” шүлгийн бичигдсэн цаг, уралдаанд оролцсон байдал, хичээлийн сурах бичигт сонгогдсон тухай шинжлэсний зэргээр шүлгийн агуулга хэлбэрт дөрвөлжилсөн шинэ бий болсон шалтгааныг задалж, зохиолчийн шүлэг бичих үеийнхний төлөвлөгөө зургийг нийтлэн, сүүл холболтын урлагийн амжилт ба амьдралтай нягт холбон дүрсэлсэн гүнзгий утга санааг илэрхийлжээ.

С.Хас-Өлзийгийн “Б.Лхагвасүрэнгийн шүлгийн нууцлал – үйлт уран дүр”⁹ хэмээх өгүүлэлд зохиогчоос Б.Лхагвасүрэнгийн шүлэг нь туулийн үйлт ахуй дахь байнгын шинжийг уянга шүлгийн агуулгад ер бусын бүтээлч шидээр шилжүүлэн өвөрмөц хэв маяг бүхий жавхаалаг, уянгалаг, хөгжимт, хөдөлгөөнт амьд дүр дүрслэлийн хэвийг цогцлоожээ хэмээн үзэж, Б.Лхагвасүрэнгийн уянгын шүлэгт илэрсэн үйлт уран дүрийн тухай шинжлэв. Сайнцогтын “Б.Лхагвасүрэнгийн шүлэг дэх Үр могой хэмээх санаа дүрийн бэлгэдэл

⁷ С.Өлзийбат. Монголын яруу найраг дахь байгалийн дүрслэлээс сонирхох нь. Алтан түлхүүр., 1991 №2 т 40

⁸ Ч.Чойдандар. Д.Нацагдоржийн Дөрвөн цаг шүлгийн тухай. БХҮндСЭШС., 1991 №1 т 35

⁹ С.Хас-Өлзий. Лхагвасүрэнгийн шүлгийн нууцлал-үйлт уран дүр. Алтан түлхүүр., 1994 №1 т 75



THE CULTURAL WAY

шинж”¹⁰-д үр могой гэх санаа төрөхийн бэлгэдэл шинжийг эх хөвгүүний харьцаа ба түүнд онцгой оршдог удвис комплексоос тайлбарлаж, тус шүлэгт нуугдаж байх далд хүчийг сэдэн гаргажээ. Тус судалгаанд Б.Лхагвасүрэнгийн өвөрмөц онцлог бүхий бичлэгийн онцлогийг судлаачдад таниулав.

Б.Буяндэгжрэхийн “”Б.Явуухулангийн яруу найргийн урлах эрдмийн тухай”¹¹-д зүйрлэх, шууд, давуулах, бясалгах, амьдчилан, бэлгэдэх, хэлхээлэх, зэрэгцүүлэх, давтах, дэлгэрүүлэх, ерөөх зэрэг уламжлалт яруу найргийн шүлэглэх маягаар Б.Явуухулангийн уянгын шүлгүүдийг задлан шинжлэсний зэргээр монгол яруу найргийн шинэ урсгал, уламжлал шинжлэлийн харьцаа, шүлгийн чадавх чанар тухай шинжилжээ. Үүнээс монгол яруу найргийн өвөрмөц онцлог ба урлах эрдмийг таньж болно.

Хоёр. Кино жүжгийн судалгаа

1991-2000 оны хооронд дундад улсад монгол улсын орчин үеийн тууж, яруу найргийн тухай судалгаа байснаар барахгүй бас кино жүжгийн тухай судалгаа хаа нэг илэрч байжээ. 1995 оны 10 сарын 20-ны өдрийн Өвөр монголын их сургуулийн сонинд Улаан-Одын “Монгол улсын кино урлагийн тухай өгүүлэх нь”¹² гэх өгүүлийг нийтлэв. Тус өгүүлэлд монгол улсын кино урлагийн хөгжлийн тухай тойм тоочин, 90-ээд онд хамтран зураг авч байсан кино, орчуулгын кино, шагнал хүртсэн киноны талаар танилцуулан, бүтээсэн киноны амжилт ба дутагдал, ирээдүйн киног хөгжүүлэх арга бодлогын тухай өгүүлэв.

Бай Ган-ий “Д.Намдагийн урлах эрдэм”¹³ гэх өгүүлэлд Д.Намдагийн германд очин суралцаж, театрын урлагтай ойртож байснаас тэрхүү урлагийн ажил хийх болсон бүх явцыг дэлгэн өгүүлж, түүний “Тэмцэл” хэмээх анхны жүжгээ бичихээс аваад “Амь ба амьдралын үнэ”, “Шинэ зам”, “Сүрэг чоно” зэрэг театрын бүтээлтэй болсон ба туужийн зохиол бичсэн үе ба “Цаг төрийн үймээн”-ий тухай өгүүлэв. Тус өгүүлэл Д.Намдагийн хүүрнэл зохиолууд нь бодит амьдралын үнэн тодорхой баримт дээр тулгуурлан бүтээсэн ахуйч шинжийг илэрхийлсэнээрээ онцгойрно.

¹⁰ Сайнцогт. Б.Лхагвасүрэнгийн шүлэг дэх Үр могой гэх санаа дүрийн бэлгэдэл шинж. Алтан түлхүүр., 1993 №3 т 46

¹¹ Б.Буяндэгжрэх. Б.Явуухулангийн яруу найргийн урлах эрдмийн тухай. Алтан түлхүүр., 1992 №3 т 55

¹² Улаан-Од. Монгол улсын кино урлагийн тухай өгүүлэх нь. ӨМИСС., 1995.10.20

¹³ Бай Ган. Д.Намдагийн урлах эрдэм. ӨМҮНБДСЭШС., 1994.1 т 52



THE CULTURAL WAY

Жан Юньсы-ийн “Илжиг биш, морь биш, луус гэсэн зүгээр байна ... – Мао тэргүүлэгчээс Учиртай гурван толгойг шүүсэн тухай эргэцүүлэл”¹⁴ хэмээх өгүүлэлд, зохиогчийн Учиртай гурван толгойг бээжин ши /жүжиг/ болгон тоглосон явцаа тоочихын хамт хожмын хүмүүсийн тус жүжигт “Илжиг биш, морь биш, энэ чинь чухам юу болох вэ?” гэх үнэлэлтэд чиглүүлэн Мао тэргүүлэгчээс “Илжиг биш, морь биш, луус боловч зүгээр байна” гэх хариулт өгсөн тухай хураангуйлан үнэлэв. Тус удаагийн Учиртай гурван толгойн тухай тоглолт нь хожмын ши жүжгийн тоглолтод ихээр нөлөөлсөн байна.

Гурав. Бусад судалгаа

1991-2000 оны хоорондох монгол улсын орчин үеийн утга зохиолын дундад улс дахь судалгаанд тууж, яруу найраг, жүжгийн зохиолын тухай судалгааа ажиглагдахаас гадна бас монгол улсын орчин үеийн уран зохиолын түүхийн судалгаа, 90-ээд оны уран зохиолын үзэгдэл судалгаа гэх мэтээр олон хэлбэрийн судалгаа ажиглагдана.

Ч.Чойдандар, Жамбын найруулсан “Монгол улсын орчин үеийн уран зохиол”¹⁵-ыг ӨМСХХ 1998 онд нийт 2500 дэвтэр хэвлүүлэн тархаав. Тус бүтээл монгол улсын орчин үеийн соёл сурга хүмүүжлийн тойм, монгол улсын орчин үеийн уран зохиолын хөгжлийн тойм, монгол улсын уран зохиолыг судалсан тойм хэмээх гурван хэсгээс бүрдэж, Д.Нацагдорж, Д.Намдаг, Ц.Дамдинсүрэн, С.Удвал, Ц.Гайтав, Б.Явуухулан, Ч.Лодойдамба, С.Буяннэмэх, Д.Сэнгэ, Б.Ренчин, Ч.Чимэд, С.Эрдэнэ, Д.Пүрэвдорж, Д.Мягмар, Л.Түдэв, Р.Чойном, Б.Лхагвасүрэн зэрэг зохиолчдын үйл амьдрал ба төлөөлөх чанартай зохиол бүтээлийг тайлбарлан танилцуулжээ. Тус бүтээлийн тухай зарим эрдэмтэд “Монгол улсын орчин үеийн уран зохиолыг олон хэсэг бүлэг, ихээхэн хуудас хэмжээгээр системтэйгээр үнэлэн танилцуулж, шинжлэн судалсны хамт бүх цаг үеийн төлөөлөгч зохиолч содон бүтээлийг шилэн сонгож, хөгжлийн зам мөрийг бусдачаар харуулан тусгасны хувьд бүтээлч шинжтэй, дэгжин шинжтэй ... их дээд сургуулийн хичээл хүмүүжилд зориулагдсаны хамт өргөн олон жирийн уншигч, судалгааны ажилтнуудын хандлага болгохын хувьд гарын авлага шинжтэй, хэрэглээний шинжтэй”¹⁶ гэж үзнэ. Тус номын хүрэлцэхгүй талыг зарим эрдэмтэд “зохиолын задлал, хэл хэллэг, нэр томьёо зэрэг нь бүр монгол хуучин судлал загварыг хэвчлэн нүүлгэж авсан нь баахан давамгайлрч, өөрийн онцлог бүхий задлал, хэл хэллэг нэлээд торгодсон юм”¹⁷ гэж үзжээ. Мөн зарим

¹⁴ Жан Юньсы. Илжиг биш, морь биш, луус гэсэн зүгээр байна. Хятад жүжиг, 1992 №7 т 24

¹⁵ Ч.Чойдандар, Жамба. Монгол улсын орчин үеийн уран зохиол. ӨМСХХ., 1998

¹⁶ Б.Сэцэн. Монголын орчин үеийн уран зохиол номыг судлан хэлэлцэх хурлын тухай татлага. ӨМНШУ, 1991 №1 т 124

¹⁷ Сүег. Монголын орчин үеийн уран зохиолын тухай хэдэн бодол. МХУЗ., 1999 №2 т 67



THE CULTURAL WAY

эрдэмтэд “уран зохиолд зохиолчийн амьдрал үйлийг танилцуулахдаа ч дундад улсад ойрын жил хэвлэгдсэн олон материалыг ашиглан бичсэн байтал хамгийн бүтээлч хөдөлмөр шаардагдаж зохиол бүтээлийн шүүмж сонирхлыг товч түүх ба тойм зэргээс шууд сонгон найруулан авах аргаар бичсэн нь арай зохихгүй. Уран зохиол ингэж монгол ард улсын уран зохиолын тойм (Буяндэгжрэх)-ийн шууд ашиглан туурвих онцлогийг мөрдөн хэрэгжүүлсэн нь өнөөдрийн утга зохиолын түүх найруулах арга зарчим буюу цаашлаад эрдэм шинжилгээний дүрэмжилд үл нийцэх зүйлс болох нь дамжиггүй”¹⁸ гэжээ.

Ван Мандаагийн “Монгол улсын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэл”¹⁹-ийг 1999 онд ӨМСХХ 1000 дэвтэр хэвлэж тархаав. Тус бүтээлд С.Буяннэмэх, Ш.Аюуш, М.Ядамсүрэн, Ч.Дашням, Д.Чимэд, Б.Содном, Ц.Дамдинсүрэн зэрэг хүмүүсийн намтар ба зохиол бүтээл, өгүүлэл шүүмжлэлийн тухай танилцуулжээ. Тус бүтээлд сонгосон өгүүлэл шүүмжлэл бүхнийг монгол улсын сонин сэтгүүлээс сонгон буулгажээ. Энэ нь монгол улсын уран зохиолын дундад улс дахь судалгаанд нэн олон судалгааны сураг чимээгээр ханган, монгол уран зохиолын онол шүүмжлэлийн түүхэн судалгааг гүнзгийрүүлж чадав.

Ван Мандаагийн “Монгол улсын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй”²⁰-г 2000 онд ӨМАХХ 1500 дэвтэр хэвлүүлэн тархаав. Тус номын тэргүүн анги нь “Зохиолчдын судлал шүүмжлэлийн бүтээл”, “Оршил, мэдээ, тэргүүн өгүүлэл, сэтгүүлчдийн өгүүлэл, сэтгэлийн зорилт сэлт тэргүүн” гэх хоёр бүлгээс бүтэж Д.Нацагдорж, Ц.Дамдинсүрэн, Б.Содном зэрэг зохиолчдод холбогдох бүх зүйлийн мэдээллийг тэмдэглэв. Судлал шүүмжлэлийн бүтээл нь хувьсгалын уран зохиол, театрын урлаг, жүжгийн зохиол ба тууж зохиол, яруу найраг жич аман зохиолын хүрээг хамарснаар барахгүй бас хуурын үлгэрийг ч багтаан судалжээ. Уг бүтээл нь ардчилсан хувьсгалын үед бичигдсэн болохоор өнөөдөрт хялбар олдохгүй болсон ховор чухаг судалгааны эх хэрэглэгдэхүүнийг ашигласнаараа онцгой юм. Энэ нь дундад улсын судлаачдын гарын авлага болсон байна.

Хуан Фучюнь Син-ий “Ардын аман зохиолын монгол улсын хорь гучаад оны уран зохиолд үзүүлсэн нөлөөг шинжлэх нь”²¹ гэх өгүүлэлд магтаал дууллаас шүлэг, үлгэрээс өгүүллэг, харилцаа дуунаас жүжиг бүрэлджээ гэж

¹⁸ С.Урсгал. Монгол утга зохиолын түүх зүйн судлал. ЛяҮнХХ., 2011 т 99

¹⁹ Мандаа. Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэл. ӨМСХХ., 1999

²⁰ Мандаа. Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй. ӨМАХХ., 2000

²¹ 黄埔群星: 《民间文学对蒙古国二三十年代文学影响的原因初探》, 解放军外语学院学报, 1995年4期, 99页



THE CULTURAL WAY

дүгнэн, бичгийн уран зохиолын ардын аман зохиолоос нөлөө олсон шалтгааныг “ардын аман зохиол нь бичгийн уран зохиолыг нөлөөлөх нь монгол уран зохиолын хөгжлийн түүхийн уламжлал мөн ... нийгэм соёлын байдал нь монголын XX зууны утга зохиолыг ардын аман зохиолоос суралцуулах, ашиглах ба хэрэглэх байдлыг тогтоожээ ... улс төрийн шаардлага нь зохиолчдыг товч ойлгомжтой, хялбар амар зохиол бүтээл байхыг шаарджээ ... ардын аман зохиолыг голлон үзэж, хуучин бичгийн уран зохиолыг хөнгөвчлөн үзэх үзэгдэл нь зохиолчдыг ардын аман зохиолын нөлөөг хөдлөнгүйгээр хүлээн авах болгожээ” хэмээн хураангуйлав.

Сарнаагийн “Нийгмийн шилжилтийн үеийн монгол улсын уран зохиол”²² хэмээх өгүүлэлд 90-ээд оны уран зохиолын үзэгдэл, төлөөлөгч хэдэн эрдэмтэн ба зохиол бүтээл, уран зохиолын үзэгдлүүдийн тухай адил бусын үзэл ойлголтыг танилцуулжээ. Тус өгүүлэл нь монгол улсын 90-ээд оны орчин үеийн уран зохиолын шинэ үзэгдэл, адил бусын үзэл ойлголт, төлөөлөгч онолч, судалгааны бүтээлийг шинжилснээрээ ялгарна.

Л.Батжаргалын “Ерээд оны монгол улсын уран зохиол дахь шинэ хандлага”²³ гэх өгүүлэлд, өнгөрсөнд монгол улсын уран зохиол нь зөвхөн улс төржиж үзэл сурталжсан зохиол байсан бол одоо соёл урлагийн шинэ уур амьсгал орж, модернист чиглэл жич бусад олон урсгал чиглэлүүдийн гоо зүйгүн ухааны онол үндэслэл ба туурвилын арга, үзэл санааны онцлог байдал тодорхой туссан соёл урлагийн олон ургалч үзэл бүрэлдсэнийг хураангуйлан шинжлэв.

²² Сарнаа. Нийгмийн шилжилтийн үеийн монгол улсын уран зохиол. МХУЗ., 2000 №4 т 58

²³ Л.Батжаргал. 90-ээд оны монгол улсын уран зохиол дахь шинэ хандлага. Дэлхийн утга зохиол, 1998 №4 т 195



THE CULTURAL WAY

ДҮГНЭЛТ

1991-2000 оны хооронд монгол улсын орчин үеийн уран зохиолын дундад улс дахь судалгаа нь туужийн зохиолын судалгаагаар онцлогдож байснаас гадна бас яруу найраг, кино зохиолын судалгаанд төвлөрч, ерөнхийлсөн чанартай судалгаагаар дэдлэж байжээ. Тус судалгаа нь Б.Явуухулан, Б.Лхагвасүрэн, Р.Чойном зэрэг зохиолчдын судалгаанд төвлөрч, голдуу харьцуулсан утга зохиолын нөлөө судлал, уран зохиолын сэдэвлэхүүн, урлах арга зэргийг онцлон шинжлэв. Үүнээс гадна монгол улсын орчин үеийн уран зохиолыг бодит амьдралын талаас шинжилж байсныг монгол улсын орчин үеийн утга зохиолын дундад улс дахь судалгааны бас нэгэн ололт гэж ойлгож болно. Үүнд монгол улсын орчин үеийн уран зохиолын хятад хэлэн дэх судалгаа нь өдрийн од шиг цөөн ажээ.

ABSTRACT

This dissertation focuses on Chinese writers' comments on modern Mongolian literature, and tries to clarify the research situation of modern Mongolian literature in China from 1991 to 2000. From 1991 to 2000, the study of Mongolian modern literature in China focused on poetry and drama, while other studies were secondary. In this period, the study of Mongolian modern literature works in Mongolian language of China entered a climax stage, but the study of Chinese language was few.

Key words: *Mongolian, modern literature, China*



THE CULTURAL WAY

НОМ ЗҮЙ

1. С.Урсгал. Монгол утга зохиолын түүх зүйн судлал. ЛяҮнХХ., 2011
2. Ч.Чойдандар, Жамба. Монгол улсын орчин үеийн уран зохиол. ӨМСХХ., 1998
3. Ван Мандаа. Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэл. ӨМСХХ., 1999
4. Ван Мандаа. Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй. ӨМАХХ., 2000
5. У.Чиглэл. Зохист аялгуун толийн хос төгөлдөр чимэг хийгээд түүний Д.Нацагдоржийн шүлэг дэх зарим илрэл. МХУЗ., 1999 № 2
6. У.Чиглэл. Дөрвөн цаг ба Манай монголын дөрвөн улирлын үзэмжийг адилтгах нь. ӨМБИСЭШС., 1999 № 3
7. Алтангадас. Монгол ардын аман зохиол 20, 30-аад оны монгол улсын шинэ шүлгийг нөлөөлсөн нь. БХҮндСЭШС., 1993 № 3
8. Ч.Эрдэнэбаяр. Монголын орчин үеийн эх орон сэдэвт яруу найргийн хөгжлийн товч. ӨМИСЭШС., 2000 № 1
9. Л.Хасбаатар. Эмэгтэйчүүдийн чөлөөлөлт хийгээд Р.Чойном. Алтан гарди., 1996 № 4
10. С.Өлзийбат. Монголын яруу найраг дахь байгалийн дүрслэлээс сонирхох нь. Алтан түлхүүр., 1991 № 2
11. Ч.Чойдандар. Д.Нацагдоржийн Дөрвөн цаг шүлгийн тухай. БХҮндСЭШС., 1991 № 1
12. С.Хас-Өлзий. Лхагвасүрэнгийн шүлгийн нууцлал-үйлт уран дүр. Алтан түлхүүр., 1994 № 1
13. Сайнцогт. Б.Лхагвасүрэнгийн шүлэг дэх Үр могой гэх санаа дүрийн бэлгэдэл шинж. Алтан түлхүүр., 1993 № 3
14. Б.Буяндэгжрэх. Б.Явуухулангийн яруу найргийн урлах эрдмийн тухай. Алтан түлхүүр., 1992 № 3
15. Улаан-Од. Монгол улсын кино урлагийн тухай өгүүлэх нь. ӨМИСС., 1995.10.20
16. Бай Ган. Д.Намдагийн урлах эрдэм. ӨМҮнБДСЭШС., 1994.1
17. Жан Юньсы. Илжиг биш, морь биш, луус гэсэн зүгээр байна. Хятад жүжиг, 1992 № 7
18. Б.Сэцэн. Монголын орчин үеийн уран зохиол номыг судлан хэлэлцэх хурлын тухай татлага. ӨМНШУ, 1991 № 1
19. Сүег. Монголын орчин үеийн уран зохиолын тухай хэдэн бодол. МХУЗ., 1999 № 2
20. 黄埔群星: 《民间文学对蒙古国二三十年代文学影响的原因初探》, 解放军外语学院学报, 1995年4第期
21. 杨乃乔: 《比较文学概论》, 北京大学出版社, 2005年5月
22. Сарнаа. Нийгмийн шилжилтийн үеийн монгол улсын уран зохиол. МХУЗ., 2000 №4
23. Л.Батжаргал. 90-ээд оны монгол улсын уран зохиол дахь шинж хандлага. Дэлхийн утга зохиол, 1998 № 4

УРИАНХАЙН ХОШУУДЫН ГАЗАР НУТГИЙН ТҮҮХИЙН АСУУДАЛД

(XIX зууны сүүлч XX зууны эхэн үе)

Л.Одзаяа*

ХУРААНГУЙ

Энэхүү өгүүлэлд Манжийн эрхшээлийн үед Алтайн урианхайн нутагт хасагуудад газар түрээслэн суух зөвшөөрөл олгосноор, нутгийн уугуул иргэд болон хасагуудын дунд газар нутгийн маргаан дэгдэх болсон. Хожим Олноо өргөгдсөн Монгол Улсын үед хасагууд Монголын төрд дагаар орж уг нутагт амьдрах эрхтэй болсон үед ч тэд нутгийн ард иргэдтэй нутаг бэлчээр булаацалдан хэрхэн тэмцэж байсныг архивын эх сурвалж, судалгааны бусад бүтээлүүдэд тулгуурлан өгүүлэх болно.

Түлхүүр үгс: *Урианхайн хошуу, газар нутаг, нүүдэл суурьшил*

Хасагууд Монголд нүүдэллэн ирж Алтайд нутаглах болсон нь

Хаант Орос улс XVIII зууны дунд үеэс Дундад Азийг түрэмгийлж, хот тосгодыг олноор байгуулж эхэлжээ. Улмаар Дундад Ази дахь нүүдэлчин олон овог аймгууд дотроос хагасуудыг эзэрхэн дагаар оруулж байлаа. Үүнийг эсэргүүцсэн хасагуудын зарим хэсэг нь нутаг орноосоо дайжин 1767 оноос хөрш зэргэлдээ Чин гүрний баруун хязгаар луу буюу одоогийн Шинжаан руу нүүдэллэжээ. Ингээд Шинжааны хойд бүс нутагт Монголтой хил залгаа Алтай, Тарвагатай, Ил зэрэг гурван аймагт голлон суурьшин нутаглах болов.

Орос, Хятадын хооронд байгуулсан 1864 оны "Хятад, Оросын баруун хилийг тодруулах тухай" Петербургийн хэлэлцээрээр хэдэн зууны турш Дундад Азийн зарим нутагт суурьшиж байсан хасагуудыг оршин суугаа нутгийн хамт Орос, Хятад улсуудад хуваан харьяалуулж, улмаар "Оросын казах", "Хятадын казах" хэмээн нэрлэж байв. Ийнхүү Алтай, Тарвагатай, Тянь-Шань нурууны хасагууд нь Чин улсын харьяа Шинжаан Уйгарын хязгаарт үлджээ. XIX зууны дунд үеэс Шинжаан дахь хасагуудын хүн ам, мал ахуй өсч бэлчээр нутаг булаацалдан улмаар Ховдын хязгаар луу оторлон өвөлжих болжээ. Ийнхүү 1860-аад оны үеэс Ховдын хязгаарт хасагууд хэсэг хэсгээр ирж амьдрах болжээ.

* ДХИС, Эрх зүй, Нийгмийн ухааны сургуулийн багш, цагдаагийн хошууч



THE CULTURAL WAY

Алтайн урианхайн нутагт хасагууд \казак\ нүүдэллэн ирсэн тухай дагнан судалсан Монголын эрдэмтэд бараг байхгүй байна. Хасагууд Монгол улсын газар нутагт анх хэрхэн орж ирсэн талаар 1924 оны Улсын анхдугаар Их хурлын илтгэлд дурдахдаа: “...урьд Чин улсын үед хар хасаг чантуу орж ирснийг хаан эзний зарлигаар манай нутагт багтаан суулгаж, жил бүр өвс бэлчээрийн хөл, тэмээ, адуу, үхэр, хонь тус бүрээс нэг зуугаас нэгжгээдийг хураан авч бас хасаг хүмүүс тариа тарихад тариалангийн хөлсийг зүй зохисоор тусгай хураан авч байгаад 1926 оноос бэлчээр, тариалангийн хөлс хураахыг зогсоож, Алтайн урианхайн нутгаас Казах хошуудад газар нутаг олгох бодлого хэрэгжүүлж эхэлсэн”¹ хэмээн тэмдэглэжээ.

Тийнхүү Монгол нутагт нүүдлэн ирсэн хасагууд хэзээ, хаана, хэний бүрэлдэхүүнд байсан тухай түүхч Х.Силим ийнхүү өгүүлжээ. Тэрбээр “Казахын хант улс” гэж тусдаа байсан бөгөөд Зүүнгартай нэгэн үе хил залгаж, байлдан явсан бөгөөд харин түүний дараа Манжид эзлэгдэж, Манжийн бүрэлдэхүүнд багтаж, засаг захиргааны хувьд хошуудад хуваагдаж, хошууг үхэр да захирдаг байсан. Хожим Чин улсын дотор гарсан бослого хямралын учраар Шинжааны казакуудын нэг хэсэг нь Алтайг давж, Ховдын хязгаарт нүүн ирсэн. Гэвч Монголын баруун хязгаарт суурьшсан казакуудыг харьяа ноёд нь хойноос нь хөөж ирээд алах талах, дээрэмдэх зэргээр амар заяа үзүүлэхгүй байсны зэрэгцээ “Шар сүм” дэх Манж амбан, нутгийн урианхайн ноёдын дарлал мөлжлөгт нэрвэгдэж байсан боловч Монгол нутагт тэд суурьшжээ”² хэмээн бичжээ. Улмаар казах түмний нэг хэсэг аргагүйн эрхэнд умард зүгт Алтайн нурууг даван нүүдэллэсэн гээд ...Монголын газар нутагт орж ирсний дараа тэдний байдал хүнд байсныг бичжээ. Монгол болон хасагийн судлаачдын зарим бүтээлд Шинжаанд нүүдэллэн очсон хасагууд өсч олширсоноор бэлчээр нутаг нь хүрэлцэхгүй байсан учраас тийнхүү Алтайг даван ирж суурьших болсон хэмээн бичсэн зүйл ч мөн ажиглагдана.

Түүхч Ц.Гантулга, Алтайн урианхайн талаар хийсэн судалгаандаа хасагууд тус оронд нүүдэллэн орж ирэх болсон асуудлыг хөндөхдөө: “Хасаг нар XVIII зуунаас ганц нэгэн өрхөөр Урианхайн нутгаар үзэгдэх болсон бөгөөд яваандаа XIX зуун хүрэхэд улам өргөжин хэсэг бүлгээрээ нүүдэллэн ирж, суурьших хандлагатай болов. Үүний улмаас Хасаг, Урианхай нарын хооронд газар нутгийн зөрчил маргаан олонтаа гарч байжээ”³ гэсэн байна.

¹ Камимүра, А. “Алтай урианхайн долоон хошууны газрын зургийн тухай”, эмх./ред. Чулуун, С, Равдан, Э, Монголын газрын зураг, газрын нэр судлал, улаанбаатар: МУИС пресс, УБ., 2015, X.112.

² Силам, Х. МАХН, Ардын төрөөс Казах, Урианхайн дунд хэрэгжүүлсэн хувьсгалт ардчилсан өөрчлөлт сэдэвт эрдмийн зэрэг горилсон бүтээл, Улаанбаатар, 1974, 18.

³ Гантулга, Ц. Алтайн урианхайчууд, Улаанбаатар: Урлах эрдэм, 2015, 132.



THE CULTURAL WAY

Харин уг явдлыг түүхч На.Сүхбаатар тэмдэглэхдээ, “1864 оны Орос-Хятадын гэрээгээр Хасагуудын нутаглаж байсан газар нутгийг зааглаж, нэг хэсэг нь Манж Чин улсад, нөгөө хэсэг нь Хаант Орос улсад хуваагдав. Удалгүй Манж Чин улсын харьяат Шинжааны хасагууд Алтайн урианхайн газар нутгийг түрээслэн суух болжээ”⁴ гэж хасагууд гурван улсын газар нутагт хуваагдан суух болсоныг илтгэжээ. Үнэхээр ч хасагууд ХХ зууны эхэн үе гэхэд Орос, Хятад, Монгол гэсэн гурван улсад харьяалагдан амьдрах болжээ. Өнөөдрийн Шинжаан-Уйгарын автономит муж гэж нэрлэгдэх БНХАУ-ын баруун хойт хязгаар нь гурван талаараа Төв Азийн сүрлэг уулсаар хүрээлэгдсэн Зүүнгарын болон Тамирын хоёр их хотгор сав газраас бүрдэх бөгөөд Зүүнгарын сав нь хойт талаараа Алтайн нуруугаар хиллэнэ. Эл нутаг нь эртнээс нааш түрэг, монгол, хамниган, хятад, төвд олон үндэстнүүдийн уулзвар хязгаар нутаг байсан хэдий ч Алтайн нурууг монголчууд эзэгнэн сууж байлаа.

Шинжаанаас Алтайг давж нүүн ирж, Ховдын хязгаарт шилжин суурьшсан хасагуудад бэлчээр нутаг амин чухал ач холбогдолтой байсныг тэмдэглээд хасагууд нь бэлчээр нутгаар үргэлж гачигдсаар ирсэн бөгөөд үүнийгээ шийдвэрлүүлэхийн тулд хасаг ноёдын төлөөлөгчид Ховдын манж амбанд хандсан боловч тус хэргийг шийдвэрлэж чадалгүй Манжийн хаанд мэдүүлжээ. Улмаар Ховдын амбан хээл хахууль авсны эцэст орон нутгийн казакуудад бэлчээр нутаг түрээсийн журмаар өгч, хатуу хяналт тавих болжээ.⁵ Тухайлбал, Цагаан гол орчмоор амьдарч байсан Алтайн урианхайчуудыг уугуул нутгаас нь нүүлгэж, тэдний нутгийг хасагуудад өгсөн явдлыг Алтайн урианхайчууд давж заалдан Ховдын амбанд очсон боловч тэднийг шийтгэн шоронд хийсэн явдал Манжийн хааны сонорт хүрч Ховдын амбан ажлаасаа халагдсан байна.⁶

Харин эл явдлын талаар судлаач Б.Монголхүү бичихдээ, “Казакууд анхлан Алтайн урианхайн баруун хошуудаар нутаглаж байгаад хүн ам өсөж өрх гэр нэмэгдэхийн хэрээр бэлчээр нутаг тэлэхээс аргагүй байсны улмаас Урианхайн долоон хошууны нутагт нүүж суух болжээ. Тэр үед урианхайчууд хүн амаар ч, мал сүргийн тоогоор ч тийм их нүсэр байгаагүй болохоор тэр болгон ашиглагдаггүй газруудад казак малчид нутаглахад дургүйцээгүй гэж хэлж болно”⁷ гэжээ. Энэхүү судлаач нь хасагуудыг Монголын газар нутаг луу нүүдэллэн ирэхэд хүргэсэн хоёр хүчин зүйлийг дээр дурджээ. Нэгд: Тэдний хүн

⁴Сүхбаатар,На. Баруун хязгаарын нийгэм-улс төрийн хөгжлийн тойм,Улаанбаатар:Монгол аригү график, 2000,24.

⁵ Силам,Х. МАХН, Ардын төрөөс Казах, Урианхайн дунд хэрэгжүүлсэн хувьсгалт ардчилсан өөрчлөлт сэдэвт эрдмийн зэрэг горилсон бүтээл,Улаанбаатар,1974,21-24.

⁶ Силам,Х. МАХН, Ардын төрөөс Казах, Урианхайн дунд хэрэгжүүлсэн хувьсгалт ардчилсан өөрчлөлт сэдэвт эрдмийн зэрэг горилсон бүтээл,Улаанбаатар,1974,25.

⁷ Монголхүү,Б. Цаст алтайн чуулган, Улаанбаатар:Ган принт,2009,Х.62.



THE CULTURAL WAY

ам, мал сүрэг нь олширсон, хоёрт: Алтайн урианхайд сул чөлөөтэй нутаг байсан гэж үзжээ.⁸ Миний бие эл дүгнэлтийг дэмжиж байна. Учир нь Манжийн болон Богд хааны төр урианхайчуудын сул чөлөөтэй газар нутгийг түрээслэн орлого олох явдал нь тус улсын сан хөмрөгт нэмэртэй зүйл байсан юм.

Ийнхүү Хасагууд Алтай даван нүүдэллэн ирсэн явдлыг Монгол Улсын Ардын эмч, Төрийн шагналт, Хөдөлмөрийн баатар Ж.Хайруллагийн өнөөдөр сонинд өгсөн ярилцлагад “аав Жалель нь Казанид төрж, Ленинградод сурч байхад нь түүнийг шашны зан үйл дэлгэрүүлэх, сүм хийд бариулахаар Хятадын казакууд руу томилолтоор явуулж, ...Шинжаанд байхдаа эхнэртэйгээ танилцаж, одоогийнх шиг хил хязгаарын зааггүй байсан учраас Ховд аймгийн Булган сумын Цагаан голд⁹ нүүн ирж суурьшсан”¹⁰ гэжээ.

Үүнээс гадна Алтайн урианхайн Зүүн гарыг захирах сул амбан Эрхшонуугийн Бадаргуулт төрийн 19 дүгээр оны 2-р сар гэсэн бичигт “Зарлигаар зарсан Ховдод сууж хэрэг шийтгэгч хэбэй амбас танаа өргөв, өргөн мэдүүлэхийн учир, мөнөөхөн ноднин жил манай гарын үхэр да Очиржавын жинсийг хасаг Шарбэйс тэргүүлэн 26 хүн дайчлан эвдсэн явдлыг удаа дараагаар уламжлан мэдүүлснийг данснаа тэмдэглэжүхүй. Эдүгээ тушаасныг дагаж урианхай, хасагийн амбан бид түшмэд бүгдээр цөм Шар нуур хэмээх газар цугларалдаж нарийвчлан байцааваас энэ хэргийн дотор худал үгүй чин үнэн, Шарбэйс би хариу урваж гомдож гаслах газар үгүй өөрөө мунхаг явдлаар үхэр дагийн биеийг занчсан нь лавтай үнэн, эдүгээ юу хэмээвч мөргөн сөгдөж дуртай дагамуй”¹¹ хэмээнээс харвал урианхай, хасаг ноёдын хооронд ямар нэгэн хэмжээгээр зөрчил байсныг илтгэж байна.

Алтайн урианхайчууд болон нүүдэллэн ирсэн хасагуудын харилцаа

Алтайн чанадаас нүүн ирсэн хасагуудад бэлчээр нутгаа түрээслэхдээ монголчууд түрээсийн төлбөрийг 100 бодоос 1 бод, 100 хониноос 1 хонь авч байжээ.¹²

⁸ Хасагууд Ховдын хязгаарт бөөнөөр ирж сууршсанаар одоогийн монголын казахуудын үндсэн гол цөм болжээ. улмаар 1940 оны 8 сард уих "казах, урианхай ард түмний эрэлт хүсэлтийн ёсоор" ховд аймгийг хувааж урианхай, тува, казах 7000 өрх, 32,000 хүн, 100,000 мал, 10 сумтай Баян-Өлгий аймгийг байгуулжээ.

⁹ Алтайн урианхайн гүн Төрбатын хошууны нутаг

¹⁰ Бат-Ундрах, О. “Хүний тэргүүнд хүрэх онцгой эрхтэй гэр бүл”, Өнөөдөр 133(5826), 2016/6/8

В хэсэг, 1.

¹¹ Баатархүү, Б. Золбаяр, Г. Мэндсайхан, Х. Алтайн туваачуудын цадиг оршвой. Улаанбаатар: Адмон принт, 2015, 13.

¹² Силам, Х. МАХН, Ардын төрөөс Казах, Урианхайн дунд хэрэгжүүлсэн хувьсгалт ардчилсан өөрчлөлт сэдэвт эрдмийн зэрэг горилсон бүтээл, Улаанбаатар, 23.



THE CULTURAL WAY

Урианхайчууд тийнхүү орлогын эх сурвалжтай болсон боловч нүүдлэн ирсэн хасагууд дэг журамгүй байдал үүсгэж байжээ. Энэ талаар Японы монголч эрдэмтэн Камимүра Акира: “Манай хошууг (Алтайн урианхайн Балдандоржийн гүний хошуу) танхай хасаг нар хулгаад булаах ба хохируулан зовоох зэргийн олон учрыг хэлж биднийг хамгаалан авахыг гуйн мэдүүлсэнд Торгуудын бэйс гүн, Хошоодын гүнгийн зэрэг хошуунаас зуу илүү тэмээг тэсгэн гаргаж тэрхүү гүн Балдандоржийн харьяат лам хар ардыг цөмийг шилжүүлэн нүүлгэж, Булган голд¹³ ирүүлж нутаглан суулгаж буй” гэсэн архивын эх сурвалжийг эш татан бичсэн байна.¹⁴ Үүнийг үзвээс Алтайн урианхайн гүн Балдандоржийн хошууныхан хасагуудын дээрэм тонуулд байнга өртөж байсны улмаас төрөлх нутгаа орхин Булган голд шилжин суурьшсан байна.

1911 онд Үндэсний эрх чөлөөний хувьсгалын үр дүнд Олноо өргөгдсөн Монгол Улс байгуулагдаж, улмаар 1912 онд Ховдын хязгаарыг манж-хятадуудаас чөлөөлж, олон хошууд Монгол улсад дагаар орох хөдөлгөөн өрнөсөн тэр үед хасагууд ч Монголын төрд сайн дураар дагаар орохоо илэрхийлсэн юм. Хасаг Сүкэрбай нарын хэсэг ардууд цутган орж ирснээр тэдэнд гүнгийн зэргэ шагнаж, өөр өөрийн дагалдсан хасагуудыг тэргүүлэн захируулж ...зохих нутагт найртайгаар нутаглуулан аж төрүүлэх зэрэг явдлыг Ховдын хэрэг шийтгэх сайдын газраас эрхлэн захирч явуулахаар тушаал гаргаж, Дотоод яамнаас бичиг явуулжээ”¹⁵. Баруун Монголыг чөлөөлөх тэмцэлд Хаант Орос Улс Монголд тусламж үзүүлсэн хэдүй ч эл үед Монголын Засгийн газрын оролцоогүйгээр Оросын консул Кузьминскийг Шар сүмд орогнон сууж Хятадын талыг төлөөлж байсан Палт вантай нэгэн гэрээ бичиг байгуулсан бөгөөд түүгээр Алтайн өмнөд хэсгийн газар нутгийг Хятадын мэдэлд шилжүүлэхээр болжээ.¹⁶ Эл үйлдэл нь Монголын оролцоогүйгээр хийгдсэн учир Монголын тал үүнийг хүлээн зөвшөөрөхгүй байсан нь хожмын хэрэг явдлын өрнөлтөөр батлагддаг билээ. Үүний талаар доор өгүүлэх болно.

Судлаач Х.Даражегийн бичсэнээр, казахууд нь Алтайгаас Ховдод авч ирсэн Жанкетей омгийн баатар А.Көбөш, Шеруши омгийн үхэрда А.Харахас, омгийн үхэр да Х.Тилеуди, С.Хожамжар мэтийн омгийн ахлагчид болон

¹³ 1860-аад оноос Жантекей, Шеруши, Харахас, Молхы, Ители, Шыбарайгыр Жадик овгийхон Алтай даван нүүдэллэн ирж, одоогийн Баян-Өлгий аймгийн Булган сумын нутаг буюу Алтайн урианхайн баруун гарын бэйс хошууны нутагт нутаглах болжээ.

¹⁴ Камимүра,А. “Алтай урианхайн долоон хошууны газрын зургийн тухай”, Эмх./ред. Чулуун,С. Равдан,Э. Монголын газрын зураг, газрын нэр судлал,Улаанбаатар:МУИС пресс,2015,109.

¹⁵ Магсаржав,Н. Монгол улсын шинэ түүх,Улаанбаатар:Адмон,2010,54-55.

¹⁶Урангуа,Ж. Монголын тусгаар тогтнолд Хаант Оросын үзүүлсэн хүчин зүйлс, Улаанбаатар:Соёмбо принтинг,2010,55.



THE CULTURAL WAY

Молхы омгоос гарсан соён гэгээрүүлэгч, зохиолч Ү.Ахыт нар болон Богд хаант монгол улсын үед Монголын харьяат болох тухай өргөдөл гаргаж, Богд эзэнтнээс тодорхой хэмжээний цол хэргэм хүртэж байжээ¹⁷.

Хасагуудын Монголд анхлан суурьших болсон явдлыг талаар түүхч Х.Мэндсайханы бичсэнээс үзвэл, 1912 онд хасаг овгууд Монголд дагаар орох хүсэлтээ илэрхийлж, 1917 онд Богд хааны зарлигаар тэднийг Монголд амьдрахыг зөвшөөрчээ. Түүнчлэн “Урианхайн ноён Бадрах¹⁸ газар нутгийн маргаан гаргаж амар заяа үзүүлэхгүй байна”¹⁹ хэмээн 1916 оны 12 дугаар сарын 6-ны өдөр хасагийн Жантекей овгийн тэргүүлэгчид Ховдын сайдаар уламжлуулан дээш мэдүүлсэн тухай эх баримтыг судлаач дурдсанг үндэслэвэл, нүүдлэн ирсэн хасагууд уугуул хүмүүсийг эх нутагтаа амар тайван оршин суухад нь хүртэл төвөг учруулж байжээ.

1915 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Дотоод яамнаас хасагийн довтолгоонд өртөж ядуурсан Алтайн цаадах Урианхай нарыг хил тогтоохын өмнө нүүлгэн ирүүлэхийг түр хүлээхийг мэдэгдэж илгээсэн бичигт, “Дөрвөдийн баруун аймгийн да, жанжин нараас өргөсөн бичигт өргөн мэдүүлж заан тушаахыг гуйх учир, эдүгээ манай аймгийн Урианхай засгуудаас удаа дараа мэдүүлсэн бичигт, бидний хошууд ойр жилээс харгис тэрслүү хасагт мал хогшлыг тамтлан хохируулснаар гачигдан ядуурах байдалд нэгмөсөн хүрэв”²⁰ хэмээснээс үзэхүл, тухайн үед хасагууд нилээд харгис ширүүн авирлаж байснаас гадна хэдийгээр Алтайн урианхайн долоон хошууд Монголд дагаар орсон хэдий ч тэдний төрөлх нутаг нь Алтайн наад, цаад биеэр байсан тул тэднийг Алтайг давуулан наад биеэр суулгах хүсэлт гаргаж байжээ.

Үндэсний төв архивын сан хөмрөгт хадгалагдаж буй Дотоод яамны 1918 оны 9 дүгээр сарын 22-ны албан бичигт: “Үгээгүй хоосон ардууд мөн албаныг залгамжлуулж амь зууж аргацаан явцгаасан бөгөөд одоо болвоос газар усны гаалийг өгөх байтугай язгуурын шагнагдсан шим өнгөтэй газар орноос зайлуулан хөөгдөхийн туйлд хүрч зун, намар, өвөл гурван цагийн бэлчээрийг хүчирхэг баян олон хасаг бэйс Сүхэрбай нарын харьяат ардууд зэргээр цутган орж өөр дураар булаан нутаглаж эрхэм чухал албанд нэгэн цэний төдий тус нөхвөр болгосон газаргүй дураар эзлэж өчүүхэн манай хоосон үгээгүй урианхайн ард нарыг харьяат нутаг газраас зайлуулан хөөхийн туйлд үнэхээр

¹⁷Дареже, Х. “Казахын үндэсний сэхээтэн үүсэж төлөвшсөн нь”, Ойрад судлал:Өнөө ба ирээдүй (Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүдийн эмхтгэл), Улаанбаатар:Соёмбо принтинг,2011,383.

¹⁸Алтайн урианхайн ёст гүн Очиржавын дүү Бадрах

¹⁹Мэндсайхан,Х. Монгол улс дахь гадаадын иргэдийн харьяаллын асуудал (1921-1940), Улаанбаатар: Соёмбо принтинг,2012,111.

²⁰Эмх./ред. Гэрэлбадрах,Ж. Монголчуудын нэгдсэн улс байгуулахын төлөөх тэмцэл, Улаанбаатар:Адмон 2015.



THE CULTURAL WAY

хүрэв”²¹ хэмээнээс үзвэл Монгол төрийн ивээлийг хүртэж тус оронд оршин суух эрх олж авсан хасагууд улам даварч бусдын эзэмшил нутгийг булаан суух явдал гарч байжээ.

Ардын засгийн алба татварын бодлого

Алтайд суурьшсан хасагууд нутгийн уугуул ард түмний нэгэн адил алба татвар төлж байв. Тэд урианхайчуудтай хамт нутаглан суух болсны хувьд аливаа албыг хамтран залгуулах болжээ. Үүний тухай нэгэн баримтыг 1924 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр Ховдын төлөөний жанжин сайдуудаас Алтай урианхайн суман өртөөний албыг харьяат Урианхай ба нутгийн Хасаг хошуудаас дагнан хаалгаваас зохих явдлыг харьяат газруудад тушаагаад мэдэгдэн ирсэн бичигт “...манай Урианхайн нутгийн дотор нутаглан бүхий ...хасгийн хошууд болвоос язгуураас манай Урианхайн газар оронд хамт нутаглан суусан учир өвс бэлчээрийн сүү гаалийг өгсөөр мөн ч аливаа өртөө сумны зэрэг олон зүйлийн албыг хувь данс нэгэн залгамжлан явсан удаа журам бүхий билээ. Одоо бидний хэдэн отог хасагуудыг харьяат газар нэвтрүүлэх өртөө сумны зэрэг албанд улаа хүнсний зэрэг хавсарга нийлүүлэн залгамжлуулж өчүүхэн дөрвөн хошуу хэмээх биднийг асран тэнхрүүлэх өршөөн үзүүлэхийг бүгдээр мөргөн гуйсугай”²² гэжээ.

Эл явдлын талаар өөр нэгэн баримтад 1924 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн Алтай урианхайн ёст гүн Бадрах нараас Монгол улс лугаа нийлж хүмүүжин явахыг хүссэн зэрэг учрыг гаргаж тогтоомуу хэмээн ирүүлсэн бичигт “...1912 онд манай гарыг ерөнхийлөн захирах тамганы газраас хүсэн батлах бичиг гаргаж өргөсөн тус гурван хошууг дагалдуулан авч шашин овгийг эрхлэн үндэс язгуураар нийлэн бүрэн бүтэн нэгэн гэр болохыг эрмэлзэж чин сүжгээр дагаар орж өршөөл соёлд нэгэн хамт багтан энх улиралд сүсэглэн алба залгамжилж суутал манай урианхайг Иргэн булаалдсаны харгайгаар манай суусан нутаг газар хятад ба хасаг этгээдэд зах хязгаар нийлэн холицолдсон бөгөөд тусгайлан хамгаалах цэрэг ангигүй тулд арга мохож Шинэ хязгаар мужийн даргын сүр хүчин доор дарлагдаж, хятад, хасагийн халдан хэлмэгдүүлэхээс эмээж хэдэн он удтал элдэвчлэн аргацааж нутаг үндсээ сахин ард олныг хамгаалж, цаг тухайг өнгөрүүлэн аж төрж, урьдын Чин улсын үед дагаар орсноос нааш уламжлан ирсэн удааг дагаж тус гурван хошууны түшмэл ард олны санаанд нийлүүлэн тус гарыг захирах тамгыг хамаарсан да лам Чүлтэмд захирагдан дагаж, сууснаас өөр улс төрөөс урван тэрсэлсэн зүйлгүй билээ”²³ хэмээн бичин мэдүүлж байснаас үзвэл Алтай хавийн урианхайчууд ч

²¹ МУУТА, А-3, Х-1, ХН-848, Нугал-23

²² МУУТА, Х-1, Д-1, ХН-328, Х.27-31

²³ МУУТА, Х-1, Д-1, ХН-328, Х.335-340



Чин улсын үеэс хятад болон хасаг нарын үргэлжилсэн түрэмгийлэл дор байсан нь илэрхий байна.

Баруун Монголынхан ба хасагууд

Алтайн хязгаарт хасгийн 12,000 өрх бүхий 13 отог, 600 өрх бүхий урианхайн 7 хошуу, 200 өрх бүхий торгууд, хошуудын гурван хошуу хамаарагдах болжээ.²⁴

Урианхай нар хасагуудын эзэгнэлийг номхон хүлцэнгүй хүлээн суусангүй, тус бүс нутгийнхан нүүдлэн ирэгчдэд хэрхэн хандаж байсан талаар баримт сөхвөөс, Дотоод хэргийг бүгд захиран шийтгэх яаманд өргөсөн бичигт, “...Манай хошууны танхай хасаг нар хулгайлан булаах ба хохируулан зовоох зэргийн олон учрыг хэлж биднийг хамгаалан авахыг гуйн мэдүүсэнд Торгуудын бэйс гүн, Хошоодын гүнгийн зэрэг хошуунаас зуу илүү тэмээг тэсгэн гаргаж тэрхүү гүн Балдандоржийн харьяат лам хар ардыг цөмийг шилжүүлэн нүүлгэж, Булган голд ирүүлж нутаглан суулгаж буй”²⁵ гэсэн баримт гэрчилж байна.

Хожим тэд 1924 оны Улсын анхдугаар их хурлын илтгэлд урианхайчууд өөрсдийн нутгаа олон тариалан, хадлан, ой мод, жимс, тэжээл, үст эвэрт ан гөрөөс зэрэг дэлхийн баялаг үлэмж газар гэж Алтайн цаадах нутгаа танилцуулж, одоо хятад, хасаг этгээд эзэрхэн ашиглаж бүхий учрыг илтгэж, тэрхүү шим өнтэй нутгийг дотоодод хамгаалан авч ядуу урианхайн хэдэн хошууны ардуудыг хүмүүжүүлэн нутаг үндсээр бүрэн бүтэн болгож тэнхрүүлэхийг үнэхээр эрмэлзэн хүсмой²⁶ гэж илтгэжээ. Байгалийн баялаг ихтэй Алтайн хязгаарыг их гүрнүүдийн геополитикийн бодлогын үүднээс 1913 онд тийнхүү хоёр хувааж хоёр орны мэдэлд оруулсан явдалд нутгийн ард түмэн төдийлөн тааламжтай бус хандаж байсныг илтгэнэ.

²⁴ [Олноо өргөгдсөн Монгол Улсын](#) үед урианхайн 7 хошуу байснаас 4 нь буюу ёст гүн, дархан гүн, саруул гүн, дархан гүний хошуу нь алтайн урианхайнх, бусад 3 хошуу буюу эетэй гүнгийн хошуу, зүгэлт гүн, зоригт гүнгийн хошуу нь тува хошуу байв.

²⁵ Камимүра,А. “Алтай урианхайн долоон хошууны газрын зургийн тухай”, Эмх./ред. Чулуун,С. Равдан,Э. Монголын газрын зураг, газрын нэр судлал,Улаанбатаар:МУИСПресс,2015,109.

²⁶ Мөн тэнд



ДҮГНЭЛТ

Эцэст нь хэлэхэд, Алтайн хязгаар дахь хоёр улсын хил тодорхой бус байсан бөгөөд 1910 он буюу XX зууны эхэн гэхэд Алтайн урианхайн газар нутаг тэдний өөрсдөө зурдаг зураг шиг өргөн уудам биш харин ч казакуудад шахагдсан бага хэмжээгээр үлдсэн нутаг болсон ажээ. Үүнээс гадна Намын Төв хороонд 1927 оны 5-р сарын 30-ны өдөр ирүүлсэн Алтайн урианхайн байдлыг илтгэсэн нууц илтгэлд тэмдэглэхдээ, “...Урьд урианхай нар цөм цагийг нэгэн удаа дагаж монголд захирагдах нэрээр явж эцсийг үзье хэмээн явсан байгаа хэмээлтэй. Ойрноос бид монголд бүрнээ орохоос өөргүй хэмээвч орсон биднийг авч захирахаа мэдэх харин Хятадын хязгаарт гарсныг нааш авахгүй юм хэмээн санагддаг боловуу хэмээн таамагламой” хэмээснээс харвал Монголд байсан Алтайн урианхайчууд алба татвар төлж байхад, Алтайн чанадад байсан Алтайн урианхайчууд Дундад иргэн улсад ямар нэгэн алба татвар төлөхгүй амар жимэр байсан нь харагдаж байна.²⁷

Чингийн үеэс Алтайн урианхайчуудын нутагт хасагууд нүүдэллэн ирж суурьшиж газар нутгийн түрээс төлөх болсон бөгөөд 1926 он хүртэл энэхүү газрын түрээс хэвээр үргэлжилж байв. Ийнхүү Алтайн урианхайчуудын нутагт хасагууд газар нутгийн түрээс төлөх болсон нь тэдний дунд газар нутгийн маргааныг эхлүүлжээ. Мөн хасасгуудын зүгээс урианхай нарыг шахан хавчих явдал үзэгдэх болжээ.

Дурдан буй хоёр этгээдийн газар нутгийн маргаан нь нэг талаас үнэхээр тэдний хооронд үүссэн бэлчээр нутагтай холбоотой боловч нөгөө талаас Алтайн урианхайчууд Монголд дагаар орон ирж улмаар алба татвар төлөх нь бэрхшээлтэй байсан учраас хасагуудын дээрэм тонуулд өртсөн хэмээн “шалтаг” болгон хуучин захиргаан дахь нутагтаа буюу Дундад иргэн улсын бүрэлдэхүүнд орсон Алтайн хязгаар орчмын газар нутагтаа амьдрахыг илүүд үзэх болсныг түүхэн баримтууд харуулж байна.

²⁷ МУУТА, Улс төрийн намын баримтын төв. Х-4, Д-2, ХН-375. Х.28-31.



THE CULTURAL WAY

ABSTRACT

Since 18th century, Tsarist Russia began to establish wide range of towns and villages in the territory Middle Asia by conquering it violently. Furthermore, the Middle Asian nomadic tribes, including Cossacks had been invaded by Tsarist Russia and kept into submission of it. Some parts of Cossacks who opposed the violence, escaped away from their homeland and migrated to the western remote area of Chin dynasty, which was located in neighborhood in 1767, century called Xinjiang. The migrants of Cossacks mostly reside in the territory 3 aimags, including Altai, Tarvagatai, and Eal which neighbor with Mongolia.

НОМ ЗҮЙ

Нэг. Архивын эх сурвалж

1. МУҮТА, А-3, Х-1, ХН-848
2. МУҮТА, Х-1, Д-1, ХН-328

Хоёр. Судалгааны зохиол

1. Камимүра,А. “Алтай урианхайн долоон хошууны газрын зургийн тухай”, эмх./ред. Чулуун,С, Равдан.Э, Монголын газрын зураг, газрын нэр судлал,улаанбатаар:МУИС пресс, УБ., 2015
2. Силам,Х. МАХН,Ардын төрөөс Казах, Урианхайн дунд хэрэгжүүлсэн хувьсгалт ардчилсан өөрчлөлт сэдэвт эрдмийн зэрэг горилсон бүтээл,Улаанбаатар,1974
3. Сүхбаатар,На. Баруун хязгаарын нийгэм-улс төрийн хөгжлийн тойм,Улаанбаатар:Монгол аригү график,2000
4. Магсаржав,Н. Монгол улсын шинэ түүх,Улаанбаатар:Адмон,2010
5. Урангуа,Ж. Монголын тусгаар тогтнолд Хаант Оросын үзүүлсэн хүчин зүйлс, Улаанбаатар:Соёмбо принтинг,2010
6. Гантулга,Ц. Алтайн урианхайчууд,Улаанбаатар:Урлах эрдэм,2015
7. Дареже, Х. “Казахын үндэсний сэхээтэн үүсэж төлөвшсөн нь”, Ойрад судлал:Өнөө ба ирээдүй (Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүдийн эмхтгэл),Улаанбаатар:Соёмбо принтинг,2011
8. Мэндсайхан,Х. Монгол улс дахь гадаадын иргэдийн харьяаллын асуудал (1921-1940), Улаанбаатар: Соёмбо принтинг,2012,111.
9. Эмх./ред. Гэрэлбадрах,Ж. Монголчуудын нэгдсэн улс байгуулахын төлөөх тэмцэл, Улаанбаатар:Адмон 2015.

**ЧИН УЛСЫН ДУНД ҮЕИЙН ХӨВӨӨТ ШАРЫН СҮРЭГ БА ЦАХАР ХӨВӨӨТ
ШАР ХОШУУНЫ НУТГИЙН ХИЛИЙН ШИНЖЛЭЛ**

Ань Нин*

ХУРААНГУЙ

Чин гүрний үед Цахарын найман хошууны хөвөөт шар хошуу болон Дотоод явдлын яамны харьяа хөвөөт шар хошуу нь зах хязгаарын хувьд нийлсэн байдалтай бөгөөд хоёулаа өнөөдөр Хэбэй мужийн Жанжякоу-ийн Башан дүүрэгт байрлаж байв. Сурвалжид тус хоёр газрын найман хэсгийг танилцуулсан ч Чин гүрний сүүл үеийн нөхөн сэргээлт, газар тариалан, бэлчээрийн байдлаас үүдэн тодорхой байр суурьтай зарим хэсэг устаж үгүй болж, газар нутгийн нэр өөрчлөгдөн хил хязгаар нь тодорхойгүй болсон байна. Сүргийн газруудын харьяалалыг удаан хугацаанд тодруулж чадсангүй өий хүрлээ. Энэ талаар өмнө нь тодорхой судалгаа хийсэн ч түүнд зөрчилтэй, алдаатай зүйл байсаар байна. Түүхэн сурвалжид дүн шинжилгээ хийх, археологийн судалгааны үр дүнг ашиглах, хээрийн судалгааны мэдээлэлд үндэслэн Чин улсын дунд үеийн Цахар хөвөөт шар хошуу, Хөвөөт шар хошуу гэх хоёр сүргийн хилийн заагийг нарийн судалж, дахин хянахыг хичээлээ.

Түлхүүр үг: *Цахар хөвөөт шар хошуу, хөвөөт шар хошууны сүрэг, хошууны хил*

Өгүүллийн бүтэц:

- *Хураангуй*
- *Цахарын хөвөөт шар хошуу ба Хөвөөт шарын сүргийн газар*
- *Хөвөөт шарын сүргийн газар ба найман хошуу*
- *Цахар хөвөөт шарын найман хошуу*
- *Дүгнэлт*

清中期镶黄旗牧厂与察哈尔镶黄旗旗界考

安 宁

摘 要:清代，隶属于察哈尔八旗的镶黄旗和隶属于内务府的镶黄旗牧厂地域相连，且均位于今河北省张家口坝上地区。史料中虽对两地的八至有所介绍，但由于清末放垦，农进牧退，导致有些确定方位的鄂博消失、地名改变，以致长期以来旗群的边界无法厘清。就这一问题，前人虽有所研究，但矛盾、错误之处仍旧很多。本文在史料分析的基础上注重考古成果的运用和田野调查数据的采纳，初步考证出清中期察哈尔镶黄旗和镶黄旗牧厂的边界，并绘制成图。

关键词: 察哈尔镶黄旗；镶黄旗牧厂；旗界

* Хаалган хот дахь Удирдлагын сургуулийн багш, ӨМИС-ийн докторант



后金天聪八年（1634年）察哈尔林丹汗遗部最终归降后金。布尔尼叛乱后的康熙十四年（1675年）察哈尔作为游牧八旗最终被固定在宣化、大同边外直至清末。游牧察哈尔八旗中，正黄与镶黄两旗居于中央位置，而镶黄旗离北京位置最近，重要程度无需多言。同时，隶属于内务府庆丰司的镶黄旗牧厂与察哈尔镶黄旗位置相邻，而且一些地方呈犬牙交错之势。他们的牧地涵盖了今河北省张家口市的康保县、张北县的大部，以及崇礼区、尚义县与沽源县的一小部分，还有今内蒙古的镶黄旗、化德县、商都县、太仆寺旗的部分地区。

一、察哈尔镶黄旗与镶黄旗牧厂

《口北三厅志》是研究察哈尔镶黄旗与镶黄旗牧厂的重要史料，但相关记载有语焉不详之处。因此，镶黄旗牧厂容易被忽视或与察哈尔镶黄旗混同。鉴于此，文章首先对察哈尔镶黄旗与镶黄旗牧厂的关系进行梳理。

1、隶属与职能上的差异

镶黄旗牧厂在顺治十一年（1654年）隶属于三旗（正黄、镶黄、正白）牛羊群牧处，后又隶属于内务府掌仪司，康熙二十三年（1684年）分掌仪司，设庆丰司¹，之后镶黄旗牧厂便隶属于内务府庆丰司，直至清末。

为便于管理三旗牧群，乾隆朝时设张家口外牛羊牧群总管一人，副总管二人，效力笔帖式二人，牛羊群还各设协领、委属协领、笔笔帖式共十二人、牧长以及牧副四百余人，同时还有牧丁一千二百余人²。不论是大小官员，牧丁的薪俸，还是相应用度，均从庆丰司领取³。反观察哈尔镶黄旗，则直接隶属于察哈尔都统。

镶黄旗牧厂的职能是围绕皇室用度展开的，概括起来有如下几个方面，即：为祭祀提供所需牛羊、皇帝亲耕时所用耕牛、提供御膳及各种宴会食物所需用的牛羊、皇帝在巡幸途中所用的牛羊、皇子与公主在婚嫁时所需用的牛羊、为喇嘛诵经提供牛羊等⁴。除直接供应肉制品外，宫中需用的“马牛驼皮由牧群随时交纳”⁵。反观察哈尔

¹ 参见赵尔巽著：《清史稿》志 93 职官五（内务府），北京：中华书局，1976年，第3424—3426页。

² 《钦定大清会典》（乾隆）卷 91，庆丰司。

³ 《为领取嘉庆元年份察哈尔镶黄、正黄二旗牛羊群官兵兵丁等俸银两事》：嘉庆元年3月20日，05-08-007-000002-0026，中国第一历史档案馆藏；

《为领取察哈尔三旗牛羊群、达理岗崖羊群一年所需纸张事》：嘉庆元年3月20日，05-08-007-000002-0028 中国第一历史档案馆藏。

⁴ 参见徐莉著：《专为皇帝饲养牛羊的机构——清朝内务府庆丰司》，《中国档案》（北京），2014年第11期。

⁵ 允陶：《钦定大清会典》卷 92，武备院。



镶黄旗，作为察哈尔八旗的一部分，它更多承担的是驻守军台，随军出征⁶这些任务。

2、人员上的紧密联系

尽管镶黄旗牧厂与察哈尔镶黄旗分属不同系统，但两地毕竟地域相连，所以联系密切，尤其表现在人员方面。据光绪朝《钦定大清会典》所载，三旗牧厂共有牛 1.2 万余头，羊 15.4 万余只，300 头牛为一群，羊则以 1100 只为一群。具体到镶黄旗牧厂，共养牛 14 群，计 4200 余头，羊 40 群，计 44000 余只⁷。通过比对发现，镶黄旗牧厂牛羊的数量分别占总数的 35 和 29 个百分点，几乎是三分之一。

据史料记载，张家口外牛羊牧群共有牧长、牧副及牧丁 1600 余人，参照牛羊数量比例分配，镶黄一旗应有 500 余牧丁。如此数量，从外调派显然不如就地选用。现实中，相关人员就是选自察哈尔部，且已脱离了原来所在旗的比丁序列⁸。这一结论也可在相关文献中得到印证，如波滋德捏耶夫在《蒙古及蒙古人》中写到“皇家牧厂的土地从察哈尔牧地的北部边界开始，向东南一直延伸到博格多音郭勒（今镶黄旗宝格达音郭勒——引者）……皇家牧厂所有的牧人（蒙语称为“霍尼齐”）分为镶黄旗和正黄旗……向我谈以上情况的察哈尔人到“霍尼齐”旗来还不到两年”。⁹

总之，察哈尔镶黄旗与镶黄旗牧厂虽隶属关系与职能不同，但人员相通，地域相连。这是清政府有意而为的结果，目的是既能削弱察哈尔部的整体势力，又可以发挥其在畜牧生产上的先进经验，最终更好地为清政府服务。¹⁰

二、镶黄旗牧厂的八至

在《口北三厅志》（以下简称三厅志）和《嘉庆重修一统志》（以下简称一统志）中，就镶黄旗牧厂的八至，记载都十分明确。两种资料各有优劣，细节之处各有详略，但总体差别不大。

1、牧厂总管驻地

⁶ 参见金海、齐木德道尔吉等编著：《清代蒙古志》，呼和浩特：内蒙古人民出版社，2009年，第174-175页。

⁷ 参见徐莉著：《专为皇帝饲养牛羊的机构——清朝内务府庆丰司》，《中国档案》（北京），2014年第11期。

⁸ 内务府折。内务府奏案：05-0255-025。转引自陈肖寒：《清代直隶口外地区内务府牧厂的管理》，《武汉大学学报》（武汉），2017年第6期。

⁹ 阿·马·波滋德捏耶夫：《蒙古及蒙古人》，刘汉明、张梦玲、卢龙译，呼和浩特，内蒙古人民出版社，1989年，第683页。

¹⁰ 参见陈肖寒著：《清代直隶口外地区内务府牧厂的管理》，《武汉大学学报》（武汉），2017年第6期。



按照上述文献的记载，牧厂在“张家口北一百里控果罗鄂博冈”¹¹。这说明，明确“控果罗鄂博冈”的位置是考证镶黄旗牧厂地望的关键。“控果罗”应为蒙古语的 *xong γ or*¹²，意为可爱的，令人喜爱的。鄂博即旧时草原上辨别方位以及举行祭祀活动的由石块堆砌而成的敖包。

对“控果罗鄂博冈”这几个字进行深入分析便会发现：第一，*xong γ or* 一词作为地名，在蒙古地区出现频率极高，而且就字意来说不具备指向功能。其次，由于鄂博的构造简单，所以极易被破坏，加之清末新政之后，大量汉族移民涌入这一地区，牧地变为农田，昔日的鄂博大多已踪迹全无。因此，仅从上述几个字无法判断具体位置。

然而，在《大清一统志》关于古迹部分的两条记载中，却为“控果罗鄂博冈”的定位提供了重要线索，因为遗迹、遗址的保存程度要远好于敖包。其一：“兴和旧城，在牧厂西南二十里”，兴和旧城，即今天的河北省张北县县城¹³，地理坐标为（东经 114.72 度，北纬 41.15 度）。其二：“沙城，在牧厂西北二十里……元时所建，杨荣北征录，沙城即元中都……此城土人名插汉巴尔哈孙城。”可见，确定沙城，即元中都的位置十分关键。“元中都遗址位于河北省张家口市张北县县城西北十五公里，在积善、魏家房（二村合称白城子村）和淖沿子三村之间。”¹⁴遗址的中心点坐标为（东经 114.37 度，北纬 41.17 度）。此外，一统志中的蒙古语“插汉巴尔哈孙”即 *ča γ an* 和 *bal γ asu* 两个单词，合起来是白色城池之意，这与考古报告中的“白城子”可以完全对应。因此，今天的中都遗址就是史料中的沙城无疑。

在确定了兴和城与沙城的位置之后，我们便可以大体划定“控果罗鄂博冈”的位置就是今天的张北县小柳沟村一带，坐标为（东经 114.73 度，北纬 41.20 度），距张家口 49.1 公里。

2、牧厂的南界与东南界

按照一统志记载，镶黄旗牧厂“南至宣化府边界四十里……东南至镶蓝旗牧厂界

¹¹ 《嘉庆重修一统志》卷 548《牧厂》，上海：上海书店出版社，1984 年影印版。金志章、黄可润：《口北三厅志》卷六，考牧。

¹² 本文中涉及到的蒙古语转写、词义均以内蒙古大学蒙古学研究院、蒙古语文研究所编写，内蒙古大学出版社于 1999 年 6 月出版的《蒙汉词典（修订本）》为依据，之后不再单独注释。

¹³ 河北省张北县地名办公室：《张北县地名资料汇编》，1984 年，第六页。

¹⁴ 河北省文物研究所：《元中都——1998—2003 年发掘报告》（上），文物出版社，北京，2012 年，第 25 页。



九十五里”¹⁵。据此，从牧厂驻控果罗鄂博冈一直到宣化府北境之间的土地均是该牧厂的游牧地。作为华北平原与蒙古高原的交界地带，宣化府与牧厂的交界十分容易确定，就是张家口北部长城一线¹⁶，大体就是今天张家口市张北县和万全区的交界处，与小柳沟的距离在 20 公里左右，从距离上判断也与史料记载基本一致。

牧厂的东南与镶蓝旗牧厂相交。镶蓝旗牧厂驻登奴素泰，位置大体在今张北县大囿囿镇大台附近¹⁷（东经 115.32 度，北纬 41.34 度）但四至不详¹⁸。如按距离推断，95 里早已深入今张家口市崇礼区或桥西区境内，然而乾隆初年，上述地区从事农耕的汉地移民已占绝大多数。因此，实际界限不应超过今天张北与崇礼和桥西的交界一带，进而推断牧厂东南界应在张北县与张家口市桥西区以及崇礼区的交界的旱淖坝（北纬 41 度，东经 114.78 度）一带。

3、牧厂的西界与西南界

据一统志记载，镶黄旗牧厂西至正黄旗牧厂界五十里，正黄旗牧厂东至镶黄旗牧厂界六十里¹⁹。在这里，只有距离的描述，并无其他可参照物的记录。因此，确定正黄旗牧厂的驻地成为解决问题的关键。

根据记载，正黄旗牧厂的驻地在位于张家口西北的诺莫浑博罗山，诺莫浑即蒙古语的 nomoxan，意思是老实的，温顺的。关于这一名称，一统志与三厅志无异，但在与张家口的距离上却相去甚远。前者记录的距离为二百里，后者确是一百里²⁰。两相比较，一统志的记载较为准确。因为前文所述的镶黄旗牧厂驻地控果罗鄂博冈距张家口一百里，而正黄旗牧厂还在镶黄旗牧厂西侧，绝不可能距张家口的位置也是一百里。

在宋哲元版的《察哈尔通志》中，关于尚义设置局有这样的叙述：“境内山岭甚少，丘陵岗峦，则所在多有，其最著者，曰老虎山。在城南十里……山巅有鄂博一，为蒙人所筑，每年夏历六月间，蒙人结夥来此，杀羊致祭，名曰祭鄂博，并有喇嘛奉经。²¹”同时，该书在关于商都县的记载中又说道“老虎山，在前县属第二区，即大青沟，六合堂及二成公乡内，距县城东南一百二十里，高约三十丈，漫衍平坦，蒙名

¹⁵ 《嘉庆重修一统志》卷 548《牧厂》，上海：上海书店出版社，1984 年影印版。

¹⁶ 《嘉庆重修一统志》卷 38《宣化府图》，上海：上海书店出版社，1984 年影印版。

¹⁷ 朱诗婷：《清代察哈尔游牧八旗政区边界研究》，硕士学位论文，中国人民大学，2015 年，第 40 页。

¹⁸ 金志章、黄可润：《口北三厅志》卷六，考牧。

¹⁹ 《嘉庆重修一统志》卷 548《牧厂》，上海：上海书店出版社，1984 年影印版。

²⁰ 《嘉庆重修一统志》卷 548《牧厂》，上海：上海书店出版社，1984 年影印版。金志章、黄可润：《口北三厅志》卷六，考牧，张家口市图书馆影印，2016 年 9 月。

²¹ 民国《察哈尔省通志》，卷 4，《疆域篇之四》，郑州：中州古籍出版社，2016 年影印本。



脑木衡脑包，系老实之意，后转音为老虎山，现属尚义辖境。”²²

显然，一统志中的诺莫浑博罗就是通志中的脑木衡脑包。而大青沟就是今天张家口尚义县的大青沟镇，该镇位于张家口的西北部。在大青沟镇西南 15 公里左右的黑圪塔山村，现尚存敖包的遗迹，当地人称之为小脑包。因此，综合史料、方位以及遗迹推断，诺莫浑博罗山应该就位于今张家口尚义县大清沟镇南部的黑圪塔山村（北纬 41.29 度，东经 114.02 度）。此地距张家口的距离大约为 100 公里，这也与一统志的记载较为吻合。根据双方驻地距离推断，镶黄旗牧厂西界应位于今张北县海流图乡义兴店村附近（北纬 41.25 度，东经 114.41 度）

镶黄旗牧厂西南至边界五十里，正黄旗牧厂东南至镶黄旗牧厂界八十里²³。镶黄旗牧厂西南五十里与正黄旗牧厂东南八十里大体在位于今张北县大河镇北部相交（北纬 41.09 度，东经 114.43 度）这里应为镶黄旗牧厂的西南边界。

4、牧厂的东界与东北界

位于镶黄旗牧厂东侧的是镶蓝旗牧厂，距离为九十里。镶蓝旗牧厂的驻地在今河北省张北县大囿囿镇大台附近的登奴素泰（东经 115.32 度，北纬 41.34 度），由于四至不详，只能按照距离推断，牧厂的东界在今张北县大囿囿镇万宝庄附近（北纬 41.25 度，东经 115.24 度）。

在东北部与镶黄旗牧厂交界的是太仆寺左翼牧厂，距离六十里²⁴。据一统志所载，太仆寺左翼牧厂在张家口东北的的喀喇尼敦井（今太仆寺旗的五旗敖包，北纬 41.64 度，东经 115.13 度），距离是一百四十里，西南到镶黄旗牧厂界六十里²⁵。按照上述数据，镶黄旗牧厂的东北界大体在今张家口市察北管理区沙沟村（北纬 41.43 度，东经 114.96 度）一带。

5、牧厂的北界与西北界

其北界一百一十里与镶黄旗察哈尔交界²⁶，大体位置是张家口市康保县郝车信村附近（北纬 41.71 度，东经 114.73 度）。因太仆寺旗牧厂西距镶黄旗牧厂 6 里²⁷，由此可以判定镶黄旗牧厂从北部向东南延伸的过程穿过了今天锡林郭勒盟太仆寺旗境内。

因镶黄旗牧厂“西北至察哈尔界一百九十里”，而这一记录可能存在误差，因为

²² 同上

²³ 《嘉庆重修一统志》卷 548《牧厂》，上海：上海书店出版社，1984 年影印版。

²⁴ 《嘉庆重修一统志》卷 548《牧厂》，上海：上海书店出版社，1984 年影印版。

²⁵ 《嘉庆重修一统志》卷 548《牧厂》上海：上海书店出版社，1984 年影印版。

²⁶ 《嘉庆重修一统志》卷 548《牧厂》上海：上海书店出版社，1984 年影印版。

²⁷ 《嘉庆重修一统志》卷 548《牧厂》上海：上海书店出版社，1984 年影印版。



同时一统志中还记载到“南北距一百五十里”²⁸两条史料明显存在矛盾，因牧厂西北界与察哈尔镶黄旗接壤，所以相关内容将在下一节阐述。

三、察哈尔镶黄旗的八至

和镶黄旗牧厂相比，察哈尔镶黄旗的地域涉及到今天的旗县较多，距离跨度很大，一些地方具体位置至今存在不少争议，因此情况相对复杂。

1、察哈尔镶黄旗总管府驻地

一统志中记载的察哈尔镶黄旗总管府为苏门峰，《口北三厅志》中的记载是苏门哈达，“哈达”即蒙古语 xada，意为岩石、山岩，由此可见两种文献的记载是一致的，都为苏门哈达。但关于苏门哈达的具体位置，在学术界存在着不同的观点，较有代表性的是以下两种：第一种是张家口市康保县的镶黄旗山²⁹（北纬 42.09，东经 114.79 度）说；第二种是锡林郭勒盟镶黄旗的巴彦塔拉镇莫日格其嘎查（北纬 42.13 度，东经 114.45 度）³⁰说。

经过考证不难发现，第一种说法更加符合实际。首先，一统志中关于察哈尔镶黄旗境内的山中有这样的描述“骆驼山，在旗东南九十里，蒙古名黑伯忒（应为“伯忒黑”，原文如此）特门，明李文忠败元兵于骆驼山，即此”³¹。而在镶黄旗山和莫日格其嘎查附近，以骆驼山为名的山峰非常多，以此定位非常困难。而文献中的“黑伯忒特门”是蒙古语的 botoγo，意为羔驼，和 temege，意为骆驼，两词，合起来可以翻译为小骆驼。在锡林郭勒盟太仆寺旗境内有两座名为小骆驼的山，一座靠近太仆寺旗和正蓝旗的交界处，位置是（北纬 42.01 度，东经 115.76 度），该山距离莫日格其嘎查将近 500 里，距离镶黄旗山也将近 300 里，而且从纬度上看，三地几乎一致，因此可以将此山排除。另一座小骆驼山位于太仆寺旗与康保县的交界处，位置是（北纬 41.96 度，东经 114.94 度）该山虽位于莫日格其嘎查东南，但距离 200 余里，与文献记载出入较大。该山距离镶黄旗山的直线距离是 40 余里，且同样在镶黄旗山的东南，与文献记载较为相近；其次，按照《张北县志》的记载，察哈尔镶黄旗驻地经过一次迁移之后，便来到了今康保县北部，地点正在今镶黄旗山附近³²。综合以上分析，本文认为苏门哈达的位置就是今天康保县的镶黄旗山。

²⁸ 《嘉庆重修一统志》卷 548《牧厂》上海：上海书店出版社，1984 年影印版。

²⁹ 朱诗婷：《清代察哈尔游牧八旗政区边界研究》，第 39 页。

³⁰ 马宝军：《镶黄旗志》，呼和浩特：内蒙古人民出版社，1999 年，第 67 页。

³¹ 《嘉庆重修一统志》卷 548《牧厂》上海：上海书店出版社，1984 年影印版。

³² 民国《张北县志》，《察哈尔清代蒙旗沿革图》。



THE CULTURAL WAY

还需要说明的是，有学者认为，镶黄旗总管府开始并不驻苏门哈达，是从位于今张家口市崇礼区响南营村（北纬 40.93 度，东经 114.94 度）的陶赖庙迁移而来³³，原因是由于大量移民的涌入。遗憾的是，上述文章并未进行深入考证。本文赞同这一观点，并进行了初步论证。

三厅志中写道察哈尔镶黄旗“南至吗呢图达坝镶黄旗牧厂界七十里³⁴”，这个表述与一统志相同。前文已经阐明，镶黄旗牧厂几乎在今张北县境内。因此，察哈尔镶黄旗南界不应超过张北县。但又说到“本旗坝内地方，距张家口外十五里……南至边墙，北至达坝……南界起自张家口外乌拉哈达”³⁵而这段描述在一统志中是没有的。这一片区域位于今天张家口市的崇礼区高家营镇附近，乌拉哈达就是今天张家口市崇礼区的乌兰哈达村（北纬 40.88 度，东经 114.94 度）这一片区域的位置还在张北县的东南方。由于一统志成书晚于三厅志，这就说明，到一统志成书时，察哈尔镶黄旗已从坝内地方迁移而出，否则关于东南界的描述应为“张家口外乌拉哈达”。

另据三厅志记载，乾隆初年，今张家口崇礼这一地区共有户口 3436，其中旗户仅 507，而民户则达到了 2824³⁶，从户口对比上可以看出，察哈尔镶黄旗的迁移已是势在必行。

接下来再将目光移向陶赖庙，在三厅志和一统志中均没有陶赖庙曾作为驻地的表述，三厅志中仅记载了陶赖庙的修建年代为顺治年间³⁷。另据《张北县志》所载，该庙为喇嘛庙³⁸。虽然该庙已荡然无存，但有一古树尚在，树龄为 800 年左右。据当地人称，该树附近曾有过庙宇。在清代的蒙古社会，喇嘛庙发挥着重要作用，是一个部落经济、文化的中心，不论是扎萨克旗的王爷还是内属旗的总管，其驻地大多位于喇嘛庙附近。因此，陶赖庙曾作为察哈尔镶黄旗的总管府驻地是有着极大可能的。

综上，不难得出这样的结论：察哈尔镶黄旗的总管府最初在陶赖庙，后因移民的涌入，察哈尔镶黄旗对这一地区几乎失去控制能力，故将旗驻地迁移到了苏门哈达。同时，旗界也有所改变，迁移的具体时间应不晚于乾隆晚期。

³³ 金海、齐木德道尔吉：《清代蒙古志》，呼和浩特，内蒙古人民出版社，2009 年，第 175 页；

潘小平、武殿森：《察哈尔史》，呼和浩特，内蒙古人民出版社，2012 年，第 205 页。

³⁴ 金志章、黄可润：《口北三厅志》卷七，藩卫志。

³⁵ 金志章、黄可润：《口北三厅志》卷七，藩卫志。

³⁶ 金志章、黄可润：《口北三厅志》卷 5，村窑户口。

³⁷ 金志章、黄可润：《口北三厅志》卷 4《坛庙》。

³⁸ 民国《张北县志》卷 3《建筑志·祠庙》。



2、镶黄旗的南界与东南界

三厅志中写道：察哈尔镶黄旗“南至吗呢图达坝镶黄旗牧厂界七十里，东南至阿尔撒兰达坝。阿尔撒兰，犹华言狮；达坝，犹华言岭。察哈尔正白旗界一百六十里。³⁹”此表述与一统志一致，但后者并未标出具体地名。

要定位该旗的南界，首先需明确“吗呢图达坝”的具体方位。“达坝”是蒙古语“daba γ-a”，意为山岭。因此，达坝或坝出现在汉语地名中大多和山有关。在现行地名中，位于崇礼区与张北县交界处的桦皮岭（古称兴安岭）有一村庄，名称是麻泥坝（北纬 41.25 度，东经 115.12 度）。而且该山岭还是蒙古高原同华北平原的分界线，坝内地方正是驻地迁移到苏门哈达之前的察哈尔镶黄旗牧地。同时，在三厅志中标有一地名为吗呢兔，位置也与此村相似。⁴⁰因此，有些学者便将此地认定为吗呢图达坝的位置⁴¹。

但这一观点经不起推敲。首先，根据三厅志的记载，察哈尔镶黄旗以南应为镶黄旗牧厂游牧地。事实上，该书成书时麻泥坝以南已大量垦种。当然，即便没有农耕化也应该是察哈尔镶黄旗自己的牧地而非镶黄旗牧厂所有。

在今康保县中南部的忠义乡有一村名为小麻尼（北纬 41.67 度，东经 114.49 度），其距小柳沟 140 里左右，距镶黄旗山 90 余里，这与史料相对接近，而且该地在位于前文推断的镶黄旗牧厂的北界郝车信村的西部偏南位置。据此判断，察哈尔镶黄旗的南界，同时也是镶黄旗牧厂的西北界，就在小麻尼村附近。

文献中的阿尔撒兰达坝位于张家口崇礼区的狮子沟乡（北纬 41.10，东经 115.38），但崇礼全区的地形属于典型的山地地貌，不宜游牧，而且当时这一区域从人口结构上也以汉地移民为主，不过仍有三佐的一半和科尔沁十八佐留在了该地⁴²，而且已不再进行游牧。因此，该地只能属于镶黄旗的一块飞地，不能作为察哈尔镶黄旗的东南界，其东南界应和镶黄旗牧厂的北界接壤，为康保县郝车信村附近。

3、镶黄旗的西界与西南界

察哈尔镶黄旗“西至喀喇鄂博图察哈尔正黄旗界七十里……西南至赤老图达坝镶黄旗牧厂界五十五里”⁴³。察哈尔正黄旗“总管驻木孙忒克山，东至镶黄旗察哈尔之

³⁹ 金志章、黄可润：《口北三厅志》卷 7《藩卫志》。

⁴⁰ 金志章、黄可润：《口北三厅志》卷 1《口北三厅全图》。

⁴¹ 朱诗婷著：《清代察哈尔游牧八旗政区边界研究》，第 41 页。

⁴² 参见额而敦巴特尔著：《崇礼县境内的察哈尔镶黄旗蒙古人》，张家口·冬奥会与一带一路学术研讨会，2016 年，第 136 页。

⁴³ 金志章、黄可润：《口北三厅志》卷 7《藩卫志》。



喀喇鄂博图界五十里”⁴⁴。显然，喀喇鄂博图的位置是确定察哈尔镶黄旗西界的关键，但喀喇鄂博图的具体位置尚未发现。

因而，只能利用双方距离来进行大体估算，正黄旗的驻地木孙忒克位于今乌兰察布市察哈尔右翼后旗东南大六号乡境内（北纬 41.27 度，东经 113.27 度）⁴⁵。史料中，两地之间的距离是 120 里，然而实际当中则为 400 余里。显然，用距离折算也无可能。因此，只能根据距离比例大体估算两地之间的分界，应在乌兰察布市商都与化德两县交界的商都县十八顷镇附近（北纬 41.63 度，东经 113.91 度）。

西南界的赤老图即蒙古语 *čilaγu*，意思为石头，因此不具有定位功能。文献中察哈尔镶黄旗西南界距离镶黄旗山 55 里，而且与镶黄旗牧厂接壤。这一记载显然有误。因为按距离推断该点超出了镶黄旗西北界的范围。一统志中关于正黄旗牧厂的范围时记载到“东北至镶黄旗察哈尔界一百十里”，可见，镶黄旗察哈尔在西南应与正黄旗牧厂接壤，按双方距离推断大体位置为康保县忠义乡忠义南村（北纬 41.65 度，东经 114.46 度）附近。

4、镶黄旗的北界与西北界

镶黄旗“北至乌兰诺尔苏尼特右翼界一百二十里……西北至登社胡图克察哈尔正黄旗界，又苏尼特界一百三十里。”⁴⁶ 乌兰诺尔位于今镶黄旗翁工乌拉苏木的乌兰诺尔（北纬 42.56 度，东经 113.88 度），该地现仍为镶黄旗与苏尼特右旗的分界。

登社胡图克的位置尚无法确定，按距离推断，应位于商都县、苏尼特右旗、镶黄旗三地交界一带（北纬 41.99 度，东经 113.34 度）。

5、镶黄旗的东界与东北界

镶黄旗“东至托克洛河察哈尔正白旗界九十里……东北至诺浑奴鲁苏尼特界一百二十里”⁴⁷。托克洛河就是今天锡林郭勒盟正镶白旗的布尔嘎斯图高勒，此河为南北流向。正白旗总管驻地布尔噶台位于今锡林郭勒盟正镶白旗布日都苏木（北纬 42.56 度，东经 114.82 度）⁴⁸。如在布日都和镶黄旗山之间做一连线，这条线穿过正镶白旗的星耀镇西北部，布尔嘎斯图高勒从该处流过。因此，可以断定察哈尔镶黄旗的东界就位于星耀镇西北一带（北纬 42.20 度，东经 114.88 度）。

⁴⁴ 金志章、黄可润：《口北三厅志》卷 7《藩卫志》。

⁴⁵ 潘小平、武殿森：《察哈尔史》，第 205 页。

⁴⁶ 金志章、黄可润：《口北三厅志》，卷 7《藩卫志》。

⁴⁷ 金志章、黄可润：《口北三厅志》，卷 7《藩卫志》。


⁴⁸ 周清澍：《内蒙古历史地理》，呼和浩特：内蒙古高等教育自学考试委员会编印，1991 年，第 183 页。



THE CULTURAL WAY

诺浑奴鲁即今苏尼特右旗赛罕乌力吉苏木的瑙滚努如山（北纬 42.65 度，东经 113.88 度）附近⁴⁹。

综合以上考证和推测，可将清中叶镶黄旗牧厂和察哈尔镶黄旗八至示意图绘制如下：



⁴⁹ 朱诗婷：《清代察哈尔游牧八旗政区边界研究》，第 39 页。



THE CULTURAL WAY

清中叶镶黄旗牧厂和察哈尔镶黄旗四至示意图

说明：各坐标点信息详见表 1.1-表 1.3

表 1.1： 镶黄旗牧厂边界坐标点

坐标点	边界名称	经纬度	古地名	今地名
A	镶黄旗牧厂北界 察哈尔镶黄旗东南界	北纬 41.71 度 东经 114.73 度		康保县郝车信村
B	镶黄旗牧厂东北界	北纬 41.43 度 东经 114.96 度		察北管理区沙沟村
C	镶黄旗牧厂东界	北纬 41.25 度 东经 115.24 度		张北县大囿囿镇万宝庄
D	镶黄旗牧厂东南界	北纬 41 度 东经 114.78 度		张北县旱淖坝
E	镶黄旗牧厂西南界	北纬 41.09 度 东经 114.43 度		张北县大河镇北部
F	镶黄旗牧厂西界	北纬 41.25 度 东经 114.41 度		张北县海流图乡义兴店村
G	镶黄旗牧厂西北界 察哈尔镶黄旗南界	北纬 41.67 度 东经 114.49 度		康保县小麻尼村
	镶黄旗牧厂南界			宣化区与张北县交界长城一 线



THE CULTURAL WAY

表 1.2: 察哈尔镶黄旗边界坐标点

坐标点	边界名称	经纬度	古地名	今地名
H	察哈尔镶黄旗北界	北纬 42.65 度 东经 113.88 度	诺浑奴鲁	苏尼特右旗赛罕 乌力吉苏木瑙滚努 如
I	察哈尔镶黄旗的东界	北纬 42.20 度 东经 114.88 度		太仆寺旗星耀镇西 北
J	察哈尔镶黄旗西南界	北纬 41.65 度 东经 114.46 度	赤老图达坝	康保县忠义南村
K	察哈尔镶黄旗西界	北纬 41.63 度 东经 113.91 度		商都县十八顷镇
L	察哈尔镶黄旗西北界	北纬 41.99 度 东经 113.34 度	登社胡图克	商都县西北
M	察哈尔镶黄旗西北界	北纬 42.56 度 东经 113.88 度	乌兰诺尔	镶黄旗翁工乌拉苏 木 乌兰诺尔



THE CULTURAL WAY

表 1.3: 驻地坐标点

坐标点	经纬度	古地名	今地名
察哈尔镶黄旗驻地	北纬 42.09 东经 114.79 度	苏门哈达 (或苏门峰)	康保县的镶黄旗山
镶黄旗牧厂驻地	北纬 41.20 度 东经 114.73 度	控果罗鄂博冈	张北县小柳沟村
正黄旗牧厂驻地	北纬 41.29 度 东经 114.02 度	诺莫浑博罗山	尚义县黑圪塔山村

四、结 语

本文以历史文献为依据，同时结合考古资料、田野调查以及前人的研究成果，对清代中期镶黄旗牧厂、察哈尔镶黄旗的驻地以及旗界进行了考证，并得出以下结论：

一 通过文献中兴和旧城和沙城两处遗址位置的考证，大体划定镶黄旗牧厂的驻地控果罗鄂博冈位于今张北县小柳沟村，在此基础上考证出镶黄旗牧厂在以今天张家口市张北县为中心北到康保县郝车信村附近、南至宣化区、西到张北县海流图乡附近、东达张北县大囿囿镇附近。

二 文章依据史料中不同语言文字对察哈尔镶黄旗境内骆驼山的记载，进一步论证了康保县境内镶黄旗山就是察哈尔镶黄旗驻地这一结论。同时通过距离远近、移民状况、现存地名等因素得出了文献中的麻泥坝位于今康保县小麻尼村这一结论，最终判定察哈尔镶黄旗以今天张家口市康保县为中心，北到苏尼特右旗赛罕乌力吉苏木瑙滚努如、南至康保县小麻尼村、西到商都县十八顷镇附近、东达太仆寺旗星耀镇西北。



THE CULTURAL WAY

周振鹤先生认为，我国的历史政治地理学研究，在行政区划方面的第一个步骤应该“以复原疆域政区历史变迁的全过程为目的”⁵⁰。本文讨论的区域从清末开始发生了剧烈的变化。在历届中央政府的主导下，这里从察哈尔八旗的游牧地和内务府的牧厂演变为设治局，进而设立县治。这其中的原因是复杂的，既有多年来内地人地矛盾的积累也有庚子赔款的影响，是国际关系、边疆政策、区域治理模式等多层面、多维度碰撞、调适的结果。最终给上述地区在人口构成、地域文化、经济模式等诸多方面带来了深刻的变化，并延续到了当下。因此，廓清边界可以为相关后续研究奠定基础、提供依据。由于个人能力所限，不足之处请方家批评指正。

安宁 男 1982.7

内蒙古大学蒙古历史学系博士生

张家口市行政学院讲师

ABSTRACT

In the Qing Dynasty, the Bordered yellow Banner affiliated with Chahar Eight Banners and the Bordered yellow banner pasture affiliated with Imperial Household Department were connected and both located in today's Bashang region of Zhangjiakou, Hebei Province. Although there is some introduction about the eight Seasons of the two places in the historical materials, due to the reclamation at the end of the Qing Dynasty, the livestock degraded and the farming expanded. these caused some obos used to definite orientation disappeared and place names changed, so that the boundaries of the banners community could not be clarified for a long time. Although predecessors have studied this problem, there are still many contradictions and mistakes. On the basis of historical data analysis, this paper pays attention to the application of archaeological results and the adoption of field investigation data, preliminarily proves the boundary of Chahar Bordered Banner and Bordered Banner pasture in the middle of Qing Dynasty, and draws a map.

Keywords: *Chahar bordered, Yellow banner, Bordered yellow banner, Pasture boundary*

⁵⁰周振鹤：《中国历史政治地理十六讲》，北京：中华书局，2013年，第23页。



НОМ ЗҮЙ

1. 参见赵尔巽著：《清史稿》志 93 职官五（内务府），北京：中华书局，1976
2. 《钦定大清会典》（乾隆）卷 91，庆丰司。
3. 《为领取嘉庆元年份察哈尔镶黄、正黄二旗牛羊群官兵兵丁等俸银两事》：嘉庆元年 3 月 20 日，05-08-007-000002-0026，中国第一历史档案馆藏
4. 《为领取察哈尔三旗牛羊群、达理岗厓羊群一年所需纸张事》：嘉庆元年 3 月 20 日，05-08-007-000002-0028 中国第一历史档案馆藏。
5. 参见徐莉著：《专为皇帝饲养牛羊的机构——清朝内务府庆丰司》，《中国档案》（北京），2014 年第 11 期。
6. 允陶：《钦定大清会典》卷 92，武备院。
7. 参见金海、齐木德道尔吉等编著：《清代蒙古志》，呼和浩特：内蒙古人民出版社，2009
8. 内务府折。内务府奏案：05—0255—025。转引自陈肖寒：《清代直隶口外地区内务府牧厂的管理》，《武汉大学学报》（武汉），2017 年，第 6 期。
9. 阿·马·波滋德捏耶夫：《蒙古及蒙古人》，刘汉明、张梦玲、卢龙译，呼和浩特，内蒙古人民出版社，1989
10. 《嘉庆重修一统志》卷 548《牧厂》，上海：上海书店出版社，1984 年影印版。金志章、黄可润：《口北三厅志》卷六，考牧。
11. 本文中涉及到的蒙古语转写、词义均以内蒙古大学蒙古学研究院、蒙古语文研究所编写，内蒙古大学出版社于 1999 年 6 月出版的《蒙汉词典（修订本）》为依据，之后不再单独注释。
12. 河北省张北县地名办公室：《张北县地名资料汇编》，1984
13. 《嘉庆重修一统志》卷 548《牧厂》，上海：上海书店出版社，1984 年影印版。
14. 朱诗婷：《清代察哈尔游牧八旗政区边界研究》，硕士学位论文，中国人民大学，2015
15. 金志章、黄可润：《口北三厅志》卷六，考牧。
16. 民国《察哈尔省通志》，卷 4，《疆域篇之四》，郑州：中州古籍出版社，2016 年影印本。
17. 朱诗婷：《清代察哈尔游牧八旗政区边界研究》
18. 马宝军：《镶黄旗志》，呼和浩特：内蒙古人民出版社，1999
19. 潘小平、武殿森：《察哈尔史》，呼和浩特，内蒙古人民出版社，2012
20. 参见额而敦巴特尔著：《崇礼县境内的察哈尔镶黄旗蒙古人》
21. 周清澍：《内蒙古历史地理》，呼和浩特：内蒙古高等教育自学考试委员会编印，1991
22. 周振鹤：《中国历史政治地理十六讲》，北京：中华书局，2013

**ШИНЭ ЭРИНЭЭС НААШ ДУНДАД УЛСЫН ОРЧИН ҮЕИЙН УТГА
ЗОХИОЛЫН МОНГОЛ УЛАМЖЛАЛЫГ ХҮЛЭЭН АВАХ ОРЧИН АХУЙН
СОНГОЛТ БА НӨЛӨӨ ТУСГАЛ**

Кань Хай Ин*

ХУРААНГУЙ

Шинэ эринээс нааш нийгэм түүх, улс төр, утга соёлын орчин нь дундад улсыг орчин үеийн утга зохиолын монгол уламжлан тархахад нөхцөл бүрэлдүүлэн өгчээ. Мөн ч тухайн үеийн монгол орчуулгын үйлсийн биеч ба бусдач талын нөхцөл нь дундад улсын орчин үеийн утга зохиолын уламжлан тархахын зайлшгүй чанарыг буй болгосон байна¹.

Түлхүүр үгс: *Шинэ эрин, Дундад улсын орчин үеийн утга зохиол*

Шинэ эринээс нааш нийгэм түүх, улс төр, утга соёлын орчин нь дундад улсыг орчин үеийн утга зохиолын монгол уламжлан тархахад нөхцөл бүрэлдүүлэн өгчээ. Мөн ч тухайн үеийн монгол орчуулгын үйлсийн биеч ба бусдач талын нөхцөл нь дундад улсын орчин үеийн утга зохиолын уламжлан тархахын зайлшгүй чанарыг буй болгосон байна.

Нэг. Улс төр ба утга соёлын орчинахуй

(Нэг) Улс төрийн ба Утга соёлынорчин.

1. Улс төрийн орчин. 20 дугаар зууны 70-аад оны сүүлээс 80-аад оны эхэн хүртэл манай улсын түүхэн шинэ эриний эхлэлийн хугацаа юм. Тухайлбал намын 11 дүгээр хугацааны төв хорооны гуравдугаар бүгд хуралдаанаас энэхүү алс хэтийн ач холбогдолтой аугаа их түүхэн шинэ эриний эргэлтийн цаг үеийг нээсэн билээ. Тус хуралдаан “Соёлын их хувьсгал”-ын хөдөлгөөн бол улс байгуулагдсанаас нааш “зүүн”-ий шугамын нөлөөлөл доорх олон удаагийн улс төрийн хөдөлгөөний үргэлжлэл буюу оргил болсон улс төрийн их самуурал гэснийг онол ба үйлдлийн талаар тодорхойлжээ. Мөн ч манай улсад хойшид соёлын их хувьсгалын дэгдээсэн самуурлыг төвшитгөж, аж ахуйг хөгжүүлэхийг гол болгох зөв оновчтой шийдвэрийг батлав. Намын төв хороо тус хуралдааны үзэл санааг даруйхан доошлуулж, бүх улсын эл газарт нарийн хянамгайгаар үнэнээс зөвийг эрж, алдаа байвал залруулах зарчмаар түүхэн үлдэгдэл хилс хэрэг буюу соёлын хувьсгалын дундах хилс хэргийг байцаан тодорхойлох

* ӨМИС, Монгол Судлалын Дээд Сургуулийн багш

¹ Тус өгүүлэл Хятадын философи, НШУ-ы Академийн төслийн хүрээнд бичигдсэн онцлох бүтээл болно. Баталгаажуулалтын дугаар (21XZW036)



THE CULTURAL WAY

үзлийг өрнүүлжээ. Тэдгээр хилсээр хорлол амссан бүх шатны нам, засаг, цэргийн кадр, ардчилсан хүмүүс, гадаадад суралцаж байсан мэргэжилтнүүд, судлаачид, хэсэг сэхээтнүүдийн хилсийг цагаатгаж нэр алдрыг нь сэргээж, ажил амьдралыг нь зохистойгоор тохируулжээ². 1980 оны 2 сард намын 11 дүгээр хугацааны төв хорооны тавдугаар бүгд хуралдаанаас соёлын их хувьсгалын хугацаанд Лю Шаочи-д өгсөн улс төрийн дүгнэлт болон зохион байгуулалтын шийдвэрийг бүрмөсөн хүчингүй болгов. Үүний хамт их хурлаас Лю Шаочи-г аугаа их марксын үзэл, үгээгүй ангийн хувьсгалч, нам төрийн удирдагчийн нэр алдрыг шүүн цагаатгасан билээ³.

Манай улс тухайн үед дээрх мэт улс төрийн их самуурлыг төвшитгөж, хилс хэргийг цагаатган бүх улс ажлын гол чиглэлийг аж ахуйн бүтээн байгуулалт дээр шилжүүлэв. Намаас аж ахуйн бүтээн байгуулалт болон ангийн тэмцлийн харилцааны асуудлын тухай улс байгуулагдсанаас нааш зүүний буруу үзэл санааны нөлөөг туйлбартайгаар арилгажээ. Ангийн тэмцлээр хөтөлбөр болгох үеийг зогсоож, намаас нийгэм журмын гол зөрчлийн тухай шинээр тодорхойлолт хийсэн байна. “Манай улсын эдүгээчлэлийн бүтээн байгуулалт эрхиш дундад улсын онцлог бүхий нийгэм журмыг бүтээн байгуулах хэрэгтэй. Энэ бол бидний урт хугацааны түүхэн туршлагаас олсон үр дүн мөн”. Дундад улсын онцлог бүхий нийгэм журмыг бүтээн байгуулах үзэл санаа бол манай улсын өөрчлөлт гэж чөлөөтэй харилцан, аж ахуйн бүтээн байгуулалтыг түргэтгэх шинэ эриний жолоодох үзэл санаа мөн⁴.

12 дугаар их хуралдаан дээр Дөн Шяопин нөхөр өөрийн замаараа явж дундад улсын онцлог бүхий нийгэм журмыг бүтээн байгуулах тухай анх удаа дурдав. Тэрчлэн тус хурлаас төлөвлөгөөт аж ахуйгаар гол болгож, зах зээлийн тохируулалтаар хавсрамж болгох тухай дурджээ. Дараа нь 12 лугаар хугацааны гуравдугаар бүгд хуралдаанаас аж ахуйн байгууламжийг өөрчлөх тогтоол батлав. Тус тогтоолд манай улсын нийгэм журамт аж ахуй бол нийтийн уламжлалын суурин дээрх төлөвлөгөөт таваарын аж ахуй болно гэж дурдан гаргаад, таваарын аж ахуй бол нийгэм журмын аж ахуйн хөгжлийн алслаж гарч болшгүй шат үе мөн хэмээснийг тодорхойлов. 12 дугаар хугацааны дөрөвдүгээр бүгд хуралдааны дараа Жян Зөминь нөхрөөр гол болгосон намын төв хороо “нэг голдлого хоёр үндсэн зүйл” гэх үндсэн шугамыг гуйвшгүй хэрэгжүүлэв. Мөн ч тус хурлаас нийгэм журмын төлөвлөгөөт аж ахуйн байгууламж бол төлөвлөгөө болон зах зээлийн дотоод нэгдсэн байгууламж байх хэрэгтэй гэжээ. Бид таваарын аж ахуйн хөгжилтэй зохицсон төлөвлөгөөт аж ахуй болон зах зээлийн тохируулалтыг уялдуулсан аж ахуйн байгууламжийг байгуулна гэж дурдав⁵. Тус

² Сарнаа: “Өнөр цэцгийн хагас зуун (1955-2005), ӨМАХХ, 2005 т 175.

³ Сарнаа: “Өнөр цэцгийн хагас зуун (1955-2005), ӨМАХХ, 2005 т 176.

⁴ Сарнаа: “Өнөр цэцгийн хагас зуун (1955-2005), ӨМАХХ, 2005 т 177.

⁵ Сарнаа: “Өнөр цэцгийн хагас зуун (1955-2005), ӨМАХХ, 2005 т 266.



THE CULTURAL WAY

яриандаа: “...Төлөвлөгөөт аж ахуй нь нийгэм журам болчихдог биш, хөрөнгөт ёсонд ч төлөвлөгөө байдаг. Зах зээлийн аж ахуй нь хөрөнгөт ёс болчихдог биш, нийгэм журамд ч зах зээл байдаг. Төлөвлөгөө ба зах зээл нь цөм аж ахуйн арга хэрэглүүр мөн. Төлөвлөгөө илүүвтэр байх уу эсвэл зах зээл илүүвтэр байх уу гэдэг нь нийгэм журам болон хөрөнгөт ёсны мөн чанарын ялгаа биш” гэж тодорхой зааж гаргав. Дөн Шяопин нөхрийн зааж гаргасан нийгэм журмын төлөвлөгөөт аж ахуй болон зах зээлийн аж ахуйн харьцааны тухай магадлалт нь аж ахуйн өөрчлөлтийн тухай хүмүүсийн уламжлалт мэдлэг ойлгогдохууныг өөрчлөх зүглүүр болжээ. Намын 14 дүгээр их хурлаас манай улсын зах зээлийн аж ахуйн байгууламжийг байгуулах нөхцөл буюу хэв загварын тухай “Өөрчлөлт гэж чөлөөтэй харилцах бол үйлдвэрлэлийн хүчийг хөгжүүлэхийн зайлшгүй явах зам мөн. Үйлдвэрлэлийн хүчний хөгжлийг хүлээсэлж байгаа аж ахуйн байгууламжийг үндсээр нь өөрчилж, нийгэм журмын зах зээлийн байгууламж байгуулах хэрэгтэй”⁶ гэж заажээ. 2001 онд дундад улс дэлхийн худалдааны зохион байгуулалт (WTO)-д орж, мөн тус онд “цахим хууль”-ийг тогтоосон байна. 2001 онд Бээжин олимпыг зохион байгуулах эрхийг олж, 2008 онд олимпын уралдаан тэмцээнийг амжилттай зохион байгуулав. Дундад улсын Эв хамт намын удирдлага доор улс төр, аж ахуй хурдан хөгжиж, дэлхий дээрх байр суурь тасралтгүй дээшилсэн байна.

2. Утга соёлын орчин. 70-аад оны сүүл 80-аад оны эхээр өргөнөөр тархсан “Шинэ цаг үе”-ийн үзэл ухамсрын охь нь “шинжлэх ухаан, ардчилал”-аар агуулга болгосон “эдүгээчлэл”-ийн гал халуун хүсэл хөөцөлдөл болно. Иймэрхүү үзэл ухамсар нь голдуу хоёр талаар илэрдэг. Нэг нь өнгөрсөн цаг үе (соёлын их хувьсгал)-тэй тусгаарлаж, ирээдүйн замаа тогтоох, нөгөө талаар голдуу түүхийн асуулт ба бодолхийллийг дахин харах зэрэг болно. 70-аад оны сүүлээр бүх зүйлийн нөхцөлийн түлхэцэд, үзэл санаагаа чөлөөлөх хүчтэй урсгал түрэн орж ирсэн байна. 1978 оны 5 сарын 11-ний өдөр “Гуанмин өдрийн сонин” дээр “үйлдэл бол үнэн ёсыг шалгах цорын ганц баримжаа мөн” гэх зохиол нийтлэгдэж, бүх улсын хэмжээнд “үнэн ёсны баримжаа”-ны тухай ярилцлага өрнүүлэв. Тус онд намын төв хорооны 11 дүгээр хугацааны гуравдугаар их хуралд “үйлдэл бол үнэн ёсыг шалгах цорын ганц баримжаа мөн” гэх үзэл санааг чөлөөлөх сэдвийг дэмжсэн байна. Энэ удаагийн хурал нь 80-аад оны дундад улсын нийгмийн эргэлт хүнд чухал утга агуулгатай. 1979 оны 10 сард бүх улсын дөрөвдүгээр удаагийн утга урлагийн их хурлыг хуралдуулав. Тус хуралд “утга урлаг ардчилал”-ын шаардлага ба төсөөлөн бодох нь хөгжөөнтэй илтгэгдсэн байна. 1956 онд дурдан гаргасан боловч үнэнхүү үр бүтээмжтэй үйлчилсэнгүй “цэцэг бүхнийг зэргээр дэлгэрүүлж, эрдэмтэн бүхнийг чөлөөтэй яриулах” чиглэлийг дахин хянаж, хожим нь 1984 оны 12

⁶ Сарнаа: “Өнөр цэцгийн хагас зуун (1955-2005), ӨМАХХ, 2005 т 267.



THE CULTURAL WAY

сараас дараа жилийнх нь 1 сар хүртэл дундад улсын зохиолчдын дөрөвдүгээр удаагийн хурлыг хуралдуулж, утга урлагийн зохиол бүтээлийн эрх чөлөөний үрийг дурдан гаргахдаа: “зохиолчид сэдэвлэхүүн, гол сэдэв ба урлагийн илрүүлэх аргын бүрэн төгөлдөр эрх чөлөөтэй, өөрийн хайр сэтгэлгээ, оргилом сэтгэлгээ ба өөрийн үзэл санаагаа илтгэх бүрэн төгөлдөр эрх чөлөөтэй”, “манай нам ба засаг, утга урлагийн бүлгэм нийт жич бүх нийгмийнхээ зохиолчдын зохион бүтээх эрх чөлөөг баримтлах ба батлах хэрэгтэй” гэжээ.

1983 онд өрнүүлсэн “үзэл санааны бохирдлыг арилгах” хөдөлгөөн, ондоошил, хүмүүнлэг үзлин ярилцлага ба шүүмжлэл хийгээд 1987 оны “хөрөнгөтөн ангийн эрх чөлөөжлийг эсэргүүцэх” зэрэг нь 80-аад оны үзэл санаа соёл, мөн ч уран зохиолын цар хүрээндэх чухал хэрэг явдал болно⁷. Өвөр монголын өөртөө засах орны утга урлагийн ажилтны гуравдугаар удаагийн төлөөлөгчдийн их хурал 1980 оны 7 сарын 14-24-ний өдөр хүртэл Хөх хотод амжилттай хуралдав. Тус хуралд бүх орны 8 аймаг, 3 хот (тухайн үеийн)-оос хүрэлцэн ирсэн бүх үндэстний төлөөлөгчид оролцов. Урилгаар зарим мужийн холбогдол бүхий байгууллага нэгжийн төлөөлөгчид иржээ. Өвөр монголын утга урлагийн холбооны дэд тэргүүлэгч, зохиолч Одсэр хурал нээх үг хэлж, ӨМӨЗО-ы намын хорооны хоёрдугаар дарга Тин Мао их хурал дээр баярын үг хэлэв. ӨМУУХ-ны тэргүүлэгч Юнь Жаогуан “бүлгэмдэж, утга урлагийн шинэ оргилд авирахаар хичээтүгэй” гэх сэдэвт ерөнхий мэдэгдэл хийв. Тус хурал бол 1960 онд хуралдсан манай орны утга урлагийн ажилчдын хоёрдугаар удаагийн төлөөлөгчдийн их хурлаас 20 жилийн дараа хуралдсан их хурал билээ. Энэхүү хурал дээр ӨМӨЗО-ы нам засгаас манай орны утга урлагийн хөдөлгөөний яруу алдарт түүхэн уламжлалыг үнэлэн сайшаав. Эдгээр үнэлэлт бол даруй намын 11 дүгээр хугацааны төв хорооны гуравдугаар их хуралдааны үзэл санааг манай орны утга урлагийн ажлыг бататгасны бодит биелэл болно. Тус хурал чөлөөлөгдсөнөөс нааш манай орны утга урлагийн ажил хэт зүүн шугамын нөлөөллөөр харш саадад учирсан ба нэн ч Линь Бяо “дөрвөн хүний бүлгэм” өвөр монгол орны утга урлагийн ажил буюу амжилтад учруулсан гай гамшиг зэрэг түүхэн туршлага сургамжийг дүгнэсэн юм. Их хурлаас бас бүх үндэстний утга урлагийн ажилчдын шинэ эриний утга урлагийн ажлын үүргийг тодорхойлон дурджээ. Манай орны утга урлагийн ажилчдын хоёрдугаар удаагийн төлөөлөгчдийн их хурлаас нааш, ялангуяа соёлын их хувьсгалын самуурал дунд талхигдсан бүх эвлэлийн байгууламжийг тус удаагийн их хурлын тогтоолоор үндэслэл болгон дахин сэргээн сонгож батлав. Ингэж утга урлагийн тусгай мэргэжил төрлөөр хуваарилсан бүх эвлэлийг зохион байгуулж, тус бүр төлөөлөгчдийн их хурал хуралдуулаад бүх эвлэлийн байгууламж шинээр сонгогдон буй болов. Энэ нь шинэ эринд утга урлагийн бүх эвлэлийн

⁷ 洪子诚著：《中国当代文学史》，北京大学出版社，2004年，第227页。



THE CULTURAL WAY

ажлыг өрнүүлэх зохион байгуулалтын системийг тохируулан бүрэлдүүлжээ.

1980-1981 онд намын төв хорооны дарга нарын газраас төвөд, юньнань, шиньжян, өвөр монгол зэрэг муж, өөртөө засах орны асуудлын тухай тусгай хурал хуралдуулж, цөөн тоот үндэстний тухай төрийн бодлогыг нарийн хянамгай бататгав. Үргэлжлүүлэн 1982 онд намын төв хорооноос сэхээтнүүдэд эрдмийн цол олгож байсан дүрмийг сэргээсэн байна. Манай орны мөн улсын бүх газартай адилаар үндэстний төрийн бодлогыг доошлуулах зэргээр сэхээтний төрийн бодлогыг бататгаад шинэ эргэлт гаргалаа. Үүний хамт 80-аад онд их сургууль төгссөн залуу оюутнуудын дотроос ажилтан шалгаруулж, манай орны утга урлагийн гол хүч болгов. 80-аад онд манай орон соёлын их хувьсгалаас өмнө эрхэлж ирсэн угийн монгол сонин сэтгүүлийг бүрмөсөн сэргээх буюу шинээр эрхлэх болов. 80-аад онд зарим хошуу ч тогтмол бус хугацаатай утга урлагийн сэтгүүл эрхлэх болжээ. 80-аад онд манай орны монгол сонин сэтгүүл, ном хэвлэл урьд өмнө байгаагүй хурдцаар түргэн хөгжиж эхэлсэн билээ⁸. 1986 оны 9 сард намын 12 дугаар хугацааны төв хорооны зургадугаар бүгд хуралдаанаас “нийгэм журамт оюуны боловсон бүтээн байгуулалтын жолоодох чиглэлийн шийдвэр”-ийг нийтлэв. Энэхүү шийдвэрт нийгэм журамт оюуны боловсон бүтээн байгуулалтын баримтлах бодлогын байр суурь ба үндсэн үүргийг тодорхойлов. Үүнээс гадна, улс даяар нийгэм журамт ёс суртахуун хэв заншлыг буй болгон бадруулж, нийгэм журамт ардчилал, хууль цааз, сахилга батын хүмүүжлийг чангатган, соёл сурган хүмүүжил, шинжлэх ухаан техник мэргэжлийг хялбаршуулахыг чухалчлан шаардав. 90-ээд онд нэг талаар “эдүгээчлэл” нь нэг зүйлийн бодитой нийгмийн бүтээн байгуулалтын хэлбэр болсны хувьд бүрэн төгөлдөр үйлдэл ба өрнөлт олж, нөгөө талаар сэхээтнүүдийн эдүгээчлэлийн байдал ба соёлын холбон бодолт ч 80-аад онтой адилгүй өөрчлөлттэй болжээ. Соёл үзэл ухамсар ба уран зохиолын агуулгын талаар 80-аад оны хувьсгалын онолын хэв маягийн баясангуй сэтгэлгээ буурч, гиоүрэл бухимдал, шүүмжлэл ба өөрийн шүүмжлэлийн үндсэн хөг аяс товойн гарсан байна.

Хоёр. Дундад улсын орчин үеийн утга зохиолыг хүлээн авах биеч ба бусдач ахуй

1. Хүлээн авах биеч ахуй. Шинэ эринээс нааш орчуулгын утга зохиолыг өргөн хэмжээнд хүндэтгэж эхэлсэн байна. Орчуулга бол нэг зүйлийн бүтээлч үйл ажиллагаа болно. Үндэстэн нэг бүрийн үг хэл үсэг бичиг ондоо бөгөөд орчуулагчийн уг бүтээлийн тухай ойлголт болон уг бүтээлийн хэв маягийн хооронд ч зөрөөтэй байдаг. Түүнчлэн орчуулагчийн ойлголт болон түүний илтгэх чадварын хооронд ч ялгаа гардгийг үгүйсгэж болохгүй юм. Адил бус хэлний хооронд утга зохиолыг орчуулах явцад уг бүтээл болон орчуулагч хоёр

⁸ Сарнаа: “Өнөр цэцгийн хагас зуун (1955-2005), ӨМАХХ, 2005 т 179.



THE CULTURAL WAY

талын үйлдэл үзүүлж байдгийг орчуулагдсан бүтээлээс олж харна. Уншигчдад авч хэлбэл орчуулгын утга зохиол уг бүтээлийн дагалт болох бөгөөд ур цогц нь болдог. Иймээс орчуулгын утга зохиол нь аль болох уг бүтээлийн хэв маяг, хөг аяс, утга агуулгыг бүрэн оновчтой орчуулж гаргах ёстой юм. Орчуулга бол утга зохиолын үүдэн бүтээх нэг зүйлийн хэлбэр мөн. Гоо зүйн цар хүрээнд харьяалагдана. Уг бүтээлийн агуулга хийгээд хэлбэрийн нэгдэл дунд урлагийн үнэнийг харуулдаг. Фу Лэй: “Орчуулга бол яг зураг зурахтай адил, хэлбэр адил байх тухай хөөцөлддөггүй, амин сүнс адил байхыг хөөцөлддөг юм”⁹ гэжээ.

Нийгмийн дэвшил ба харилцааны өргөжлийг дагалдан үндэстнүүдийн хоорондох үзэл санаагаа ойлголцох хэрэгцээг хангахын тулд орчуулга буй болсон байна. Адил бус үндэстнүүд харилцан адил амьдралаа мэдэлцэн сэтгэл санаагаа ойлголцож чаддаг. Үүнд гүүр, зуучийн үйлдэл гаргаж байгаа нь орчуулга болно¹⁰. Үндэстэн нэг бүрийн хэл нь бүгд өвөрмөц онцлогтой, энэхүү өвөрмөц онцлог нь бүгд тус хэлийг үүдэн бүтээсэн үндэстний соёл түүх, эрхэлж байгаа ажил төрөл, баримталж буй заншил дадал, шүтэж байгаа шашин шүтлэг ёс суртахуун зэрэгтэй шууд холбоотой байдаг. Орчуулгын ухаан нь хүн соёл, нийгмийн шинжлэх ухаан, байгалийн шинжлэх ухааны зах хөвөөн шинжилгээний салбар болсны хувьд өөрийн оршихуйн арга маяг байдаг.

Тоури (Gideon Tougy): “Орчуулга бол гол нь түүхийн хязгаарлалыг хүлээх орчуулах хэлэнд хандуулсан үйл ажиллагаа мөн. Харин дан ганц хэлний солилцоо төдий биш”¹¹ гэжээ. Н.Конрад: “Орчуулга бол орчуулсан улсын хэлийг баялагжуулах хүчтэй арга хэрэглүүр мөн. Түүний илэрхийлэх шинэ арга барилыг баялагжуулах хүчтэй арга барил мөн. Шинэ найруулгын арга барилыг эзэмших сайн арга хэрэглүүр, утга зохиолын орчуулгад авч хэлбэл, шинэ онтологийг эзэмших шалгарсан арга хэрэглүүр юм. Иймээс уг хэл бол орчуулгын дундах бэрхшээлийг тэвчиж чаддаг”¹² гэжээ.

Орчуулга нь зөвхөн дахин үйлдэх ба дуурайх биш, харин соёлыг зохицуулах ба соёлыг хүлээсэн хязгаарладаг байна¹³. Гегель: “Урлаг бол байгалийг номхотгодог, урлаг бол нэг зүйлийн холбон бодолтын хувьд жинхэнэ үүдэн бүтээлт мөн”¹⁴ гэжээ. Хомес (霍姆斯 *huo tu si*): “Орчуулгын ухааны хоёр гол нөхцөл бол орчуулгын явц ба орчуулга бүтээлийн бүх зүйлийн үзэгдлийг бусдачаар дүрслэн зураглах, дээрх үзэгдлийг дүрслэн бичих ба төсөөлөн бодох энгийн ёсыг байгуулах болно”¹⁵ хэмээжээ.

⁹ 陈惇, 刘象愚著: 《比较文学概论》, 北京师范大学出版社, 2004年, 第213页。

¹⁰ 李伟著: 《中国近代翻译史》, 齐鲁书社出版发行, 2005年, 第1页。

¹¹ 谢天振著: 《译介学》, 上海外语教育出版社, 1999年, 第17页。

¹² 谢天振著: 《译介学》, 上海外语教育出版社, 1999年, 第244页, 第111页。

¹³ 廖七一: 《研究范式与中国译学》, 《中国翻译》, 2001年第5期, 第18页。

¹⁴ 重庆炳: 《文学理论教程》, 高等教育出版社, 2002年, 第111页。

¹⁵ 廖七一: 《研究范式与中国译学》, 《中国翻译》, 2001年第5期, 第17页。



THE CULTURAL WAY

Лениний зааснаар: “Орчуулагчийн үзэл санаа нь заавал тусгах бай хийгээд уг бүтээлтэй ойртох хэрэгтэй. Орчуулагч заавар уг бүтээлийн хэлбэр ба агуулгын нэгдлийг дахин илрүүлж уг бүтээлтэй төсөөтэй урлагийн цогцыг дахин бүтээх хэрэгтэй. Энэхүү нөхцөлийг үндэслэвэл, орчуулагч заавал урлагийн шаардлагыг журамлаж, орчуулагч нь хэлний найруулга дээр уг бүтээлтэй нийцүүлэх хавсрах үйлдэл үзүүлдэг”¹⁶ гэнэ. Орчуулагч бол уг бүтээлийн уншигч мөртөө орчуулгын зохиолын бүтээгч мөн. Бүхийл орчуулгын явцад орчуулагч бол зангилаа болж байдаг. Орчуулагдах хэлний зохиол бүтээлийн мэдээллийг орчуулагч орчуулгын хэлэнд хэрхэн “зөв оновчтой, үнэнч”-ээр илтгэх, яаж илтгэх нь эцсийн эцэстээ орчуулагчаас шийдвэрлэгддэг. Н.Сайнцогт, Б.Бүрэнбэх, Содбилэг, Дугарсүрэн, Сольфунгаа, Пэрэнлэй, М.Хишигжаргал, Оргил, Жигжид, Агдунгаа, Боргил, Б.Гэрэлт, Н.Сундуй, Т.Сайнбаяр, Ардай, Одсэр ... зэрэг наяд гаруй орчуулагчаар бүрэлдсэн орчуулагчийн эгнээн орчуулж нийтэлсэн зохиол бүтээл нь нийгэм даяар орчуулгын үлгэр жишээ зохиолууд гэж үнэлэгджээ.

2. Хүлээн авах бусдач ахуй. Шинэ эринээс нааш орчуулагчийн байр суурь доошилж, орчуулагчийн эгнээ дахин сэргэсэн байна. орчуулагч бол зохиолч болоод урлагч мөн. Орчуулагч бол уг бүтээлийн уншигч бөгөөд уг бүтээлийн амь насны үргэлжлэлийн хэлбэр мөн. Орчуулагч уг бүтээлийг өөрийн ойлголтоор дахин үүдэлт хийж, утга зохиолын дамжуулга дунд хүлээгч авагч бөгөөд ахлагч этгээд мөн¹⁷. Монголын орчуулгад үгчилсэн ба утгачилсан гэх хоёр зарчим бий¹⁸. Орчуулагч уг бүтээлийг эрхбиш гүйцэд судалсан суурин дээрээ ажлаа эхлүүлбэл зохино. Утга зохиолын бүтээлийг орчуулахдаа уг бүтээлийг эндүү ойлгохгүй байдалд орчуулга нь нийцтэй сайхан орчуулж, орчуулгын зохиол нь уг бүтээлтэй урлагийн үр бүтээмжтэй байх хэрэгтэй. Уншигчид зөвхөн харь улс үндэстний амьдрал үзэл санаанд сонирхолтой болохоор үл барам, бас үүний дундаас ашигтай зүйлийг сурч авбал зохино гэж тухайн үеийн монголчлогчид зорьж байв.

70-аад оны сүүл 80-аад оны эхнээс намын 11 дүгээр хугацааны төв хорооны гуравдугаар бүгд хурлаас бүх нам, бүх улсын ажлын гол зүйлийг аж ахуйн бүтээн байгуулалтад шилжүүлж, дөрвөн үндсэн зарчмыг баримтлан, өөрчлөлт хийх, чөлөөтэй харилцахыг баримталж, нийгэм журамт дөрвөн өөрчлөлтийн бүтээн байгуулалтын шинэ цаг үе эхэлснээс аваад, монгол үндэстний орчуулгын утга зохиолын самуурлыг үнэнхүү засан зүгшрүүлэх, зохиолч орчуулагчид үзэл санаагаа чөлөөлөн хорио цээрийг эвдэж, уран бүтээлийнхээ шинэ алхмыг эхэлсэн байна¹⁹. Иймээс монгол орчуулгын утга

¹⁶ 谢天振著：《译介学》，上海外语教育出版社，1999年，第111页。

¹⁷ 谢天振著：《译介学》，上海外语教育出版社，1999年，第111页。

¹⁸ Д.Цэрэнсодном: “Монгол шүлгийн онол түүхийн зарим асуудал”, ӨМСХХХ, 1983 т 128.

¹⁹ Т.Сайнбаяр: “Дундад улсын монгол үндэстний утга зохиолын түүх”, ӨМСХХХ, 2003 т 316.



THE CULTURAL WAY

зохиол нь монгол үндэстний утга зохиолын хөгжилд чухал байрыг эзэлсэн мөртөө орчуулгын зохиолчдын эгнээ өргөжиж, орчуулгын зохиолын тоо олширч, орчуулгын зохиолын чанар чансаа дээшилж, орчуулгын зохиолыг бичих арга барил ч өөр болж -шинэ, хачин, сонирхолтой бол эхэлсэн байна²⁰. Монгол орчуулгын үйлс ч өнгөрсөн соёлын их хувьсгалын хорио цээрийг эвдэж, үндэстний хэвлэлийн хороо, өвөр монголын ардын хэвлэлийн хороо, өвөр монгол сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, Ляонин-ий ардын хэвлэлийн хороо, хар мөрний ардын хэвлэлийн хороо, Хөнань-ий ардын хэвлэлийн хороо, Гириний ардын хэвлэлийн хороо зэрэг хэвлэлийн хороо байгууламжууд өнгөрсөн үед хэвлэгдсэнийг ба шинээр орчуулан хэвлүүлж, ихэнх сонин сэтгүүл “Өвөр монгол өдрийн сонин”, “Хөлөн буйрын өдрийн сонин”, “Баян нуурын өдрийн сонин”, “Шилийн голын өдрийн сонин”, “Алшаагийн өдрийн сонин”, “Жиримийн сонин < Тунляогийн өдрийн сонин >”, “Ордосын сонин”, “Улаанцавын сонин”, “Хинганы өдрийн сонин”, “Улаанхадын өдрийн сонин”, “Дэлхийн утга зохиол”, “Алтан түлхүүр”, “Тураг сараана”, “Хөлөн буйр”, “Шар мөрөн”, “Хилчид” зэрэг сонин сэтгүүлийн хэвлэл сэргэж, орчуулгын утга зохиолыг нийтлүүлэн хэвлүүлснээс аажмаар сэргэлтээс өрнөл хөгжлийн шатанд орсон байна.

90-ээд оны хүмүүсийн эдүгээчлэлийн үзлийн элемент дунд, эн тэргүүнд “даяарчлал”-ын хөгжлийн тухай үзлийн хувьсгал, дараа нь адил бус соёлын хэлбэр ба соёлын зогсолтын илээр илэрсэн явдал болно. 90-ээд онд дундад улсын хэрэглээний соёлын үндсэн хөгжил бүрэлдсэн байна. “Олон түмэнчилсэн соёл” нь хүмүүсийн голдуу соёлын шаардлага болж, үндсэндээ аж үйлдвэрийн хэлбэрийн үйл ажиллагааны арга хэлбэр болсон байна²¹. Энэ үед хэвлэлийн хороо байгууламжийн үүрэглэх үйлдэл, сонин сэтгүүлийн уламжлан тархаалт, олон түмэнч дамжуулгын зуучлуурын түгээмэлжил, цахим, блог дээрх уран зохиол зэрэг илэрснээс шинэ зуунаас нааш нэлээд өрнөлтэй байсан монгол орчуулгын үйлс дахин бууралтын шатандаа орж, дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын утга зохиолын түүхийн хамгийн доод тэмдэглэлийг үүсгэсэн байна.

Гурав. Дундад улсын орчин үеийн утга зохиолыг хүлээн авах зайлшгүй чанар

1. Үндэстний соёлын харилцаа. Хэлний бүтээлч ажиллагаа болсон орчуулга нь үндэстнүүдийн хоорондох үзэл санаагаа солилцох хүрээ хэмжээг өргөтгөж, нийгмийн хөгжил дэвшлийг ахиулах үйлдэлтэй юм. орчуулга бол бүх үндэстний ард түмний үзэл санааг нэвтрэлцүүлж, улс төр, аж ахуй, соёл урлаг, шинжлэх ухаан, техник мэргэжлийн солилцоог ахиулах чухал зэвсэг болж,

²⁰ Т.Сайнбаяр: “Дундад улсын монгол үндэстний утга зохиолын түүх”, ӨМСХХ, 2003 т 316.

²¹ 洪子诚著:《中国当代文学史》, 北京大学出版社, 2004年, 第387页。



THE CULTURAL WAY

өнөөгийн мэдээ мэдээллийн цаг үеийн хамгийн хэрэгцээтэй ажил болж байдаг.

Адил бус үндэстний хоорондох соёлын харилцаа нь өдөр ирэх тутам хөгжөөнтэй явагдаж, харилцан нэг нэгнийхээ соёл боловсролыг танин ойлгож авах “хос чиглэл”-ээр харилцаж байдаг. Утга зохиолын харилцаа нь үндэстний хоорондох соёлын харилцааны чухал нэгэн агуулга болж байх бөгөөд соёлоо харилцан уламжлан дамжуулах гол арга барилын нэг нь болж байдаг. Орчуулгаар дамжиж үндэстний хоорондох утга зохиолын харилцаа өрнөж чадах бөгөөд үндэстний хоорондох утга зохиолын нөлөөлөл буй болж, утга зохиолын харьцуулал судлал ч өрнөх учиртай. Орчуулгын утга зохиолын бүтээлийг хүлээн авч уншин сонирхож, шүүмжлэн судлах нь тэр чигээрээ үндэстний хоорондох соёлын харилцааны илрэл болох юм. Ямарваа нэг үндэстний утга зохиолын хөгжил баялагжил нь нэг талаар тус үндэстний утга зохиолын баялаг өвийн сор дээжийг шилэн уламжласны үр дүн болохоор барахгүй, нөгөө талаар харь бусдын утга зохиолын охь шимийг уусган шингээсэнтэй холбоотой юм. Нэг үндэстний утга зохиол нь үндэстний удамшлаар хичнээн чанга, өвөрмөц шинжээр хэдий өтгөн байсан ч бүр л өөрийгөө түгжиж, харь бусдын утга зохиолтой харилцан тусгаарлаж чадахгүй билээ. Харин ухамсартай буюу ухамсаргүйгээр, мэдэгдэм буюу үл мэдэгдмээр, шууд буюу дамаар, нэг зам буюу олон зөргөөр харь бусдын утга зохиолтой харьцаа холбоо үүсгэж, утга сэдвийн солилцоо, эсвэл урлагийн хэлбэрийн тольчлол, эсвэл зохион бүтээх ур дүйн нөлөөлөл, утга зохиолын үзэл санааны урсгалын хүртээл олгодог. Үүний улмаас үндэстний утга зохиол нь улам илүү нөхвөрлөгдөж баялаг болно.

2. Харилцан ахиулах харилцаа. Орчуулга нь бодит үйлдэл дээрээ голдуу хоёр хэлний солилцоо боловч зөвхөн хоёр хэлний солилцоо огт биш. Мөн чанартаа тэр нь нийгмийн харилцаа, соёлын нэвтрэлцэл, шинжлэх ухаан техник мэргэжил жич таваарын солилцоог ахиулах хэлбэрээр хүн төрөлхтний нийгмийн дэвшил, соёлын хөгжлийг ахиулах зэрэг чухал ач холбогдолтой. Орчуулга нь улс төрийн дайчлах үйлдэлтэй. Өнөө үед шинээр буй болсон техник мэргэжил, давшингүй арга хэмжээ, шинэ нээлт, үүдэн бүтээлт зэргийг уламжлан тархааж, дэлгэрүүлэн түгээмэлжүүлэхэд орчуулга орлож болшгүй гарамгай үйлдлээ үзүүлж байдаг. Шинжлэх ухаан техник мэргэжлийн шинэ үр бүтээмжийг цаг тухайд нь орчуулан танилцуулж, улс орны аж ахуйн хөгжлийг ахиулан, ард түмний соёл шинжлэх ухааны хэр хэмжээг дээшлүүлэн, ард иргэдийн амьдралын ёс чанарыг сайжруулахад орчуулгын үйлдлийг төгс бадруулах хэрэгтэй. Гарцаагүй орчуулга нь аж ахуйг хөгжүүлэх үйлдэлтэй. Дэлхийн алдарт зохиол бүтээл, кино жүжиг, дуу бүжиг, зураг урлал нь орчуулгаар зууч болгож монгол оронд уламжлагдан тархаж, үүний улмаас бид дэлхийн соёл урлагтай танилцан, улс улсын амьдрал тэмцлийг ойлгож чадна. Бид бусад үндэстний гойд сайхан соёл урлагийг сонирхохдоо шилдэг сайхан



THE CULTURAL WAY

соёлын үр жимсийг амтлахдаа орчуулгыг мартаж үл болно. Орчуулгын соёл гэгээрлийг цэцэглүүлэх үйлдлийн хөндөц нь хамгийн их байдаг. Итали улсын харьцуулсан утга зохиолч Мерегалли Францо-ийн үзсэнээр: “Орчуулга бол адил бус хэлний хоорондох утга зохиолын солилцоон дунд хамгийн чухал хамгийн баялаг онцлогтой зууч мөн”²² хэмээв.

Утга зохиолын харилцааны зорилго нь өөрийн утга зохиолоо бусад үндэстэнд таниулах ба бусдын утга соёлоос шим тэжээл хүртэж, өөрийн утга соёлоо нэн дээшлүүлэхийн төлөө юм. орчуулгын бүтээлийг хүлээн авч уншин сонирхох нь харийн хүмүүст авч хэлбэл, бусдын утга соёлоос ондоо үндэстний соёл сэтгэлгээг ойлгохын хамт тухайн үндэстний утга зохиолын байдлыг ойлгож, өөрийнхөө утга зохиолтой харьцуулан судалж, түүний дундаас шим тэжээлийг хүртэж, мөн ч өөрийн утга соёлоо хөгжүүлж дээшлүүлэхийн төлөө билээ. Ийм утга зохиолын солилцооны үйл ажиллагаа нь солилцож байх хоёр талын соёл боловсролыг харилцан ахиулж байдаг.

3. Зайлшгүй чанар. Тухайн үед орчуулгын үйл ажиллагааны өрнөл ба түүний зайлшгүй чанарыг задалбал доорх мэт:

(1) Олон тооны орчуулгын ажилчид илрэн гарсны үр дүн болно. Н.Сайнцогт, Содбилэг, М.Хишигжаргал, Б.Бат, Ренчинков, Сольфунгаа, Насан-Арвидах, Эрдэнэтогтох, Б.Бүрэнбэх, Пэрэнлэй, Дугарсүрэн, Баяр, Маньжав, Гэрэлцогт, Гэээ, Оргил, Насанбаатар, Жигжид, Агдунгаа, Боргил, Б.Гэрэлт, Н.Сундуй, Т.Сайнбаяр, Ардай, Одсэр, Б.Насан-Урт ... зэрэг нэлээд олон орчуулагчид илрэн гарчээ. Ийнхүү орчуулгын эгнээ бүрэлдсэн байна. Тэдний зарим нь шууд орчуулгын ажил хийж, зарим нь ажлын чөлөө завсраар орчуулгын ажил хийдэг байв. Иймээс тэдний боловсролын түвшин нь адил бус юм.

(2) Нам засгаас олон түмний соёл урлагийн амьдралыг баялагжуулан, нийгэм журамт утга урлагийн хүчээр ард түмнийг ухамсарлуулан хүмүүжүүлж, бүтээн байгуулалтын үйлсэд оролцоход дундад улсын орчин үеийн утга зохиолыг монгол хэлээр орчуулах нь цаг үеийн шаардлага болжээ.

(3) Шинэ эринээс нааш бүх нийгмийн төвшрөл, соёл сурган хүмүүжлийн түргэн хөгжил, ард нийтийн соёлын харанхуй бүдүүлэг байдлыг арилгах ажиллагаа амжилттай өрнөсний үр дүнд үсэг бичиг мэдэх, хэрэглэж чадах монгол хүмүүс олшров. Үүнээс болж монгол ном бичиг, сонин сэтгүүлийн уншигчдын тоо ихээр нэмэгдэж монгол хэлэнд орчуулсан ном бичиг, сонин сэтгүүл дэх орчуулагдсан дундад улсын орчин үеийн зохиол бүтээл нь туйлын чухал шаардагдах болов.

(4) Өнөөгийн монгол утга зохиолын хөгжлийг дагалдан, монгол утга зохиолын төрөл зүйл шинээр нэмэгдээд, зохиол бүтээлийн тоо хэмжээ ч олшров.

²² 陈焯, 孙景尧, 谢天振主编: 《比较文学》, 高等教育出版社, 2004年, 第142页。



THE CULTURAL WAY

Гадаад улс, харь үндэстний сонгодог бүтээлүүдийг монгол үндэстний уншигчдад танилцуулж, монгол утга зохиолын бүтээлийг нэн чанаржуулан дээшлүүлэх зэргийг чухалчилж байснаас үзвэл, зөвхөн хэдэн сонгодог бүтээл нь цаг үеийн бодит хэрэгцээг хангаж чадахгүй болсон байжээ.

(5) “Өнөр цэцэг”, “Өвөр монголын өдрийн сонин”, “Дэлхийн утга зохиол”, “Алтан түлхүүр”, “Тураг сараана”, “Хөлөн буйр”, “Алтан гарди”, “Жиримийн уран зохиол”, “Шар мөрөн”, “Цэлгэр тал”, “Залуу зохиолч”, “Хун галуу” ... зэрэг сонин сэтгүүлүүдэд хятад үндэстний олон тооны сонгодог зохиол бүтээлийг орчуулж нийтлэх түүхт их үйлсийг амжилттай биелүүлж чадав. Мөн ч монгол үндэстний ард түмэн төрөлх үг хэл, үсэг бичгээрээ дэлхийн соёл урлаг буюу хятад үндэстний соёл урлагийг хүлээн авах талбар болж байсан байна.

Хоёр. Монгол орчуулгын сонголт ба нөлөө тусгал

Дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга нь агуулга хэлбэрийн талаар зохих сонголт хийж, монгол утга зохиолын үйлдэлд урлагийн хэлбэрийн талаар сонголт хийж, монгол утга зохиолын үйлдэлд урлагийн хэлбэр ба утга зохиолын хэлний талаар зохих нөлөө үйлдэл гаргасан байна.

(Нэг) Монгол орчуулгын сонголт

Аль эртнээс эхлээд хүн төрөлхтний түүхэнд адил бус үг хэлийг хэрэглэж, өөр өөрийн соёлын уламжлалтай үндэстэн илэрсэн байдаг. Харилцан танилцах ба үзэл сэтгэлгээгээ илтгэх, мэдээллийг дамжуулахад орчуулгын үйл ажиллагаа аяндаа үүссэн байна. Иймээс орчуулга бол хүн төрөлхтний нэлээд эртний бүтээлч ажиллагаа болно. Тэр нь нэг зүйлийн хэлээр өөр зүйлийн хэлийг орлуулж, адилхан мэдээллийг дамжуулахаар эхлэл болгож, нэг зүйлийн хэлээр өөр зүйлийн хэлийг орчуулах, нийгэм ба соёлын хүрээний гүн давхаргад нэвчин орж, адил бус хэлний үүрэглэж байгаа соёлын мэдээллийн солилцоо ба солигдлыг биелүүлэх явдал мөн. Үүнээс эхлэн орчуулгын утга зохиол нь үйлдлийн үйл ажиллагааны дэгтэр/*индэр зэргийн шатлаг зам, шат*/-ээс онолын дэгтэрт дэвшсэн байна.

1. Монгол орчуулгын утга зохиолын онтологийн мэдрэмж. Нэг улс буюу нэг үндэстний зохиол бүтээл нь бусад улс буюу үндэстний хэлэнд орчуулагдаж, улс хийгээд улсын хооронд, үндэстэн ба үндэстний хооронд “утга зохиолын хувь барилдлага”-ыг буй болгож харилцаан нөлөөлдөг. Гэхдээ тус улсын ард түмэн буюу бусад үндэстний ард түмэн энэ нөлөөг хүлээн авахдаа гүн гүехний хэмжээ, хүрээ хэмжээний их бага зэрэг нь орчуулгын бүтээлийн материалаар дамжин биелэгддэг. Иймээс орчуулгын утга зохиол бол орчуулгын ухааны чухал нэгэн бүрэлдэхүүн хэсэг болох бөгөөд утга зохиол судлалын анхаарах чухал нэг тал болно. Алдарт орчуулгын мэргэжилтэн Е Тинфан: “Утга зохиолын орчуулга бол аливаа орчуулга дундах бэрхшээлийн хэмжээ хамгийн их нэг зүйл мөн, учир нь утга зохиолын зохиол бүтээл бол шинжлэх ухаанч сэтгэхүйн



THE CULTURAL WAY

бүтээгдэхүүн биш, харин сэтгэлгээ ба урлагийн дагина лугаа хувь барилдлагын нэг зүйлийн гоо зүйн тоглоом мөн”²³ гэжээ.

Онтологийн онол нь хамгийн анх утга урлагийн судлалын хүрээнд орж ирсэн нь 20 дугаар зууны 40-өөд оны үе болно. Америкийн утга зохиолын онолч кино найруулагч Рэнсом: “Шинэ шүүмжлэл” гэх бүтээлдээ онтологийн онол хэмээх ухагдахууныг хэрэглэжээ. Елидт бол хамгийн анхны үүдэн дурдагч мөн. Тэр шүүмжлэлийн чадавхийг тайлбарлах, адилтгах, задлах гэж гурван талаас нь ажиглажээ. Адилтган харьцуулах нь судлагдахууны мөн чанарыг нэн гүнзгий илрүүлж, судлагдахууны шинжлэх ухаанч чанарыг улам нэмэгдүүлж чадна. Шүүмжлэлийн шүүмжлэл бол үнэлгээ болно гэж дурдаж өнгөрчээ. Шүүмжлэлийн шүүмжлэл зөвхөн харьцуулалд дулдуйдаж биелэгдэнэ. Харьцуулал байхгүй бол үнэлгээ байж чадахгүй²⁴.

Орчуулгын утга зохиол нь өөрийнхөө хөгжлийн явцад орон нутгийн утга зохиолтой нягт харьцаа холбоотой болсон байна. Нэн тэргүүнд орчуулгын утга зохиол нь гадаадын утга зохиолтой тэнцүүгүй бөгөөд тус улсын утга зохиолтой ч тэнцүүгүй, харин тэр хоёрын хоорондох утга зохиолын хэлбэр мөн. Түүнд нөлөө тусгал үзүүлэх ба хүлээн авахын хооронд харилцан нөлөөлнө. Дараа нь орчуулгын утга зохиол нь бусад соёлын мөн чанарын онцлогтой мөртөө орчуулагчийн илэрхий орон нутгийн соёлын онцлогтой байдаг. Юэ Дэйюнь: “Өнөөдрийн харьцуулсан утга зохиолын орчуулгын шинжилгээний салбар нь хэлний зөрөө лут их адил бус соёлын тогтолцоонд нүүр тулах хэрэгтэй болжээ. Утга зохиолын орчуулга бэрхшээлийн хэмжээ улмаар нэмэгдэж, орчуулгын судлал нь харьцуулсан утга зохиол судлалын салаа мөчрийн хамгийн анхаарал татах сэдэв болж ирсэн байна”²⁵ хэмээв. Монгол орчуулгын утга зохиол бол монгол хятад утга зохиолын харьцааг судлах зууч мөн, тэр нь монгол утга зохиолын онцгой мөртөө чухал нэг бүрэлдэхүүн хэсэг болсон байна. Уншигчдын сонирхож байгаа орчуулгын утга зохиол нь уг бүтээлээс тусгаарласан шинэ бүтээл байж, уг бүтээлээс үүсэлтэй, гэвч уг бүтээл биш юм. иймээс орчуулгын утга зохиол нь орчуулагчийн мэдэрдэг утга зохиолын дахин бүтээх шинж чанарыг агуулж байдаг.

Монгол орчуулгын утга зохиолын түүх бол монгол утга зохиолын солилцооны түүхийн чухал нэг бүрэлдэхүүн хэсэг мөн, хятад монгол утга зохиолын харьцааг судлах дутагдаж болшгүй цар хүрээ болно. Цаг үеийн түргэн хөгжил ба орчуулгын түвшний дээшлэлтийг дагалдан орчуулгын бүтээл ч тасралтгүй илэрч, бүх цаг үе ба бүх давхаргын уншигчдын хүсэл шаардлагыг хангасан байна.

2. Монгол орчуулгын утга зохиолын сонголт. Аливаа орчуулгын үйл

²³ 孟昭毅, 李载道主编: 《中国翻译文学史》, 北京大学出版社, 2005年, 第1页。

²⁴ 陆贵山著: 《中国当代文艺思潮》, 中国人民大学出版社, 2003年, 第34页。

²⁵ 孟昭毅, 李载道主编: 《中国翻译文学史》, 北京大学出版社, 2005年, 第19页。



THE CULTURAL WAY

ажиллагаа нь тогтсон нийгэм соёлын орчин дунд биелэгдэнэ. Нийгмийн соёл ба түүхийн ахуй байдлын орчуулгын утга зохиол дахь хязгаарлал хийгээд тохируулал нь аль эртнээс бодитой оршиж байжээ. Энэ байдлаас үзвэл, орчуулга нь нэг зүйлийн соёлын хэлбэршил бүхий улс төрийн явдал мөн. Нийгэм зүй, хүн зүй, соёл зүй үтэр түргэн хөгжиж байгаа өнөө үед орчуулгын утга зохиолын тухай ойлголт зөвхөн хэлний ба бичвэрийн хүрээ хэмжээний ойлголт дээр зогсонгуйрч болохгүй, харин нийгэм ба соёлын орчны шаардлагыг анхаарах хэрэгтэй. Орчуулгын утга зохиол нөлөөлөх нийгэм соёлын орчинд үндэстний утга зохиолын хэлбэр, соёлын сэтгэхүйн бүтэц, гоо зүйн сонголт ба хүлээн авалт, үзэл ухамсрын хэлбэр зэрэг багтана. Монгол орчуулгын утга зохиолын сонголт нь доорх мэт илэрхий хэдэн онцлогтой юм.

(1) Үндэстний утга зохиол нь хүчирхэг буурай аль ч байранд байсан ч орчуулгын утга зохиолын сонголт нь адил бус байдаг. Үндэстний утга зохиол дахь орчуулгын утга зохиол нь гол байрыг эзлэх үед орчуулгын бүтээл нь уг бүтээлд үнэнч байж, уг бүтээлийн бүтэц ба агуулгад үнэнч байж, үндэстний утга зохиолыг баялагжуулах ба хөгжүүлдэг байна.

(2) Орчуулгын утга зохиол нь орчуулагчийн хувь хүний хязгаартай үйл ажиллагаа төдий биш, үндэстний соёл сэтгэхүйн үнэ цэнийн хэлбэршил ба ёс суртахууны хэлбэршлийг илрүүлдэг. Орчуулагч ба уншигчаас орчуулгын утга зохиолыг ойлгохдоо сэтгэхүйн ойлголт нь хөндий хоосон биш, харин урт хугацааны турш бүрэлдсэн ба боловсорсон шүтлэг бишрэл хийгээд хүсэл эрмэлзэл байдаг. Орчуулагчаас танил бус ертөнцийг уншигчдын өмнө дэлгэн танилцуулж, уншигчид ч аль чадахаар хичээн ойлгож, хариу тусгал үүсгэвэл сая орчуулгын утга зохиол нь үндэстний соёл сэтгэхүйн шаардлагатай нийцэж, орчуулагч ба уншигч хоёр нь таарах цэгээ олж чадна.

(3) Бусад орны утга зохиолд авч хэлбэл, үндэстний гоо зүйн шаардлагын зөрөөнөөс болж орчуулагчийн орчуулах ба хүлээн авах нь бүр зохих сонголттой байдаг. Хэл бол соёлын нэг хэсэг, соёлын үүрэглэгч мөн. Түүний үүрэглэж байгаа соёлын мэдээлэл нь хүмүүсийг өөрийн үндэстний түүх хийгээд соёлын ахуй байдлыг хүмүүст тусган илрүүлдэг. Орчуулагч гарцаагүй ойлголт ба гоо зүйн суурин дээр адил бус сонголтын шинжтэй байх нь дамжиггүй. Утга зохиолын орчуулга бол орчуулагчаас уг бүтээлийг орчуулгын бүтээл болгон хувиргах нэг зүйлийн идэвх чанар бүхий хөдлөнгүй явц мөн. Тэр нь хоёр зүйлийн хэлний хоорондох хувирал ба хүлээн авагч улсын нийгэм ба соёлын орчуулгын утга зохиолын сонголт ба шингээн авах асуудалтай холбогдоно. Утга зохиолын орчуулга бол үнэндээ орчуулагчийн дахин бүтээлт мөн, орчуулагч өөрийн эх хэлээр бичсэн бүтээгдэхүүн мөн. Уншигч бол бичвэрийн утга агуулгын үүдэн бүтээгч мөн²⁶.

²⁶ 吴格非著：《当代文化视域下的中西比较文学研究》，外语教育研究出版社，2005年，第4页。



THE CULTURAL WAY

(4) Үзэл ухамсрын хэлбэр ба орчуулгын утга зохиолын харьцаа нь голдуу орчуулагчийн биеч үзэл ухамсраар илэрдэг. Орчуулга нь эн тэргүүнд нэг зүйлийн хэл ба солилцооны үйл ажиллагаа мөн. Орчуулга нь нэг зүйлийн нийгмийн үйлдлийн үйл ажиллагаа болсны хувьд бүлгэм нийтээр хязгаарлах чанар ба бодгаль биеийн дээд хэмжээний тусгай чанарын эсрэгцэх нэгдэл мөн. Тэр нь шинэ хэлний суурин дээр зохиолын агуулга ба хэлбэрийн дахин шинээр нэгдэх явц мөн²⁷. Орчуулгын хамгийн эцсийн байдал нь ойлголтын суурин дээр шинийг үүдгэх ба дээшлэх явдал болно²⁸. Орчуулга нь хэлний солигдлын үйл ажиллагаа төдий биш, харин үндэстэн, газар орон, цаг үе зэрэг талд холбогдох соёлын үйл ажиллагаа мөн²⁹. Орчуулагчид авч хэлбэл, бүх цаг үе, бүх зүйлийн соёлын хэлбэрийн тэдний тархин дахь тусгал нь бүр адилгүй, тэдний адил бус орчуулгыг сонгох арга бодлогыг тогтоодог.

1976-2013 он хүртэл 38 жилийн хугацаанд дундад улсын орчин үеийн утга зохиол 56 дэвтэр орчуулагдаж, 100 гаруй орчуулагч орчуулгын ажилд оролцсон байна. Орчуулагчдын орчуулсан бүтээлийн дотор ихэнх нь соёлын их хувьсгалаас өмнөх бүтээлийн дахин хэвлэл болно. “Өвөр монгол өдрийн сонин”, “Дэлхийн утга зохиол”, “Алтан түлхүүр”, “Тураг сараана”, “Хөлөн буйр” зэрэг сонин сэтгүүлд алдартай зохиолчийн нэртэй бүтээл даруй Лү Шюнь, Гуо Моруо, Мао Дунь, Ба Жинь, Лао Шө, Цао Юй, Ай Чин, Тянь Жянь, Жу Зычин, Зан Көжя, Чюй Чюбай, Бин Шинь, Шяо Чянь, Юй Дафу, Шэнь Цунвэнь, Сунь Ли, Чинь Мү, Жян Гуанцы, Дуаньмү Хунлян, Дин Лин, Чянь Жуншу, Ху Ши, Ли Дажао, Фан Жыминь, Мао Зөдун зэрэг хувьсгалчдын шүлэг зохиол нийтлэгдэж байв. Энд бид голдуу дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга шинэ эринд ихэнх нь “Өнөр цэцэг”, “Алтан түлхүүр”, “Алтан гарди” зэрэг том сэтгүүлд нийтлэгдэж, бусад “Шар мөрөн”, “Цэлгэр тал”, “Залуу зохиолч”, “Хун галуу”, “Өвөр монголын өдрийн сонин”, “Ардын мэдэл” зэрэг сонин сэтгүүлд дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын сэргэлт, өрнөл хөгжил, бууралтын бүх явц нь орчуулгын утга зохиолын судлал өргөц ба хөндөцийн талаар улам илүү тэлж, монгол орчуулгын утга зохиол судлалын агуулгыг баялагжуулсан байна.

(Хоёр) Монгол орчуулгын нөлөө тусгал

Монгол орчуулгын утга зохиол нь урт удаан хөгжлийн явцдаа хүчирхэг буурай аль ч байранд байсан ч монгол утга зохиолын бүхийл явцад уусан шамдаж, монгол утга зохиолын дутааж болшгүй бүрэлдэхүүн хэсэг болсон байна. Иймээс монгол орчуулгын утга зохиол дахь нөлөө тусгал нь олон талтай байдаг.

²⁷ 张今, 张宁著:《文学原理》, 清华大学出版社, 2005年, 第81页。

²⁸ 董明著:《翻译创造性叛逆》, 中央编译出版社, 2006年, 第34页。

²⁹ 方汉文主编:《比较文学原理》, 苏州大学出版社, 2005年, 第107页。



THE CULTURAL WAY

1. Урлагийн хэлбэр талын нөлөө тусгал. Урлагийн үйлдвэрлэл бол нийгэм болон олон нийтгэй уялдсан хувийн оюуны бүтээлч хөдөлмөр байгаа учир, энэхүү хөдөлмөрийн хувийн хэв маяг, өнгө зүс ба төрх байдлыг илрүүлэх явдлыг зөвшөөрдгөөр үл барам мөн онцгойлон шаарддаг жам ёс бий.

Гёте: “Урлагийн жинхэнэ амь бол онцгой тусгай хэрэг байдлыг эзэмшиж дүрслэхэд оршино. Үүнээс гадна, зохиолч хэрэв энгийн юманд ханавал хэн ч түүнийг дуурайж болох юм. Гэтэл онцгой тусгай зүйлийг бичээд байвал өөр бусдыг дуурайхын аргагүй. Учир нь биеэрээ түүнийг түүнийг туршиж үзсэнгүй” гэжээ. Тэрээр цааш өгүүлэхдээ: “Онцгой тусгай зүйлийг дүрслэн бичих энэхүү шатанд хүрвэл хүмүүсийн < зохион бүтээх > хэмээх ажил даруй эхэлж байгаа юмсан” гэв. Тусгай чанар бол бүтээлч чанартай нягт холбоотой. Шүлэгч тусгай чанарыг олж үзэхдээ бодгаль чанараа ч илрүүлдэг. Б.Бүрэнбэх: “Шүлэг аливаа юмыг зан чанартай болгож аливаа юманд амь нас олгодог”³⁰. Сонин сэтгүүл ба хэвлэл дарамлалаар дамжин орчуулагдсан зохиол бүтээл нь дундад улсын орчин үеийн алдартай зохиолчийн бүтээл, адил бус төрөл чиглэлийн зохиол даруй шүлэг, найруулал, туужис, мэдээллийн уран зохиол, жүжиг, утга урлагийн онол зэрэг байж, хэлбэрийн хувиар монгол үндэстний уламжлалт соёлын өв хөрөнгийг залгамжлан хөгжүүлэх ба гадаадын буюу хятад үндэстний урлагаас суралцах зэрэг хоёр талыг уялдуулж чадсан өвөрмөц бүтээлч хэв маяг бүхий шинэ урлагийн бүтээлүүд олон орчуулагдан нийтлэгджээ. Монгол шүлэг, туужис, найруулал, жүжиг зэрэг нь бүрэлдэн хөгжих явц дунд, орчуулгын утга зохиолын нөлөөг хүртсэн нь гарцаагүй юм. Орчуулагчийн ач гавьяа нь дундад улсын утга зохиолын шилдэг зүйлийг эх хэлэндээ орчуулж, бусдын шим тэжээл ба шилдэг зүйлийг шингээсэн авч, өөрийгөө төгөлдөржүүлэн баялагуулсан байна.

Монгол орчуулгын утга зохиол нь монгол утга зохиолын төрөл чиглэлээс хэлбэр бүтэц, үргэлжилсэн үг ба шүлэглэсэн хэлбэрээр бичиглэх ба үйл явдлын зохиомж бүтцийн тохируулалт зэрэг талаар нөлөө тусгал гаргасан байна. Монгол орчуулгын утга зохиол нь монгол утга зохиолын урлаг үзэл санаанд уусан шамдаж, монгол зохиолчдын зохион бүтээлтэд нөлөө тусгал үзүүлдэг нь дамжиггүй. Дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга монгол зохиолчдын зохион бүтээлтэд агуулга хэлбэр, утга сэдэвлэхүүн, зохиомж байршуулалт, үг хэл зэрэг олон талаар нөлөө тусгал үзүүлжээ. Тэд өөрсдийн онцгой арга хэлбэрээр өөр бусад үндэстний соёлыг шингээх ба хүлээн авч байв. Алдарт шүлэгч Н.Сайнцогт, Б.Бүрэнбэх, Гэрэлцогт, Ардай, Ч.Мэргэн, Батмөнх, Одсэр, Лигдэн, Аянга, Өлзийбүрэн, Н.Сундуй, Ноломсаран, Л.Чулуунбаатар нар өөрийн үндэстнийхээ түүх соёл ба утга зохиолын уламжлалаа гүн судалж гүнзгий ойлгон, сайтар залгамжилсан суурин дээр

³⁰ Б.Бүрэнбэх: “Аянгын эрэлчний тэмдэглэл”, ӨМАХХ, 1984 т 130.



THE CULTURAL WAY

орчуулгаар зохион найруулахын анхны боловсролоо болгож, өдөр ирэх бүр цагааран боловсорсон юм. Дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга нь хятад монгол үндэстний соёлын солилцоонд идэвх нөлөө үйлдэл үзүүлсэн бөгөөд өнөөгийн монгол утга зохиолын хөгжилд шинэ элементийг нэмэрлэсэн байна.

2. Утга зохиолын хэлний талын нөлөө тусгал. Орчуулга нь адил бус үндэстний хэлний хоорондох үзэл санаа соёлын солилцооны зуучийн арга хэлбэр ба солигдлын хэлбэр мөн³¹. Даруй орчуулга нь нэг төрлийн хэлний үүрэглэж бүхий мэдээллийг өөр хэлээр дахин илтгэх ажиллагаа юм. Орчуулагчийн хийж байгааг өнгөн талаас нь үзэхэд хоёр хэлний солигдлыг биелүүлж байгаа ч үнэндээ адил бус хоёр зүйлийн соёлын хоорондох орчуулга болох юм. Соёлын хоорондох орчуулга нь заавал хэлээр дамжиж биелэгдэнэ. Утга зохиол бол хэлний урлаг мөн. Иймээс утга зохиолын орчуулга нь үг хэлтэй төрөлх нягт барилдлагатай мөртөө үндэстний соёлын агуулахуун нь эчнээ далд нуугдаж, харилцан салж болшгүй харьцаатай байдаг. Үүнд үгийн соёлын утга нь тухайн үндэстний нийгэм соёлын амьдрал ахуй дахь зан үйл, сэтгэхүйн хэлбэр, үнэ цэнийн үзэл буюу ойлгогдохуун зэрэгтэй шууд харьцаатай юм.

“Хэл бол шүлгийн хөгжмийн багаж, шүлэгч бол хэлний хөгжимчин”³² юм. Хэл нь хүн төрөлхтний харьцаа ба үзэл санааны солилцооны багаж мөн, мөн ч нийгмийн хөгжлийг түлхэн ахиулах чухал хүчин зүйл болно. Үндэстэн нэг бүрийн хэл нь тусгаар оршихгүй, тэр нь бүх үндэстний нийгмийн үйлдэл дунд жич бусад үндэстний харилцаан дунд аажмаар үүсгэсэн бөгөөд хөгжсөөр ирсэн юм. Хэл бол үндэстний онцлогийн цорын ганц элемент биш юм. Монгол утга зохиолын үндэстний онцлогийн шийдвэрлэгч элемент нь монгол үндэстний ард түмний өвөрмөц зан чанар, сэтгэлгээний байдал болон амьдралын дадал заншил зэрэг дотоод сэтгэлгээний хэлбэрүүд болно. Энэ бол жинхэнэ монгол утга зохиолын өвөрмөц онцлогийг харуулдаг онц ялгавар мөн³³.

Хэв маяг гэдэг бол ер нь далд зүйрлэл, зохиогчийн утга зохиолын санаа зорилго хийгээд махбод биеийн шинж бүхий бүтцийн хооронд тэнцүү өртөгт харьцаатай байдаг³⁴. Үгсийн тольд: “Хэв маяг бол зохиогч үүдэн бүтээлт дунд илрүүлсэн урлагийн онцлог ба үүдэн бүтээх бодгаль чанарыг заана”³⁵ хэмээжээ. Зохиогчийн хэв маяг ер нь зохиол бүтээл дээр илрэх нь дамжиггүй юм. Гэвч зохиолч нэг бүрийн ангийн гарал, амьдралын туулсан зам, ааш араншин, дур сонирхол харилцан адил бус болохоор амьдралд хандах үзэл, амьдралыг таних

³¹ 郭延礼著:《中国翻译文学概论》,湖北教育出版社,1998年,第1页。

³² Б.Бүрэнбэх: “Зөн мэдрэхүй шүлэг зүй”, ӨМАХХ, 2001 т 43.

³³ Б.Гэрэлт: “Монгол үндэстний утга зохиолын үндэстний онцлог”, МСӨС, ӨМАХХ, 1992 т 398.

³⁴ (法)罗兰, 巴尔特:《写作的零度》,中国人民大学出版社,2009年,第8页。

³⁵ 《辞海》,上海辞书出版社,1977年,第1616页。



THE CULTURAL WAY

чадвар, урлагийн дадлага боловсрол харилцан ялгаатай бөгөөд өвөрмөц онцлогтой байдаг. Энэхүү өвөрмөц онцлог нь агуулга ба хэлбэр, үзэл санаа ба уран мэргэшил, сэдэвлэхүүн ба гол сэдэвт илэрч хэв маяг болон бүрэлдэнэ. Нэг зохиолчийн хэв маягтай болсон явдал нь түүний зохиол бүтээл боловсорч цагаарсны шинж тэмдэг болох юм. Утга зохиол бол хэлний урлаг болсны хувьд зохиогч ба монгол бүтээлийн хэв маяг нь голдуу хэлний илрэлийн онцлогоор мэдрэгдэж байдаг. Гэтэл ямар нэгэн зохиолч зохиолын баатрынхаа өвөрмөц зан чанарыг өрөөл бусдаас тасархай ялгагдах болтол бичихдээ тун бэрхшээлтэй адил, шүүмжлэгч ч гэсэн зохиолын хэв маяг, зохиолчийн хэв маягийг оновчтой дурдахад маш бэрх юм. Учир нь хэв маяг бол олон зүйлийн элементээс бүрэлддэг тул оноцыг нь олж үнэлэхэд онцгой анхаарах хэрэгтэй. Хэл хэллэг бол зохиогчийн өвөрмөц сэтгэлгээ ба урлагийн дадлага боловсролын биет илрэл мөн³⁶. Нэг зүйлийн хэлбэр нь даруй нэг зүйлийн үнэ цэнэ, хэлний бүтэц ба хэв маягийн хооронд ондоо нэг зүйлийн хэлбэрийн чанартай бодит ахуйн орон зай оршдог, энэ нь даруй зохион бүтээлт болно³⁷.

Нэг улсын утга зохиол нь бүрэлдэн хөгжих явц дунд гадна нөлөөг тасралтгүй хүлээж байдаг. Монгол утга зохиол нь хятад утга зохиолын нөлөөг хүртэх нь дамжиггүй. Монгол үндэстэн нь үндэстний онцлог ба хэв заншлыг хадгалж, хүн төрөлхтний түүхэнд гэрэл цацрангуй хуудсыг нэмэрлэсэн байна. Энэ явцад монгол утга зохиол нь хятад утга зохиол ба гадаад утга зохиолын нөлөө тусгалыг тасралтгүй хүртсэн бөгөөд тэдний нөлөө тусгалыг олтгойлж болшгүй зүйл юм. Хүлээн авах нь харалган бүдүүлгээр дуурайх биш, харин монгол утга зохиол нь хятад утга зохиолын шим тэжээлийг шингээн авч, өөрийгөө чийрэгжүүлж иржээ. Иймээс бид орчуулагчийн монгол утга зохиолд үзүүлсэн гавьяа зүтгэлийг гүйцэд нотлохын хамт заавал үндэстний утга зохиолын хөгжлийг анхаарч, үндэстний өөртөө итгэх сэтгэлгээг дээшлүүлж, монгол орчуулгын утга зохиол дэлхийн утга зохиолын хөгжилд үзүүлбээс зохих хувь нэмэр үзүүлбэл сая дэлхийн үндэстний эгнээнд мөр зэрэгцэн урагшилж чадна.

³⁶ Батбаяр: “А.Одсэрийн өгүүллэг туужийн тухай ажиглалт”, УЗЭШӨ, ӨМАХХ, 1985 т 257.

³⁷ (法)罗兰, 巴尔特: 《写作的零度》, 中国人民大学出版社, 2009年, 第8页。



ABSTRACT

The social, historical, political and cultural context since the new period has created conditions for the spread of modern Chinese literature. Moreover, the subjective and objective conditions of the translation cause at that time provided the possibility of the spread of modern Chinese literature, as well as the connection between national cultures, the relationship of mutual promotion, and the inevitability, which formed the inevitability of the acceptance of Mongolian translation by modern Chinese literature in the new period. Mongolian translation of modern Chinese literature made certain choices in content and form, as well as in the artistic form of Mongolian literary practice, which had a certain impact and effect on the artistic form and literary language of Mongolian literary practice.

Key words: *The new period, modern chinese literture, Mongolian translation, context*

НОМ ЗҮЙ

1. Д.Цэрэнсодном: “Монгол шүлгийн онол түүхийн зарим асуудал”, ӨМСХХХ, 1983
2. Б.Бүрэнбэх: “Аянгын эрэлчний тэмдэглэл”, ӨМАХХ, 1984
3. Батбаяр: “А.Одсэрийн өгүүлэлг туужийн тухай ажиглалт”, УЗЭШӨ, ӨМАХХ, 1985
4. Б.Гэрэлт: “Монгол үндэстний утга зохиолын үндэстний онцлог”, МСӨС, ӨМАХХ, 1992
5. Б.Бүрэнбэх: “Зөн мэдрэхүй шүлэг зүй”, ӨМАХХ, 2001
6. Т.Сайнбаяр: “Дундад улсын монгол үндэстний утга зохиолын түүх”, ӨМСХХ, 2003
7. Сарнаа: “Өнөр цэцгийн хагас зуун (1955-2005), ӨМАХХ, 2005
8. 《辞海》，上海辞书出版社, 1977
9. 郭延礼著:《中国翻译文学概论》，湖北教育出版社, 1998
10. 谢天振著:《译介学》，上海外语教育出版社, 1999
11. 廖七一:《研究范式与中国译学》，《中国翻译》，2001
12. 童庆炳:《文学理论教程》，高等教育出版社, 2002
13. 陆贵山著:《中国当代文艺思潮》，中国人民大学出版社, 2003
14. 陈惇, 孙景尧, 谢天振主编:《比较文学》，高等教育出版社, 2004
15. 洪子诚著:《中国当代文学史》，北京大学出版社, 2004
16. 陈惇, 刘象愚著:《比较文学概论》，北京师范大学出版社, 2004
17. 李伟著:《中国近代翻译史》，齐鲁书社出版发行, 2005
18. 孟昭毅, 李载道主编:《中国翻译文学史》，北京大学出版社, 2005
19. 吴格非著:《当代文化视域下的中西比较文学研究》，外语教育研究出版社, 2005
20. 张今, 张宁著:《文学原理》，清华大学出版社, 2005
21. 方汉文主编:《比较文学原理》，苏州大学出版社, 2005
22. 董明著:《翻译创造性叛逆》，中央编译出版社, 2006
23. (法) 罗兰, 巴尔特:《写作的零度》，中国人民大学出版社, 2009

**ХӨВСГӨЛ ДАЛАЙ БҮРЭНХАН УУЛЫН ХОШУУНЫ ТҮҮХЭНД ХОЛБОГДОХ
НЭГЭН БАРИМТЫН ТУХАЙ ТОВЧ ӨГҮҮЛЭХ НЬ**

*(Хөвсгөл далай Бүрэнхан уулын хошуу ба Дарьганга уулын хошууны жишээн
дээр)*

Э.Итгэл*

ХУРААНГУЙ

Хөвсгөл далай Бүрэнхан уулын хошууны түүх нь Хөвсгөл нуурын урианхай, бүр нарийвчлан үзвэл Хөвсгөл нуурын зүүн, зүүн хойд талаар нутаглах ард олны өвөг дээдэс, тэдний ахуй амьдралтай холбогдох билээ. Гэвч ХХ зууны эхэн үеийн монголын хошуу нутаг тэр дундаа Хөвсгөл нуурын урианхайн түүхэнд холбогдох судалгааны бүтээл өнөө хэр тун цөөн байсаар байна. Бид энэхүү илтгэлдээ Хөвсгөл нуурын зүүн талаар оршин байх Хөвсгөл далай Бүрэнхан уулын хошуунд хамаарах нэгэн баримтыг судлан, хэлэлцүүлэхийг зорьсон болно. Иймийн тул тухайн баримтад дурдагдсан мэдээллийг хэд хэдэн алхмаар тайлбарлан танилцуулах болно.

Түлхүүр үгс: *Хөвсгөл далай Бүрэнхан уулын хошуу, хүн ам, мал сүрэг, харьцуулал*

Монголын түүх судлал олон чиглэлээр улам өргөжин, гүнзгийрч байгаагийн дээр салбар ухаануудын огтлолцол уулзвар дээр тулгуурласан судалгаа шинжилгээ эрчимжиж байна. Үүнээс үзвэл Монголын түүх судлалын хүрээнд өнөө хэр төдий л судлаагүй буюу цаашид тусгайлан судлах шаардлагатай хавсрага ухааны нэг бол орон нутаг судлал билээ.

ХХ зууны эхэн үеийн Монголын нийгэм-эдийн засгийн талаарх судалгаа шинжилгээ, түүний дотор хүн ам зүйд холбогдох судалгаа эдүгээ хүртэл бүрэн боловсруулагдаагүй байна. Тухайлбал, Ардын хувьсгал ялсны дараахан байгуулагдсан аймаг, хошуудын түүхийн асуудлыг тал бүрээс нь судалж, түүхийн бүрхэг, зангилаа олон асуудлуудыг нарийвчлан судлах шаардлага зүй ёсоор тавигдаж болжээ.

1922 оноос Ардын Засгийн Газраас хувьсгалын нийгмийн зорилтыг хэрэгжүүлж, засаг захиргааны шинэ өөрчлөлтүүдийг хийж эхэлсэн бөгөөд энэ хүрээнд 1923-1924 онд хуучны зарим онцлог бүхий орон нутгийн

* ӨМИС-ийн докторант



THE CULTURAL WAY

байгууллагууд, шавийн тухай тусгайлсан дүрмүүдийг батлан гаргажээ. Үүний гол зорилго нь эдгээр онцлог бүхий газар орнуудыг бусад хошуу нутгийн нэгэн адил ардчилсан засаг захиргааг байгуулахад чиглэгдэж байв. Хөвсгөл нуурын урианхай нарын хувьд ч хуучин нийгмээс шинэ нийгэмд шилжин орох шилжилтийн үе тохиож байв. Энэхүү шилжилтийн үеийн түүхийг тодруулан судлахад тухайн үеийн хошуу нутгийн түүхэнд холбогдох түүхийн аливаа асуудал туйлын чухал юм.

Бид энэхүү өгүүлэлдээ Хөвсгөл далай Бүрэнхан уулын хошуу хэмээх тусгай засаг захиргааны нэгжид хамаарч байх үе буюу 1924-1925 онд холбогдох хошууны хүн ам, хөрөнгийн бүртгэлд хамаарах нэгэн баримтыг сонгон авч задлан шинжлэхийг зорьлоо.

Өнөөгийн Хөвсгөл аймгийн Ханх, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Эрдэнэбулган, Түнэл зэрэг сумдын газар нутаг нь Хөвсгөл нуурын урианхай нарын нутаглаж байсан нутаг дэвсгэр юм.

Хөвсгөл нуурын урианхайн уг гарлын тухай судалгааны бүтээлд харилцан адилгүй тэмдэглэсэн байх бөгөөд хамгийн сүүлд энэ талаар жинтэй судалгаа хийсэн ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн эрдэмтэн Б.Нацагдорж "... Хөвсгөл нуурын урианхай хошуу болон түүний хүн амын үүсэл болон уг хошуу нь хэрхэн үүсч зохион байгуулагдсан тухай судалгаа өнөө хэр дутагдаж байна"¹ хэмээн өгүүлжээ.

Чин улсын ноёрхлын үед Тагна урианхай, XIX зууны эхэн үеэс Улиастайн жанжны шууд мэдэлд байв. Богд хаант монгол улсын үед 1921-1923 онд Дотоод яамнаа шууд захирагдаж хааны санд ангийн үсээр алба барьж явжээ². "1924 онд Цэцэрлэг мандал аймгийн Хөвсгөл далай Бүрэнхан уул, Хөвсгөл далай Дэлгэрцагаан уул гэх 2 хошуу яваад 1926 онд Дэлгэрхан уулын хошуу болж улмаар 1928 онд Харуулын хошууг өөртөө нэгтгэв"³ гэжээ. 1931 онд БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 5 дугаар тогтоолоор Цэцэрлэг мандал уулын аймгийн Дэлгэрхан уулын хошуунаас байгуулагдсан, Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын нутгийн нэгэн хэсэг болсон юм.

Эдүгээ Монгол Үндэсний Төв архивын Түүхийн баримтын архивт хадгалагдан буй "Дотоод явдлын яаманд олон газраас ирсэн бичиг" хэмээх баримтууд дунд байх "Фонд-4. Данс-2. Хадгаламжийн нэгж-73" дугаартай нэгэн баримтыг онцлон танилцуулья.

Уг баримт худам монгол бичгээр "Дарьганга, Хөвсгөл далай Бүрэн хан уулын 2 хошуунаас арван тавдугаар онд мэдүүлсэн хүн ам, үл хөдлөх

¹ Б.Нацагдорж. "Хөвсгөл нуурын урианхай хошууны үүсэл. Евроазийн нүүдлийн мал аж ахуй, УБ., 2016 т 139

² Ц.Сономдагва. Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэлчлэт (1691-1997). УБ., 1998. т 318

³ Манжийн үеийн хошуу. ЭШХЭ. УБ., 2016 т 51



THE CULTURAL WAY

хөрөнгийн дансыг байцаан тодорхойлсон товч данс” гэсэн гарчигтай, муутуу цаасан /ойролцоогоор А4/ дээр тухайн хоёр хошуунд холбогдох мэдээллийг харьцуулах байдлаар хүснэгтлэн тэмдэглэжээ. Он цагийн хувьд Монгол Улсын арван тавдугаар он хэмээсэн нь 1925 он болно. Баримтыг худам монголоос кирилл үсэгт буулгасан байдлаар доор толилуулъя.

Дарьганга, Хөвсгөл далай Бүрэн хан уулын хошуудаас арван тавдугаар онд мэдүүлсэн хөдлөх хөрөнгөний дансыг байцаан тодорхойлсон товч данс.

Дотоод явдлын яаманд олон газраас ирсэн бичиг.

Дарьганга, Хөвсгөл далай Бүрэн хан уулын 2 хошуунаас арван тавдугаар онд мэдүүлсэн үл хөдлөх хөрөнгөний дансыг байцаан тодорхойлсон товч данс⁴.

	Дэс дараалсан дугаар	1	2
	Хошууны нэрс	Хөвсгөл далай Бүрэн хан уулын хошуу	Дарьганга уулын хошуу
	Өрх	720	2584
	Хүн ам	2560	13657
	Эсгий		3756
Модон голтой	2 дугуйтай тэрэг		3248
Ат	5 наснаас дээш	Х	1240
	4 наснаас доош	Х	635
Ингэ	5 наснаас дээш	Х	1909
	4 наснаас доош	16	714
	Дүн	16	4498
	Нийлсэн бодын дүн	32	5996
	Ботго	2	589
Морь Азарга	5 наснаас дээш	2257	7383
	4 наснаас доош	618	3888

⁴ Ф-4. Д-2. ХН-73



THE CULTURAL WAY

Гүү	5 наснаас дээш	1291	6791
	4 наснаас доош	641	3670
	Дүн	4807	21732
	Унага	538	3937
Шар Бух	5 наснаас дээш	995	1923
	4 наснаас доош	1109	1793
Үнээ	5 наснаас дээш	3385	3607
	4 наснаас доош	1566	2211
	Дүн	7055	9534
	Тугал	1797	1310
Хонь ямааны тоо	Хонь ямааны тоо	15476	119274
	Нийлсэн бодын тоо	2210	17039
	Хурга ишиг	5366	63460
	Бүгд бодын дүн нь	14104	57301
	Бод үл хүрэх малын тоо	6	1

Дээрх баримтад туссан мэдээллийг дараах байдлаар шинжлэн судлах боломж байгааг харуулахыг зорьсон билээ. Үүнд:

1. Хоёр хошууны тухай мэдээллийг нарийвчлан үзвэл, Дарьганга уулын хошуу, Бүрэнхан уулын хошуунаас бүх үзүүлэлтээр давамгайл байна. Тодруулбал, хүн ам, өрх, малын тоо толгой гэх мэт. Хүн амын тооны хувьд 2560 ба 13657 байгаа нь даруй Дарьганга уулын хошууны хүн амтай харьцуулахад 18.7%-тай тэнцэж байна. 1918 оны хүн амын тооллыг сөхөн үзвэл Хөвсгөлийн 4 сум урианхай нар 1100 өрх, 5000 орчим хүн ам гэж бүртгэгджээ. Тэгвэл 1924 оны байдлаар урианхайн 4 сум байсны 2 сум нь Хөвсгөл далай Бүрэнхан уулын хошууг бүрдүүлж байсан нь илэрхий байна.
2. Тус баримтад эсгий болон модон голтой хоёр дугуйтай тэрэг гэсэн бүртгэлд Хөвсгөл далай Бүрэнхан уулын хошууны тэмдэглэл байхгүй байна. Эсгий гэр, модон голтой тэрэг бол эдүгээ ч өргөн хэрэглэгдсээр байх тул тухай үед бүртгэлд тэмдэглээгүй нь хойшид анхаарал хандуулж, лавшруулан судлах асуудал юм.
3. Мал аж ахуй хувьд монгол орны бусад нутгийн адил таван хошуу малыг тоолуулсанаас бод малын бүртгэлийг нас насаар нь нарийн тэмдэглэжээ. Бог малын хувьд хонь, ямаа гэж нийтэд нь тэмдэглэжээ. Тухайн малын бүртгэлийн нийт дүнгийн доор төл малыг тусад нь бүртгэжээ. Төл



THE CULTURAL WAY

малын дүн нийт малын тоонд ороогүй байна. Бог малын нийт тоог бодод харьцуулан нийт бодын тоо 14104 байна. Үүнээс тэмээ өчүүхэн бага хувь буюу 0.2%, адуу 34%, үхэр 50%, хонь ямааны бодод харьцуулсан нь 15.7%-ийг эзэлж байна. Хонь ямааг бодод шилжүүлэлгүй бүгд малын тоог бодвол 27370 толгой болж байна. Мөн нийт төл малын тоог гаргавал 7663 болж байна. Үүнийг бүх малын тоотой харьцуулбал 28%-ийг эзэлж байгаа нь ажиглагдана.

4. Бог малыг бодод шилжүүлэхдээ ойролцоогоор 7 бог мал 1 бод малд тооцож байсан нь тодорхой байна.
5. Хөвсгөл далай Бүрэнхан уулын хошууны хамгийн олон тоог эзлэх нь бог мал (хонь, ямаа), дараа нь үхэр, адуу, тэмээ гэсэн дараалалтай байна. Тэмээний тоо толгой бага байгаа нь тэмээг маллах, хариулах газар нутгийн онцлог үүнд нөлөөлсөн болов уу. Аливаа бод малыг эр, эмээр ялгаад мөн насны хувьд 5 наснаас дээш, 4 наснаас доош гээд бог малын хувьд ерөнхийд нь тэмдэглэжээ. Хонь ямааны нийт тоо байх боловч чухам хэд нь ямаа, хонь болохыг тогтоох боломжгүй байна.
6. Өгөгдсөн мэдээлэл дээр үндэслэн нэг хүнд ноогдох малын тоо ойролцоогоор 5.5 болж байна.
7. Бас нэг анхаарал татах асуудал нь өгүүлэн буй урианхай нарын эрхлэх гол аж ахуйд ан агнуур зохих байр суурь эзэлж байсан билээ. Гэвч тус бүртгэлд үүнийг тэмдэглээгүй байгаа нь цаашид судлууштай асуудал юм.
8. Чин улс ба ХХ эхэн үеийн Хөвсгөл нуурын урианхай нарын гол эрхлэн амь зогоож байсан мэтээр тэмдэглэгддэг ч үнэн хэрэгтээ бусад монголчуудын адил таван хошуу мал сүргээ өсгөсөөр ирснийг гэрчилж байна. Ан агнуур бол алба гувчуурт түлхүү ашиглагдах буюу туслах чанартай аж ахуй байжээ.

ХХ зууны эхэн үеийн хошуу нутгуудын судалгааны материал ерөнхий тойм байдлаар дүрслэгдсээр ирсэн бөгөөд Хөвсгөл нуурын урианхай нарын түүхэнд холбогдох судалгаа ч мөн тийм байгаа нь нууц биш юм. Иймээс бид Хөвсгөл далай Бүрэнхан уулын хошууны түүхэнд холбогдох нэгэн баримтыг сонгон, тэр үеийн хүн ам, мал аж ахуйн байдлыг тодруулахыг хичээлээ. Эдүгээ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарьт өөрчлөлт орсон тухайн үеийнх нь архивын баримт материалыг нягтлан судлах шаардлага зайлшгүй тулгараад байна. Цаашлаад архивын бусад материалыг нарийн нягт шүүж, түүхэн хүн ам зүйд холбогдох асуудлыг илүү дэлгэрүүлэн хүн амын бүртгэл, нас баралт, төрөлт, өвчин эмгэг, хөдөлмөр эрхлэлт, шийтгэл зэрэг асуудлуудыг тодруулан, нарийвчлан судлах боломж байгаа нь ажиглагдаж байна.



THE CULTURAL WAY

НОМ ЗҮЙ

1. МУУГА. Ф-4. Д-2. ХН-73
 2. Ц.Сономдагва. Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэлчлэт (1691-1997). УБ., 1998
 3. Манжийн үеийн хошуу. ЭШХЭ. УБ., 2016
 4. Монгол улсын угсаатны зүй. III боть. УБ., 1996
 5. Л.Жамсран. Дарьганга. УБ., 1999
 6. О.Пүрэв. Монгол улсын түүхэн газар зүй. УБ., 2004
 7. Ц.Сономдагва. Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалт өөрчлөлт, шинэлчлэлт. (1691-2013) УБ., 2013
 8. З.Доржир. Ойрад түүхийн дурсгалууд. ШАХХ., 1992
 9. Б.Мөнх-Очир. Монгол улсын аймаг, хошуу, сумын лавлах. УБ., 2012
- Ж.Цэвээн. Дархад, хөвсгөл нуурын урианхай, дөрвөд, хотон, баяд, өөлд, захчин, торгууд, мянгад, дарьганга, хасаг, хамниган нарын гарал, үндэс байдлын өгүүлэл. УБ., 1934

**МОНГОЛ УЛСЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ,
ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

А.Мөнхцэцэг*

Ц.Түвшинбаяр♦

ХУРААНГУЙ

Монгол Улсын хэвлэл мэдээллийн хараат бус байдал түүний эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх замаар зарим орны давуу, сул тал, ялгаа онцлогийг тодруулж харьцуулан судлахыг зорьлоо. Манай улс ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжиж, шударга ёс хүний эрхийг дээдлэх болсноор 1990-ээд оноос чөлөөт хэвлэлийн үндсэн суурь тавигдсан.¹ Хэдийгээр хэвлэлийн эрх чөлөөг дээдлэн Үндсэн хуулинд үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, чөлөөтэй хэвлэн нийтлэх эрхийг баталгаажуулж, 1998 онд “Хэвлэлийн эрх чөлөөний тухай” хуулийг баталсан ч хэвлэл хөгжиж төлөвшихөд тулгадамж буй олон асуудал байна.

Түлхүүр үгс: *ОНМХ, МҮОНРТ, ИНБ, хараат бус байдал, телевиз, радио*

“Чөлөөт хэвлэлийн арван номлол”-ын 1-т зааснаар бол “Хэвлэл чөлөөтэй байх ёстой бөгөөд энэхүү эрх чөлөө нь үндсэн хууль, хэвлэлийн хуулиар хүлээн зөвшөөрөгдөх учиртай”². Түүчлэн чөлөөт хэвлэлийн онолын үүднээс авч үзвэл “Ихэнх ардчилсан улс оронд мэдээллийн хяналт зохицуулалт нь хууль эрх зүй, шүүхийн хүрээнд, мөн нийгмийн статусыг дээдэлсэн хандлагаар тодорхойлогдож байна. Түүнчлэн Үндсэн хуулийн зүйл заалт нь гол зохицуулагч эрх зүйн баримт бичиг байж, мэдээллийн хэрэгсэлийн бодлого үйл ажиллагаанд оролцох, нөлөөлөх, төр засгийн хязгаар, “хэмжээ”-г зааглаж байдаг”³.

* ДХИС, Эрх зүй, Нийгмийн ухааны сургуулийн багш, цагдаагийн дэслэгч

♦ ДХИС, Эрх зүй, Нийгмийн ухааны сургуулийн багш, цагдаагийн дэслэгч

¹ “Монголын хэвлэл мэдээллийн хараат бус байдлын судалгаа” УБ., 2019 он

² Батбаатар Ж. “Чөлөөт хэвлэлийн арван номлол”. УБ., 2010 т 16

³ Болд-Эрдэнэ.Д “Олон нийтийн харилцаа”. УБ., 2006 т 159



THE CULTURAL WAY

Хэвлэл мэдээллийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаагаа аливаа ашиг сонирхол, хөндлөнгийн нөлөөллөөс хараат бус, бие даасан байдлаар хэрэгжүүлэх нөхцөлийг хуульчлан баталгаажуулснаар иргэд Үндсэн хуульд заасан үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах эрхээ бүрэн утгаар нь хэрэгжүүлэх боломжийг хангаж байна.

Хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг хангах эрх зүйн зохицуулалт нь төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд шууд нөлөөлөхийг хориглож хязгаарлах, хэвлэл мэдээллийн салбарт тусгай зөвшөөрөл олгох, бүртгэх, агуулгын хяналт хийх байгууллагын хараат бус байдлыг хангах, олон ургалч хэвлэл мэдээллийг дэмжих, хамгаалах эрх зүйн орчныг бий болгох, сэтгүүлчид мэргэжлийн үйл ажиллагааг хөндлөнгийн дарамт шахалтгүйгээр хэрэгжүүлэх хуулийн баталгааг бий болгох, МҮОНРТ-ийн хараат бус байдлыг хангах зохицуулалтаас бүрдэх юм.

Монгол улсын үндсэн хуулиар баталгаажуулсан “Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй бөгөөд төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах” эрхийг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “хэвлэл мэдээллийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлж хариуцлагатай, мэргэшсэн сэтгүүл зүй, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлж, нийгмийн тогтвортой байдлыг хангана”⁴ хэмээн давхар баталгаажуулсан байдаг. Тухайлбал, хэвлэл мэдээллийн хараат бус байдал гэдэг бол зөвхөн салбарын асуудал биш харин ардчилал, хүний эрх, хэвлэлийн эрх чөлөө цаашлаад үндэсний аюулгүй байдлын бодлогын асуудал юм.

Манай улсад “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” (1998), “Олон нийтийн радио телевизийн тухай” (2005), “мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” Монгол улсын хууль нь манай улсын хэвлэл мэдээллийн харилцааны хэм хэмжээг зохицуулах гол хууль болж байна.” Эдгээрээс гадна Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хуулиар, тухайлбал Зар сурталчилгааны тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Төрийн болон албаны нууцын тухай зэрэг бусад хуулиар хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн агуулга, үйл ажиллагаатай холбоотой хязгаарлалтыг тогтоосон байна.

⁴ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. УБ., 2010 т 36



THE CULTURAL WAY

Үндэсний эрх зүйн зохицуулалтын зэрэгцээ Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн аливаа үүрэг хариуцлагаа шудрага сахин биелүүлэх ёстой бөгөөд олон улсын гэрээ соёрхон баталсан, нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилдэг.

Монгол Улс НҮБ-ын гишүүн орны хувьд 1946 онд баталсан “Хүний эрхийн түгээмэл тунхаглалын зарчим”-ыг хүлээн зөвшөөрч, 1974 онд Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пактад нэгдэн орсон билээ.

Дээрх хоёр баримт бичгийн 19-р зүйлд хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээллийг хилийг зааг ялгаагүйгээр аливаа арга хэрэгслээр хүлээн авах, эрж сурвалжлах эрх чөлөөтэй хэмээн заасан байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын төр засаг нь олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, дээх заасан эрхийг баталгаажуулан хамгаалах үүрэгтэй. Иймд Монгол Улс нь НҮБ-ын гишүүн орны хувьд ч, өөрийг Үндсэн хуулийн дагуу ч нэгдэн орсон “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, “Иргэний болон Улс төрийн эрхийн олон улсын Пакт”-ын 19-р зүйлд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах үүрэгтэй.

Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд төрөөс шууд нөлөөлөхийг хориглох зохицуулалтыг аваад үзье. Үүнд: Төрөөс хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс шууд нөлөөлөхийг хуулиар хориглох нэн тэргүүний зохицуулалт бол цагдан хяналтыг хориглох явдал юм. 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулиар үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан хэдий ч, үүнээс хойш даруй зургаан жилийн дараа буюу 1998 онд цагдан хяналтыг албан ёсоор хуулиар хориглосон билээ.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйлд Мэдээлэлд хяналт тавихыг хориглох

3.1. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтэрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй... хэмээн заасан байдаг.

Ардчилсан зарим орны туршлагаас үзэхэд цагдан хяналтыг хориглохын сацуу хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд төрийн зүгээс нөлөөлөхийг хуулиар хориглодог байна. Тухайлбал:



THE CULTURAL WAY


ХБНГУ	Монгол Улс
Эрүүгийн хуулиар редакцын нууцыг хамгаалах, редакцад нэгжлэг хийх замаар сэтгэл зүйн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийхийг хуулиар хориглодог.	Эрүүгийн тухай шинэчилсэн хуулийн 14.2 дугаар зүйлд Мэдээлэл хайх, хүлээн авахад саад учрууллахыг хориглосон.
<p>Үүнээс үзэхэд “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах иргэний эрхийг хэрэгжүүлэхэд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж саад учруулсан бол” ... торгох, нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэгээс зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг нь хязгаарлах шийтгэнэ гэжээ. Мөн хуулийн 14.3-т " Өөрийн, эсхүл бусдын хууль ёсны ашиг сонирхолыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, тараалгахгүй байхын тулд хэвлэн нийтлэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл төлбөр төлж зориуд нийтлүүлээгүй эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлсэн бол торгох, нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэхээр зохицуулсан байна.</p>	

Монгол Улсад 2022 оны байдлаар тогтмол үйл ажиллагаа эрхэлж буй хэвлэл мэдээллийн 10,8 хувь нь төрийн байгууллагын харьяанд байгаа бөгөөд 2010 оноос жил тутам буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал энэ үзүүлэлт 2010 онд 11%, 2016 онд 9%, 2017 онд 8.8% , 2020 онд 9.6 байна⁵. (Сонины 15%, сэтгүүлийн 12%, телевизийн 3 хувь% радиогийн 12% нь төрийн аль нэг байгууллагын мэдэлд байна.) Мөн төрийн эзэмшилд буй мэдээллийн хэрэгсэлийн тоонд зарим агентлагаас эрхлэн гаргаж буй 5 сонин, 1 сэтгүүл багтаж ббайгаа юм. Тус агентлагийн даргыг Ерөнхий сайд томилдог бөгөөд Монголыг гадаадад сурталчлах зорилгоор сонин хэвлэл эрхлэн гаргадгаараа онцлог бол төрийн бусад байгууллагаас эрхлэн гаргаж буй мэдээллийн хэрэгсэл бүгд тухайн байгууллагын бодлогыг сурталчлах зорилготойгоор ажиллаж байна гэж зарим эх сурвалжуудад бичсэн байна.

⁵ “Хэвлэлийн Хүрээлэн”. УБ., 2021



THE CULTURAL WAY



Үүнээс үзэхэд Монгол Улсад байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслийн /ХМХ/ дийлэнхийг буюу 78 хувийг хувийн компани, хувь хүн эзэмшиж байна. Ялангуяа телевизийн салбарт хувийн харьяалал давуу байна. Үйл ажиллагаа явуулж байгаа 10 телевиз тутмын 9 нь хувийн эзэмшилд байна. Харин ТББ, иргэний холбоод дэргэдээ радио ажиллуулж, сонин, сэтгүүл гаргах нь түгээмэл байгааг дээрх үзүүлэлтээс харагдаж байна.

ДҮГНЭЛТ

Манай улсад хэвлэл мэдээллийн хараат бус байдал түүний эрх зүйн орчин харьцангуй бүрдсэн байна. Хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг хангах эрх зүйн зохицуулалтууд байгаа хэдий ч бусад хууль тогтоомжоор зөрчилтэй байдал үүссэн нь шууд бус цагдан хяналтын хэлбэр рүү оруулахад хүргэж байгаа юм. Төрийн нууцын тухай, Зөрчлийн тухай хууль, Олон нийтийн радио телевизийн тухай хууль болон зарим тогтоол, журам нь сэтгүүл зүйн хараат бус байдалд тодорхой байдлаар сөргөөр нөлөөлж байна.

Дэвшүүлэх санал:

- *Хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг улс төрөөс ангид байлгах эрх зүйн орчныг сайжруулах*
- *Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэн, хөрөнгө оруулагч хөндлөнгөөс нөлөөлөхгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлэх*



THE CULTURAL WAY

ABSTRACT

Analyzing the independence of media in Mongolia and its legal regulations, we aim to clarify and compare the strengths, weaknesses, and differences of some countries. Since the 1990s, when our country has transitioned to a democratic social system, justice and human rights have been respected, the foundation of a free press has been laid. Although the Constitution guarantees the right to express opinions, speech, and free publication in respect of the freedom of the press, and the Law on Freedom of the Press was approved in 1998, there are many problems in the development of the press.

Keywords: Public media association, Mongolian National Broadcasting system, independence, Civil society organizations, Broadcasting

НОМ ЗҮЙ

1. “Монголын хэвлэл мэдээллийн хараат бус байдлын судалгаа”. УБ., 2019
2. Батбаатар Ж. “Чөлөөт хэвлэлийн арван номлол”. УБ., 2010
3. Болд-Эрдэнэ.Д “Олон нийтийн харилцаа”. УБ., 2006
4. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. УБ., 2010
5. “Хэвлэлийн Хүрээлэн”, УБ., 2021

**САЖА БАНДИДА МОНГОЛ БИЧГИЙГ ЗОХИОСОН ТУХАЙ ДОМГИЙГ
ДАХИН АВЧ ҮЗЭХ НЬ**

Б.Лхагважав*

ХУРААНГУЙ

Сажа бандида Гунгаажалцаны “Зүрхэн толт”-ын тухай судлаачид өөр өөрийн саналаа дэвшүүлж ирсэн бөгөөд энэ нь монгол бичгийг шинээр зохиож хэрэглэж болсон тухай агуулгатай сурвалж бичиг үү? эсвэл анхны хэл зүйн бичгийг тэр үед зохиосон уу? гэдэг асуултад өнөөг хүртэл бүрэн хариулаагүй байна. Энэ асуултад хариулах зорилгоор тухайн хэл зүйн бичгийн чухал хоёр үгийг сонгон авч судлалаа.

Түлхүүр үгс: *Зүрхэн толт, хэл зүйн бичиг, Гунгаажалцан, Чойжи-Одсэр*

Монгол бичгийг зохиож хэрэглэсэн цаг үеийн тухайд судлаачид өөр өөрийн саналаа дэвшүүлсээр иржээ. Энэхүү өөр өөр саналуудын нэгэн салаа, гол түлхэц нөхцөл нь болж буй нэгэн баримт нь уламжлалт хэл зүйн бичгүүд дэх Сажа бандида Гунгаажалцаны монгол үсгийг зохиосон тухай домог юм. Одоогоор олдоод буй хамгийн анхны хэл зүйн бичиг нь равжамба Данзандагвын “Зүрхэн толтын тайлбар үсгийн эндүүрлийн харанхуйг арилгагч Огторгуйн маань хэмээх оршив” гэдэг зохиол юм. Энэ зохиолд Сажа бандида Гунгаажалцаны монгол үсгийг зохиосон тухай домгийг анхлан дурдсан бөгөөд дараа дараагийн хэл зүйн бичгүүдэд хуулагдан орсон байдаг. Уг домгийн агуулгыг нийтээр мэдэх хэдий ч “Огторгуйн маань”-д буй хэсгийг дор сийрүүлье.

“... Тэр цагт Сажа бандида Монгол улсад аль үсгээр туслах болох хэмээн шөнө тугдам барьж эрт манагаар бэлгэлэхүйд нэгэн эхнэр хүн мөрөн дээрээ хэдрэг модныг барьж ирээд мөргөвөөс тэрхүү бэлгээр эр, эм, эрс гурванаар чанга хийгээд хөндий ба саармаг гурванаар зохиосон болой...” (Зүрхний толт: За)

хэмээсэн агуулга бүхий энэхүү домог нь ЕБС-ийн сурах бичиг болон ном хэвлэлүүдэд хэвлэгдэн, нийтэд нэлээн түгсэн домог юм. Энэ домгийг хэл зүйн бичгүүдэд хуулагдаж, эшлэгдэж ирснээр нь авч үзвэл аль XVIII зууны үеэс судалгааны эргэлтэд орсон гэж үзэж болно. Тус домгийг “монгол бичгийг анх

* ШУА-ийн ХЗХ-ийн ЭША, ӨМИС-ийн докторант
lhagvajav_b@mas.ac.mn lhagvajav.b_88@yahoo.com



THE CULTURAL WAY

бий болгож, шинээр үүтгэсэн тухай баримт” хэмээн нийтээр түгээмэл ойлгосон хэвээр байна. Тус домгийг хэл зүйн бичгүүдэд элдэв засвар, тайлбаргүй хуулсан байдаг тул монгол бичгийг үүсгэж, монгол хэлийг тэмдэглэж эхэлсэн цаг үеийн тухай нэгдмэл нэгэн ойлголттой байсан гэж үзэж болмоор байна.

Хэдийгээр өнөөг хүртэл тэрхүү хэвшмэл ойлголт хэвээр байгаа ч хорьдугаар зууны эхэн үеэс нааших судлаачид уг домгийн баримтад эргэлзэж, энэ тухай судалгааны бүтээл бичин хэвлүүлж, таамгаа дэвшүүлж иржээ. Энэ саналыг анхлан бичиж, нийтэд хүргэсэн хүн бол О.Жамьян гүн юм. Тэрээр монгол хэл, бичиг соёлоо түгээх үйлсэд хичээнгүйлэн зүтгэж, ном, сурах бичиг олныг зохион хэвлүүлж хүүхэд багачууд, ард нийтийг сургаж, соён гэгээрүүлж явжээ. Тэрээр 1925 онд хэвлүүлсэн “Урт өдрийн улиг үгний бичиг” хэмээх зохиолдоо дээрх домгийг дурдаад, 1204 онд Найман улсыг эзэлсний дараа уйгур үсгийг хэрэглэх болсон, 1225 оны Чингисийн чулууны бичиг хэмээх хөшөөг монгол бичгээр бичсэн гэх мэт баримтыг мөн дурдаж домогт өгүүлэн буй цаг үе (1243 он)-ээс өмнө монголчууд бичигт үсэгтэй байсан хэмээн баталжээ. “Урт өдрийн улиг үгний бичиг” зохиолын оршилд:

“Дэлхий дахины олон овгийн улс, өөр өөрийн хэлний үсгийг хэдийд хэн нэртэй хүн зохиосон явдал цөм тодорхой данс буй хэмээмүй. Манай Монгол улсад өөрийн хэлний үсэг хэрхэн дэлгэрсэн учрыг гаргасан номлол буй боловч ихэд дэлгэрсэнгүй бөгөөд, хүн бүр олж мэдэн чадаагүй ажгуу. Эдүгээ аваас манай Монгол тусгаар улс болон тогтнож эрдэм соёлыг бадруулахыг шамдан хичээж бүхүй цаг тул, сая сурах бага хөвгүүдэд өчүүхэн тус болохыг эрэн хүсээж, манай Монголд өөрийн хэлний үсэг хэрхэн дэлгэрсэн учрыг товч төдий гаргаж бичсүгэй” (Жамьян, 2014: 81)

хэмээн бичиж, дэлхий дахины бичиг үсгийн түүх, хэдийд хэн гэдэг хүн зохиосон тухай товч дурджээ. Дээрх шалтгаанаар монгол болон бусад бичиг үсгийн үүсэл гарал, түүх домгийг судлах явцдаа Сажан бандидын монгол бичиг зохиосон гэх 1243 оны харагчин туулай жилээс өмнө монголчууд монгол бичгийг хэрэглэж байсан тухай баримтуудыг анзаарч, үүгээрээ Монголын уламжлалт хэл зүйн бичгүүдэд нэгэн хэвээр хуулагдан ирсэн тус домгийн баримтад эргэлзэх болсон бололтой. О.Жамьян гүн үүнээс өмнөх зохиолууддаа энэ домгийг оруулсан нь байх ч домгийн баримтад эргэлзсэн зүйл үгүй байна. Түүний 1914 онд буюу “Урт өдрийн улиг үгний бичиг”-ээс даруй 11 жилийн өмнө хэвлүүлсэн “Монгол үсгийн аймаг. Анхан сурах хөвгүүдийн оюуны амыг нээх *Тодорхой толь* хэмээгдэх оршвой” гэдэг зохиолдоо:



THE CULTURAL WAY

“Монгол үсгийн ёсон хэмээвээс Юань улсын анхны хаан Чингис богд тэр бээр Сажийн банчин Содномцимү¹ хэмээх лам лугаа найран зохицож лам барин шашны эх олсны учирт түүний дөрөвдүгээр үеийн хаан Гүндэн² Амдау³ төвөдийн зүүн хойно ойр Шар талын Лианжу хотод суухуйн үест Сажя бандида Гунгаажалцан хэмээх ламыг залж лам барьснаар лам тэр бээр монголчуудад үсэг үгүй тул ямар дүрэмтэй үсэг болгохыг түгдэм барьж хоноод өглөө эрт бэлэг⁴ шинжилбээс нэгэн эхнэр хүн хэдрэг модон барьж ирээд мөргөснөөр бэлэглэн⁵ үсгийн дүрэм болгож а, э, и, на, нэ, ни ... эдгээр дөчин дөрвөн үсгийг зохиов” (Жамьян, 2014: 42-43)

хэмээгээд цааш нь үргэлжлүүлэн Чойжи-Одсэрийн нэмсэн үсгүүд, харь үгийг тэмдэглэхээр зохиосон үсгүүд болон эр, эм, саармаг эгшгийн тухай бичжээ. Өөрөөр хэлбэл энэ үед Сажя бандида Гунгаажалцан “монгол бичгийг анх үүсгэж зохиосон” гэсэн үзлийг хүлээн зөвшөөрч байсан бололтой.

Академич Ц.Дамдинсүрэн “Монголын уран зохиолын тойм”-ын нэгдүгээр дэвтэртээ Данзандагвын “Огторгуйн маань” зохиолоор дамжуулан Чойжи-Одсэрийн зохиосон “Зүрхний толт”-ын тоймыг тодруулжээ⁶. Тус өгүүлэлдээ Сажя бандида Гунгаажалцан монгол үсгийг шинээр зохиосон бус, зөвхөн цагаан толгой буюу үсэглэл зохиосон бололтой хэмээн бичсэн бөгөөд монгол бичгийг Уйгараас уламжлан авсан нь баримттай хэрэг хэмээн бичжээ (Дамдинсүрэн, 2017: 124).

Академич Ш.Лувсанвандан “Гунгаажалцан нь монгол үсэг зохиосон биш, харин хэдэн зуун жилийн өмнөөс монгол хэлэнд зориулан хэрэглэсээр ирсэн бэлэн уйгаржин монгол үсгийг эмхэтгэж монгол бичгийн сурах бичиг буюу үсэглэл зохиосон хэрэг биз” (Лувсанвандан, 1981: 82) хэмээн бичжээ.

¹ Жавзансодномзэмо. “Огторгуйн маань”-д бичсэнээр Чингис хаан Сажийн лам

Жавзансодномзэмод элч илгээж, лам ба өглөгийн эзний барилдлага тогтоож байжээ.

² Годан. Өгэдэй хааны хоёрдугаар хүү. Тэрээр Сажя бандида Гунгаажалцаныг монголд урин ирүүлж, улмаар анхны “Зүрхэн толт”-ыг зохиолгосон юм.

³ Амдо. Өнөөгийн БНХАУ-ын Төвөдийн Өөртөө Засах Орны нэгэн муж.

⁴ Эхэд “бэлэг” хэмээн бичжээ. “Огторгуйн маань”-д “бэлгэ” гэж буй. Зүй нь “бэлгэ тэмдэг”-ийн “бэлгэ” байх ёстой.

⁵ Эхэд “бэлэглэн” хэмээн бичжээ. “Огторгуйн маань”-д “бэлэглэн” гэж буй. “Бэлгэдэн”, “бэлгэ болгон” гэсэн утга.

⁶ Сажя бандида Гунгаажалцан, Чойжи-Одсэр, Гунгаа-Одсэр нарын бичсэн “Зүрхний толт” хэмээх хэл зүйн бичгүүд байсан тухай хойших үеийн хэл зүйн бичгүүдэд дурдсан нь байх ч өнөөг хүртэл энэ гурван сурвалжийн эх бичиг олдоогүй байна. Судлаачид эдгээрийн тухай судалгаандаа равжамба Данзандагвын “Огторгуйн маань” зохиолын голлон хэрэглэдэг юм.



THE CULTURAL WAY

Судлаач Т.Пагва “Зүрхэн тольтын тайлбар-ыг судалсан тухай гэмдэглэл” хэмээх номыг 1957 онд бичиж хэвлүүлсэн бөгөөд энэ домгийн тухайд “Сажа бандида монгол үсгийг зохиосон гэдэг нь даруй анхны хэл зүйн тухай өгүүлсэн байна гэж үзүүштэй” (Пагва, 1957: 5) хэмээн бичжээ.

Профессор Ш.Чоймаа “... Энд өгүүлсэн нь, Сажа бандида Гунгаажалцан (1182-1251) монгол үсгийг анх зохиосон бус харин тэрбээр 1243 онд 61 насан дээрээ монгол бичгийн хэлний авиа зүйн бүтээл буюу анхны Зүрхэн толт зохиосон болох нь нэгэнт тодорхой болжээ” (Чоймаа, 2017: 174) хэмээн бичжээ.

Дээрх судалгаануудаас харахад судлаачид тус домгийн “монгол үсгийг зохиов” хэмээсэн нь монгол бичгийг шинээр зохиож, монголчуудыг бичиг үсэгтэй болгосон хэрэг биш, монгол бичгийн анхны цагаан толгой, сурах бичиг, хэл зүйн дүрмийг зохиосон бололтой хэмээсэн таамгуудыг дэвшүүлжээ.

Эдүгээ бид ч мөн адил “энэ домогт монгол бичгийн анх зохиож, хэрэглэсэн тухай өгүүлсэн бус, харин монгол бичгийн хэл зүй, дүрмийг анхлан эмхэтгэсэн байна” гэсэн таамаг дэвшүүлж батлахыг оролдлоо. Ингэхдээ тус домог дахь “зохио-“ гэдэг үг ямар утга илтгэж буйг цуваа цагийн үүднээс судалж илрүүлэхийг зорилоо.

Юуны өмнө “зохио-” гэдэг үгийг бүтцээр задлан үзвэл академич Д.Төмөртоогогийн “Монгол хэлний үгийн гаралын тайлбар толь”-д “**Зохи-** [ʃoki] {<ʃoqi} ‘нийцэх’, ‘тохирох-’ || ... Энэхүү язгуур дээр -ldu, -mji, -ra, -s, -ya зэрэг дагавар залгаж, ʃoqildu- [ʃoqi-idu] ‘зохилд-’, ʃoqimji [ʃoqi-mji] ‘зохимж’, ʃoqira- [ʃoqi-ra] ‘зохир-’, ʃoqis [ʃoqi-s] ‘зохис’, ʃoqiya- [ʃoqi-ya] ‘зохио-’ гэх зэрэг үг үүсжээ” (Төмөртоого, 2018: 129) хэмээн уул үгийн утга нь “нийцэх, тохирох”-гэсэн утгатай, энэ үгээс *зохилд-*, *зохимж*, *зохир-*, *зохис*, *зохио-* гэх зэрэг үгс үүссэн гэж тайлбарлажээ. Тэгвэл судлаач Сэцэнцогтын “Монгол үгсийн язгуурын толь”-д хэрхэн ялгасныг авч үзье. “зохь-” гэдэг үйл язгуурыг “тохь”-ийн үүсмэлд үз хэмээгээд “тохь” гэдэг язгуурыг “1. тав тааламж, эв зүй: ~ алдах, ~той цаг, 2. тогтуун, төвлүүн, лавдуун хичээнгүй: ~гүй аашлах, 3. нийцэх, зохицох, таарах: энэ үг санаанд тохив, хувцас биед тохив, 4. болзож тогтох: хэлэлцэж тохих, ханш тохих (Сэцэнцогт, 1987: 1900)” гэсэн 4 утгатай хэмээн



THE CULTURAL WAY

тайлбарлажээ. Энд эхний хоёр утга нь бидний мэдэх *тохь тух* болон *тохь томоо* гэсэн нэр үг бол сүүлийн хоёр утга нь *тохирох* гэсэн үйл үгийн утгыг тайлбарласан байна. Дээрх хоёр толийн жишээнээс харахад “зохь-” гэдэг үйл үг нь “тохь” гэдэг үгтэй нэг язгуур бөгөөд “нийцэх, тохирох” гэсэн утгыг илэрхийлдэг, “зохио-” гэдэг үг нь “зохь-” гэдэг үгээс дагаврын аргаар үүссэн үг хэмээжээ. Өөрөөр хэлбэл “зохь-” гэдэг үйл язгуурт бусдаар үйлдүүлэх хэвийн “-аа” нөхцөлийг залгаж “зохио-” хэмээх үйл үндсийг үүсгэжээ.

Монгол хэлний тайлбар толиудад дээрх үгсийг хэрхэн тайлбарласныг авч үзье. Судлаач Норжингийн “Монгол хэлний толь”-д “зохиох - 1. Зүй ёсонд нийцэх буюу бодтой хэв хэмжээ, шаардлагад таарах, тохирох: *чармайвал зохино, ~ арга хэмжээ, ~ хугацаа, хоол унд ~, хувцас хунар ~, 2. холбогдох: ~ дээд газар, ~ хүмүүстэй ярилцах*” (Норжин, 2017: 2841) хэмээн тайлбарлажээ. Тэгвэл “зохиох” гэдэг үгийн тухайд, “зохиох - 1. тохиох: *хувь заяа ~, 2. хэрэг явдлыг үүсгэн хийх, төлөвлөн тогтоох: зохион байгуулах, зохион бүтээх, төлөвлөгөө ~, 3. ном бичиг ба урлагийн бүтээлийг туурвин бичих, бүтээн гаргах: үлгэр ~, зохиол ~, аялгуу ~, бичгээр ~, амаар ~; 4. учир явдлыг үнэн байдлаас гажуудуулан санаан таваар эвлүүлж ярих буюу бичих: мэхлэгчдийн зохиосон худал цуурхал, үг ~*” (Норжин, 2017: 2842) хэмээн тайлбарлажээ. Энд “зохь-” гэдэг үйл язгуурыг дээр дурдсан хоёр толийн адил “нийцэх, таарах, тохирох” гэсэн утгатай, “зохио-” гэдэг үйл язгуур нь “тохиох, үүсгэх, төлөвлөх, туурвих” гэх мэт утгатай хэмээн бичжээ. “Зохио- гэдэг үгийн анхны утгыг “тохиох” хэмээн тайлбарлаж, хувь заяа зохиох гэсэн хэвшмэл хэллэгийг жишээнд авчээ. Өөрөөр хэлбэл энэ хэллэгийг шинээр үүсгэх бус, *тохиох, [учрах, тохирох, найруулах]* гэсэн утгатай гэжээ. “Тохио-” гэдэг үгийн язгуур нь мөн л түүрүүчийн “тохь” болох тул үүнд эргэлзэх зүйл үгүй юм.

“Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”-д энэ хоёр үгийг тайлбарласан нь Норжингийн “Монгол хэлний толь”-той тун төстэй боловч аль аль үгийн анхны утгыг оруулаагүй байна. Энэ нь эдгээр хоёр үгийн утга нь “тохь” язгуураас ихэд холдож, ялангуяа “зохио-” гэдэг үгийн утга нь “шинээр буй болгох, үүсгэх” гэсэн утгыг илэрхийлэх болсонтой холбоотой болов уу.

Орчин цагийн бичгүүдэд дээрх мэт тайлбарласан бол Чин гүрний үеийн “Таван зүйлийн үсгээр хавсарсан манж үгний толь бичиг”-т “зохиол” гэдэг үгийг төвөд хэлний “bsgrigs”, хятад хэлний “編” гэдэг үгстэй зэрэгцүүлэн хадаж бичжээ. Энд буй төвөд хэлний “bsgrigs” гэдэг үгийн утгыг төвөд - монгол толь бичгээс хайвал “найруулах, жигдлэх” (Бүрнээ, 2012: 130) хэмээн бичсэн байна. Хятад хэлний “編” гэдэг үгийг хятад - монгол толь бичигт “1. гөрөх,



THE CULTURAL WAY

сүлжих; 2. хуваах, эмхлэх, жигдлэх, зохион байгуулах; 3. найруулах; 4. хийх, зохиох; 5. дуу зохиох...” (Баатар, 2007: 69) гэхчлэн хадаж бичжээ. “Зохиомуй” гэдэг үгийг төвөд хэлний “rtsom”, хятад хэлний “编纂” гэдэг үгтэй зэрэгцүүлэн хадаж бичжээ. Төвөд - монгол толь бичигт “rtsom” гэдэг үгийг “1. туурвих, найруулах, зохиох; 2. утга, уянга найруулал” (Бүрнээ, 2012: 384), хятад - монгол тольд “编纂” гэдэг үгийг “найруулах арга” (Баатар, 2007: 70) хэмээн орчуулжээ. Эдгээрээс харахад төвөд үгийн утга нь “найруулах, жигдлэх” болон “туурвих, найруулах, зохиох” гэсэн утгатай бөгөөд бидний ашигласан төвөд - монгол толь нь орчин цагийн төвөд хэлний толь биш тул орчин цагийн ямар утга илтгэж буйг мэдэж чадсангүй. Харин хятад хэлний “编” гэдэг үг нь өдгөө ч “найруулах” гэсэн утга илтгэсэн хэвээр буй. Ном хэвлэл, толь бичиг, гарын авлагуудад “голлон найруулав”, “эрхлэн найруулав” гэсэн үгийг “主编” хэмээн бичсэнийг хятад номын хавтаснаас олонтоо харж болно.

Ямартай ч дээр дурдсан жишээнүүдэд “зохь-”, “зохио-” хэмээх үгс нь “найруулах, тохируулах, нийцүүлэх, жигдлэх, эмхлэх” гэсэн утгуудыг илтгэж байсан бөгөөд одоо тэр утгаа дам илэрхийлсэн хэвээр байгааг мэдэж авлаа. Тэгвэл одоо Данзандагвын “Огторгуйн маань” хэл зүйн бичигт “зохио-” гэдэг хэд хэдэн удаа гарах бөгөөд тэдгээр нь ямар утга илтгэж байгааг тодруулж үзье.

“... Яамлах газраа хаан ахлаад, ном сонсох ба зүг суухуйд лам ахлаад, төвөдийн хэрэгт ламаас эшгүй хаан бүү зохио, хятад, монголын хэрэгт лам юм зарлиг болохыг байтугай” (Зүрхний толт: 4a)

Энэ хэсэгт “Хос ёсны сургаал”-аар төрийн засахдаа төрийн ажил хийх, хэрэг шийдэх талыг хаан мэдэж, номын ёсны талыг лам нь мэдэж, улмаар төвөдүүдийн холбоотой хэргийг хаан ганцаар шийдэхгүй, ламтай заавал зөвших, хятад болон монголын хэргийг хаан дангаар шийдэж байх тухай айлтгажээ. Энд “зохио-” гэдэг үг “шийдэх, мэдэх” гэсэн утгыг илтгэжээ.

“Эдүгээ инү Манзуширийн хувилгаан Энх-Амгалан дээд хаан тэрээр “Цахарын хутагт хааны үед орчуулсан монгол Ганжуурыг ариутган шүү хэмээн” зарлиг болсон ёсоор сайтар шүүж хэв байгуулаад Монгол улсад эртнээс эс болсон номын өглөгийн дээд болгон зохиов” (Зүрхний толт: 5b)

“Тэндээс дөтгөөр дэлхий дахины их эзэн Найралт төв дээд хаан тэрээр Гүн дэн бо шан гон за да гү ши бус нэр Жанжаа хутагт дээд богд түүний бум



THE CULTURAL WAY

зарлигийг монгол хэлээр орчуулж, хэв байгуулаад Монгол улсад судар тарнисын дээд увдисыг үзэхүй гагц нүдэн мэт болгон зохиовой” (Зүрхний толт: 5b)

Энэ хэсгүүдэд “зохио-” гэдэг үйл үг өөрийн үндсэн утгаар бус, туслах үйл үгийн утгаар оржээ. Эхний хэсэгт Энх-Амгалан хааны зарлигаар “монгол Ганжуурыг засан нягталж, хэв байгуулаад (бар сийлүүлж) өмнө үед монгол хэлээр ном орчуулж, монгол хэлээр урьж, уншиж чадаагүй байсныг гүйцээж, монгол улсад номын өглөгийн дээд болгов” гэсэн утгыг илтгэжээ. Хоёр дахь хэсэгт “Жанжаа хутагтын зохиол бүтээлийн эмхэтгэлийг монгол хэлд орчуулан хэвлүүлж, судар тарнисын дээд увдисын тухай уншиж мэдэх гол гарын авлага болгов” гэсэн утгыг илтгэжээ.

Гурван үсгийг зассан ёсон: “а-гаас о, у хоёр, э-гээс ө, ү хоёр, на-гаас но, ну хоёр, нэ-гээс нө, нү хоёр... бөгөөд чанга арван дөрвөн хийгээд хөндий арван дөрвөнөөс хошоод хошоод хувилгаж тавин зургаан үсгийг зохиовой” (Зүрхний толт: 8b)

Энэ хэсэгт бандида Чойжи-Одсэр өмнөх үеийн хэл зүйн бичиг болох Сажа бандида Гунгаажалцаны “Зүрхний толт” дахь 44 үсгийг нэмэн дэлгэрүүлж, 100 үсэг болгосон тухай өгүүлжээ. Сажа бандида Гунгаажалцан юуны учир “Зүрхний толт”-оо 44 үсэгтэй бичсэн тухай судлаачид саналаа дэвшүүлсээр иржээ. Бидний саналаар Гунгаажалцан хэл зүйн бичигтээ 14 үсгийг эр, эм, эрс эгшгүүдээс төлөөлөл болгон “а, э, и” гурван эгшгийг сонгож, үлдсэн уруулын дөрвөн эгшгийг тус тусын зохицлоор нь дагаж бичих үлгэр болгон бичсэн бололтой. Ингэж үзвэл Чойжи-Одсэр үүн дээр уруулын эгшгийн бичих хувилбарыг нэмж оруулсан бололтой. Учир нь гийгүүлэгч үсгүүдийг эгшгээр хувилгахад ихэнх гийгүүлэгч үсгүүд нэг ижил дүрстэй байдаг ч “бо, бу, бө, бү”, “хө, хү”, “гө, гү” үеийг монгол бичгээр бичихдээ тус гийгүүлэгчүүдийг нуманд гэдсийг оруулж бичих гэх мэт өвөрмөц дүрстэй болдог тул тийнхүү үе үсэг тус бүрийг дэлгэрэнгүй оруулсан болов уу. Мөн эдгээр хэл зүйн бичгүүд нь тухайн цагийнхаа монгол бичиг сурах гол гарын авлага болж байсныг санах хэрэгтэй.

Дээрх жишээнүүдээс “зохио-” хэмээх үг нь “найруулах, тохируулах, эмхлэх” мөн “шийдэх, мэдэх” гэсэн утга илтгэж байсан гэж үзвэл бидний анх жишээ татсан

“Тэр цагт Сажа бандида Монгол улсад аль үсгээр туслах болох хэмээн шөнө тугдам барьж эрт манагаар бэлгэлэхүйд нэгэн эхнэр хүн мөрөн дээрээ хэдрэг модыг барьж ирээд мөргөвөөс тэрхүү бэлгээр Монгол улсын үсгийг хэдрэгийн дүрсээр нь эр, эм, эрс



THE CULTURAL WAY

гурваар чанга хийгээд хөндий ба саармаг гурваар зохиосон болой”
(Зүрхний толт: 3а)

энэ хэсэгт буй “зохиосон” гэдэг үгийг “найруулсан, эмхэлсэн, жигдэлсэн” хэмээх утгаар ухвал монгол бичгийн хэл зүйн бичиг “Зүрхний толт”-доо “эр, эм, саармаг буюу чанга, хөндий, саармаг” гурван зүйл эгшгээр уйгурын 14 үсгийг хувилгаж, цааш бусад (уруулын) эгшгээр хувилгаж бичих загвар болгон бичсэн гэж үзэж болно. Мөн хэл зүйн бичгүүдэд энэ домгийг засваргүйгээр хуулж оруулахдаа “зохио-” гэдэг үгийн утгыг “найруулах, эмхлэх, жигдлэх” болон “шийдэх, мэдэх” хэмээсэн утгаар ухаж байсан ч байж болно. Ингэж үзсэнээр өгүүллийн эхэнд дурдсан “монгол бичгийг үүсгэж, монгол хэлийг тэмдэглэж эхэлсэн цаг үеийн тухай нэгдмэл нэгэн ойлголттой байсан” хэмээн дүгнэснээ үгүйсгэхгүй юм. Энэ нэгдмэл ойлголт задарч, домгийн баримтад эргэлзэх болсон нь “зохио-” гэдэг үг “шинээр үүсгэх, бий болгох” гэсэн утга илтгэх болсон цаг үеэс эхэлсэн бололтой. Өөрөөр хэлбэл ХХ зууны эхэн гэхэд “зохио-” гэдэг үг “шинээр үүсгэх, бий болгох” гэсэн утга илтгэж эхэлсэн байжээ гэж үзэж болно.

“Зохио-” гэдэг үг нь өнөөгийн бидний ойлгодог “шинээр үүсгэх, бий болгох” гэдэг утгаас өөр утга илтгэж байсан юм бол тухайн цагт (дундад зууны үед) ямар үгээр энэ утгыг илтгэж байсан юм бэ? хэмээх асуулт аяндаа урган гарна. Энэ тухай баримт “Данзандагвын *Огторгуйн маань*-д байна” хэмээн үзэж болмоор байна.

“Тэндээс өдий төдий болсны хойно Хаан Пагва ламд зарлиг болруун. Энэтхэг, Хятад улсад өөр өөрийн үсэг буй бөгөөд манай Монгол улсад үсэг үгүйн тул чи үсэг гаргагтун хэмээн зарлиг болсон ёсоор Пагва лам Монголын Дөрвөлжин үсэг гаргаж монголын билигтэй хөвгүүдийг цуглуулаад сургаал хийвэй”
(Зүрхний толт: 4b)

Энэ хэсэгт Хубилай хаан Пагва ламд “Монгол улсад хэрэглэх өөрийн гэсэн бичиг зохио” хэмээн зарлиг буулгаж, Пагва лам тус зарлигийн дагуу “Дөрвөлжин үсэг”-ийг зохиож, монголын хүүхдүүдэд сургасан тухай өгүүлжээ. Дөрвөлжин үсгийг монголчууд өмнө хэрэглэж байгаагүй, Пагва лам 1269 онд төвөд үсгээс санаа авч зохиосон гэдгийг бид бүгд мэднэ. Жишээлж авсан энэхүү хэсэгт өнөөгийн бидний “шинээр үүсгэх, бий болгох” гэсэн утгыг “гарга-” гэдэг үйл үгээр илтгэжээ. “Гарга-” гэдэг үгийг толь бичгээс магадлалал, Норжингийн “Монгол хэлний толь”-д “1. Дотроос гадагш шилжих: гэрээс ~, эмнэлгээс ~; 2. Далд байсан зүйл илрэх: нар ~, цус ~, ус ~; 3. Үгүй байсан юм үүсэж буй болох, ургах, төрөх, үйл үүсэх: гал ~, шүд ~, хүүхэд ~, хэрэг ~, үнэр ~, сураг чимээ ~...”



THE CULTURAL WAY

гэхчлэн тайлбарласан бол “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”-д “1. Дотор, далд байсан юм гадагш шилжин байрлах, ил болох: гадаа гарах, ... 2. Төрөх: ихэр хурга гарах; 3. Зайлах, салж ангижрах, хагацах: ажлаас гарах, гараас гарах... 4. Юмны үүсэн бий болох: гарз гарах, дайн гарах...” гэх мэтээр тайлбарлажээ. Мөн энэ үгийг “Таван зүйлийн үсгээр хавсарсан манж үгний толь бичиг”, “Мукаддиммат-Ал-адаб”, “Хорин нэгт тайлбар толь”, “Хорин наймт тайлбар толь” зэрэг хуучны толь бичгүүдээс шүүсэн боловч “гадагш гарах”, “далд байсан зүйл илрэх” гэсэн утгуудаас өөр утга олсонгүй. Эдгээрээс үзэхэд “гарга-” хэмээх үйл үг нь “үүсэх, бий болох” гэсэн утгатай хэдий ч энэ нь анхнаасаа нэгдүгээр утга нь байгаагүй эсвэл “үүсэх” гэсэн утга нь нэлээн эртнээс явцуурсан байж магадгүй. Энэ тухай цаашид дэлгэрүүлэн судлах шаардлагатай байна.



THE CULTURAL WAY

НОМ ЗҮЙ

1. О.Жамьян. *Монгол хэл бичгийн ухаан*. Эмхэтгэн хэвлүүлсэн доктор Э.Пүрэвжав. Улаанбаатар., 2014. Адмон принт.
2. Данзандагва. *Зүрхний толт судар оривой*. Бүтэн нэр нь “Богд Чойжи-Одсэрийн зохиосон Зүрхний толтын тайлбар үсгийн эндүүрлийн харангусыг арилгагч огторгуйн маань”. Бээжин модон барын эх.
3. Ц.Дамдинсүрэн. *Монголын уран зохиолын тойм*. Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган. 6 дугаар боть, Улаанбаатар., 2017. Соёмбо принтинг.
4. Ш.Лувсанвандан. *Монгол хэл шинжлэлийн асуудлууд*. Улаанбаатар., 1981.
5. Т.Пагва. *Зүрхэн толтын тайлбарыг судалсан тухай тэмдэглэл*. Улаанбаатар., 1957.
6. Ш.Чоймаа. *Монгол хэл, бичиг, соёл судлал*. Профессорын эрдмийн өв цуврал. II боть, Улаанбаатар., 2017. Соёмбо принтинг.
7. Сэцэнцогт. *Монгол үгсийн язгуурын толь*. Жанчхүү., 1988. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо.
8. *Хааны бичсэн таван зүйлийн үсгээр хавсарсан манж үгний толь бичиг*. Бээжин., 1957. Үндэстний хэвлэлийн хороо.
9. Д.Баатар. *Хятад монгол толь* (гуравдугаар хэвлэл). Бээжин., 2007. Үндэстний хэвлэлийн хороо.
10. Д.Төмөртоогоо. *Монгол хэлний үгийн гаралын тайлбар толь*. Улаанбаатар., 2018 Адмон принт.
11. Д.Бүрнээ, Д.Энхтөр. *Төвд - Монгол толь*. Улаанбаатар, 2012.



**ХЯТАНЧУУД УМАРД ЦЭРГИЙН ЯВДЛЫН ХҮРЭЭЛЭНГ БАЙГУУЛСАН БА ДИЕЛА
ОВОГ ХУВААГДСАН ЗЭРЭГ ҮЙЛ ЯВДЛЫН ХАМААРЛЫГ ТОВЧ ӨГҮҮЛЭХ НЬ**

И Бо Рань♦

ХУРААНГУЙ

Ляо гүрний тайзу Елю Абаожи диела овгийн хүчирхэг цэргийн хүчний тусламжтайгаар хятаны хаан болсон ч диела овгийн байдал нь түүнийг хаан ширээнд суусны дараа ч эзэн хааны хүчийг тогтворжуулахад саад болсоор байв. Түүний дүү Лагө болон бусад хүмүүс диела овгийн цэргийн хүчний тусламжтайгаар Абаожи-ийн засаглалыг байнга эсэргүүцэж байв. Хүчирхэгжүүлэх, хяналт тавих хэцүү байдал тулгарахад хятан улсын дээд давхарга асуудлыг хойд ба өмнөд гэсэн хоёр танхимд хуваан шийдэхээр болжээ. Гэсэн хэдий ч хариу арга хэмжээ авсны дараа диела овог нь хятан дахь гол овог хэвээр байсан бөгөөд улс дахь төрийн томоохон үйл явдлуудад нөлөөлж эсвэл шууд хөндлөнгөөс оролцох боломжтой хэвээр байв. Иймээс диела овгийн байдал хятаны эзэнт гүрэнд заналхийлж буй асуудлыг бүрэн шийдэж чадаагүй юм. Шизу Елю Руан хаан ширээнд суусны дараа умард болон өмнөд зөвлөлийн цэргийн хүчийг хянах зорилгоор умард цэргийн явдлын хүрээлэн байгуулагдаж, хятаны эзэнт гүрний эрх мэдэлд учирч байсан диела овгийн зөрчил үндсэндээ намжсан юм.

Түлхүүр үгс: *Абаожи, Диела овог, Елю Руан, цэргийн явдлын хүрээлэн*

Өгүүллийн бүтэц:

- *Хураангуй*
- *Диела овгийн байдал*
- *Диела овгийн зөрчил*
- *Хятаны умард цэргийн явдлын хүрээлэн*
- *Дүгнэлт*

♦ ӨМИС, Монгол Судлалын Дээд Сургуулийн магистрант



THE CULTURAL WAY

浅析契丹设立北枢密院与析分迭刺部之关系

益博燃

摘要：辽太祖耶律阿保机虽然借助迭刺部的强大军事力量成为契丹皇帝，但是迭刺部强大的实力同样成为阿保机即位以后稳固皇权的障碍。其弟刺葛等人便是借助迭刺部的军事力量不断挑战阿保机的统治。契丹上层面临迭刺部强大难制的问题选择的办法是将其析分为南北两院。然而析分以后的迭刺部仍是契丹内部的主体部族，依然可以影响或者直接干涉契丹内部的重重大政治事件。因此析分初期并未彻底解决迭刺部威胁契丹皇权的问题。直至世宗耶律阮即位以后，通过设制北枢密院来节制南北两院的兵权，才基本消除迭刺部对于契丹皇权的危害。

关键词：阿保机；迭刺部；耶律阮；枢密院

迭刺部是契丹内部的主体部族。由于迭刺部的首领曾经帮助遥辇氏可汗重新构建契丹部落联盟有功，因此事后得以保留迭刺部的完整性。又因联盟最高统治机关设于迭刺部，使迭刺部首领拥有左右契丹政局的强大实力与超然地位。这种权利与地位是其他部族的首领所无法比拟的，亦是造成迭刺部终遥辇一世难制的根本原因。伴随着遥辇氏政衰，阿保机以迭刺部强大军事力量为基础，最终夺得契丹联盟的可汗之位，使得契丹汗位从遥辇氏家族转移到世里氏家族。

阿保机成为契丹可汗以后，同样需要直面迭刺部强大难制的问题，对此契丹贵族给出的建议是“析分迭刺部”。此举固然是可以在一定程度上消除迭刺部对于契丹皇权的威胁，亦有利于阿保机政权的稳固。但是通过考察发现，析分迭刺部实际上并不能完全达到稳固皇权的预期结果，此举仍然存在很多隐患。学界通常只注意到析分迭刺部对于稳固皇权所带来的积极影响，却是极少关注析分迭刺部以后仍然存在的弊端及其解决方法。本文就在前人研究的基础上稍作补充，并且着重考察析分迭刺部以后仍然存在的隐患及后代君主的解决办法。该问题的探索将有利于我们更好的了解契丹的政权机构。

一、析分迭刺部之决议

耶律阿保机虽然借助迭刺部强大的军事力量成为契丹联盟可汗，但是强大的迭刺部同样成为阿保机即位以后稳固皇权的巨大障碍。其弟刺葛等人不断的纠结迭刺部的贵族成员挑战阿保机的统治。而此空前的内战终将造成契丹“民间昔有万马，今皆徒步，有国以来所未尝有”的严重后果¹。面临迭刺部贵族接连叛乱的危害，契丹统治阶层则一致认为只有将其析分才是解决问题的最根据《辽史·耶律辖底传》记载：

¹【元】脱脱等著，刘浦江等校：《辽史》卷一《太祖本纪上》，中华书局修订本，2017年，第10页。



THE CULTURAL WAY

“将刑，太祖谓曰：‘叔父当死，朕不敢赦。事有便国者，宜悉言之。’

辖底曰：‘迭刺部人众势强，故多为乱，宜分为二，以弱其势。’²

根据《辽史·耶律曷鲁传》记载：

“初，曷鲁病革，太祖临视，问所欲言。

曷鲁曰：‘惟析迭刺部议未决，愿亟行之。’³

耶律曷鲁是太祖阿保机的左膀右臂，最终官至大于越，极尽显贵。耶律辖底则是随同刺葛等人叛乱的逆臣，最终被阿保机处死。立场不同的两人却在迭刺部强大难制的问题上有着统一的想法。因此可以认为，上述两人的观点能代表契丹贵族绝大部分人的看法。迭刺部终遥辇一世强大难制的问题却在阿保机上位以后集中爆发。于是待到条件成熟，耶律阿保机将迭刺部析分为南北两院。

根据《辽史·太祖本纪上》记载：

“天赞初，分迭刺部为二院，斜涅赤为北院夷离堇，绾思为南院夷离堇。”⁴

根据《辽史·营卫志》记载：

“天赞元年，以强大难制，析五石烈为五院，六爪为六院，各置夷离堇。”⁵

五院即是北院，六院即是南院。耶律阿保机析分迭刺部的同时“以皇子尧骨为天下兵马大元帅”⁶，设于南北两院之上，并且两院夷离堇皆由皇帝任命。史料评价，太祖此举有“英雄之智”⁷。客观来讲，析分迭刺部确实可以在一定程度上获得分其权、弱其势的预期结果⁸。然而此举并不能完全消除迭刺部于契丹皇权的消极危害。因为迭刺部虽被析分为南北两院，但其仍为契丹的主体部族，他们的意见往往能决定契丹政治的走向。不论是从太宗耶律德光继位或是从世宗耶律阮继位事件中都能看到南北两院夷离堇干涉皇位继承问题所带来的负面影响。因此在析分迭刺部的初期阶段，并没有完全解决迭刺部威胁皇权的问题。

二、析分迭刺部之隐患

² 《辽史》卷一百一十二《耶律辖底传》，第1649页。

³ 《辽史》卷七十三《耶律曷鲁传》，第1348页。

⁴ 《辽史》卷一《太祖本纪上》，第20页。

⁵ 《辽史》卷三十三《营卫志下》，第436页。

⁶ 《辽史》卷三《太宗本纪上》，第29页。

⁷ 《辽史》卷四十五《百官志一》，第800页。

⁸ 何天明：《迭刺部与北南大王院》，《辽代政权机构史稿》，内蒙古大学出版社，2004年，第145页。



THE CULTURAL WAY

析分迭刺部为南北两院，各置夷离堇，并且两院夷离堇皆由皇帝任命。看似其势遭到削弱，无法继续对皇权形成危害，实则是在皇帝在世为前期条件。若是皇帝在世，南北两院夷离堇服从皇帝的意志。若是皇帝离世，南北两院夷离堇会根据自己的意志决定某些大事的走向。接下来从太宗耶律德光继位事件以及世宗耶律阮继位事件中考察析分迭刺部为南北两院以后出现的相关问题。

根据《辽史·耶律安团传》记载：

“太祖崩，淳钦皇后称制，欲以大元帅嗣位。

迭里建言：‘帝位宜先嫡长，今东丹王赴朝，当立。’由时忤旨。

以党附东丹王，诏下狱，讯鞠，加以炮烙。不伏，杀之，籍其家。”⁹

天显元年（926），太祖阿保机病逝于扶余城。契丹内部逐渐以长子耶律倍及次子耶律德光为核心展开皇位争斗。就在此时南院夷离堇耶律迭里公然表态支持皇太子耶律倍继承皇位，惹恼淳钦皇后，最终落得个身死监狱的下场。然而纵观史料记载，北院夷离堇斜涅赤从始至终未在皇位继承人的事情上发表过言论。

根据《辽史·耶律斜涅赤传》记载：

“天赞初，分迭刺部为北、南院，斜涅赤为北院夷离堇。侄颇德。”¹⁰

根据《辽史·耶律颇德传》记载：

“天显初，为左皮室详稳，典宿卫，迁南院夷离堇，治有声。”¹¹

分析上述史料记载，太祖阿保机分迭刺部为南北两院开始，耶律斜涅赤就是北院夷离堇。直至太宗耶律德光即位耶律斜涅赤仍为北院夷离堇。值得注意的是南院夷离堇耶律迭里被淳钦皇后下令处死以后，接替南院夷离堇职位的人竟然是北院夷离堇斜涅赤之侄耶律颇德。很显然，值此皇位斗争的关键时刻斜涅赤同样无法置身事外。北院夷离堇斜涅赤没有像南院夷离堇迭里那般公然表态，并非他置身事外，而是因为斜涅赤早就站在淳钦皇后的阵营，成为其坚定支持者，因此深得当局倚重信任。北院夷离堇斜涅赤就这样成为太宗耶律德光的支持者。

南院夷离堇迭里与北院夷离堇斜涅赤因皇位继承人的问题走向对立面，契丹最强的两股军事力量有可能再度爆发军事冲突。面临此种情况，淳钦皇后果断的采取措施，诛杀南院夷离堇迭里及其下辖的属官。可以发现，契丹两大主体部族首脑在此种重大政治问题上意见相左，其

⁹ 《辽史》卷七十七《耶律安团传》，第1390页。

¹⁰ 《辽史》卷七十三《耶律斜涅赤传》，第1350页。

¹¹ 《辽史》卷七十三《耶律颇德传》，第1351页。



THE CULTURAL WAY

造成的危害无疑是巨大的。

耶律德光继位以后“册皇弟李胡为寿昌皇太子，兼天下兵马大元帅”¹²。此举符合北方民族皇帝生前指定继承人，再由贵族会议共同推举上位的传统。很显然李胡就是太宗生前指定的皇位继承人。因此正常的情况是太宗皇帝去世以后根据契丹的传统推举李胡继承皇位才是，结果却是因为不符合南北两院夷离董的利益最终使得法定继承人李胡与契丹皇位失之交臂。

根据《辽史·耶律吼传》记载：

“及帝崩于栾城，无遗诏，军中忧惧不知所为，吼诣北院大王耶律注

议曰：‘天位不可一日旷。若请于太后，则必属李胡。李胡残暴，讷能子民。

必欲厌人望，则当立永康王。’注然之。

会耶律安圜来，意与吼合，遂定议立用康王，是为世宗。”¹³

根据《辽史·耶律注传》记载：

“太宗崩于栾城，南方州郡多叛，士马困乏，军中不知所为。

注与耶律吼定策立世宗，乃令诸将曰：‘大行上宾，神器无主，

永康王人皇王之嫡长，天人所属，当立，有不从者，以军法从事。’”¹⁴

根据《辽史·耶律安圜传》记载：

“太宗伐晋还，至栾城崩，诸将欲立世宗，以李胡及寿安王在朝，犹豫未决。

时安圜值宿卫，世宗密召问计。安圜曰：‘大王聪安宽恕，人皇王之嫡长，

先帝虽有寿安，天下属意多在大王。今若不断，后悔无及。’

会有自京师来者，安圜诈以李胡死传报军中，皆以为信。

于是安圜诣北南二大王计之。

¹² 《辽史》卷三《太宗本纪上》，第33页。

¹³ 《辽史》卷七十七《耶律吼传》，第1389页。

¹⁴ 《辽史》卷七十七《耶律注传》，第1392页。



THE CULTURAL WAY

北院大王洼闻而遽起曰：‘吾二人方议此事。先帝尝欲以永康王为储贰，

今日之事，有我辈在，孰敢不从。但恐不白太后而立，为国家启患。’

安团对曰：‘大王既知先帝欲以永康王为储副，况永康王贤明，人心乐附。

今天下甫定，稍缓则大事去矣。若白太后。必立李胡。

且李胡残暴，行路共知，果嗣位，如社稷何？’

南院大王吼曰：‘此言是也。吾计决矣。’乃整军，

召诸将奉世宗即位于太宗柩前。”¹⁵

世宗虽然有自己的直属武装“永康王军”¹⁶，但是若无契丹最强两大军事集团首脑支持世宗继位，只靠耶律安搏是根本无法压服其他部族军队的。因此世宗能夺得皇位，关键在于南北两院夷离堇的共同支持，否则根本无法问鼎大位。

根据史料记载分析，诸将清楚李胡才是合法的继承人，若是就皇位继承人的问题向淳钦皇后做请示，那么她肯定要支持李胡而不是世宗耶律阮。世宗耶律阮能获得诸将支持从而夺得皇位，说明其本身是具备着继承皇位的合法性，不然就无法获得诸将的支持。然而世宗的皇位继承资格显然是要略逊于李胡，这不仅是因为太宗生前指定其为契丹皇位的继承者，更是因为契丹传统的“长宜先”原则决定李胡就是要比世宗耶律阮更具优先权。南北两院夷离堇就是因为清楚契丹的传统及制度，因此在面对是否要支持世宗继位的问题上“犹豫未决”。

太宗出兵伐晋，最后病逝于栾城。掌握契丹最强两大军事集团的首脑并不想遵从太宗欲使李胡成为契丹皇位继承人的安排。而南北两院夷离堇敢于公然违背太宗生前的安排，主要是因为太宗突然病逝，而且南北两院的夷离堇皆统兵在外又远离契丹本土，此刻的淳钦皇后已经无法再制约两大军事集团首脑。并且南北两院夷离堇皆认为“李胡残暴，讷能子民，而永康王贤明，人心乐附”¹⁷，为契丹江山社稷考虑不得不违背太宗欲使李胡嗣位的安排，拥立世宗耶律阮上位。

耶律安搏为使永康王获得南北两院夷离堇以及其他部族的支持“诈以李胡死传报军中”¹⁸。接着找南北两院夷离堇商量，欲借南北两院部族军队裹挟其他部族首脑支持世宗耶律阮继位。

¹⁵ 《辽史》卷七十七《耶律安团传》，第1390—1391页。

¹⁶ 《辽史》卷三十五《兵卫志中》，第465页。

¹⁷ 《辽史》卷七十七《耶律吼传》，第1389页。

¹⁸ 《辽史》卷七十七《耶律安团传》，第1390页。



THE CULTURAL WAY

两院夷离堇更是放豪言“今日之事，有我辈在，孰敢不从”¹⁹，甚至威胁军中诸将“有不从者，军法从事”²⁰。就这样世宗耶律阮获得作战大军的支持，成功夺得皇位。世宗此举险些引得契丹内部兵戈再起。

淳钦皇后获得消息后“遣皇子李胡以兵逆击”²¹，双方相拒于潢河横渡。最终双方在耶律屋质的劝说下“各罢兵，趋上京”²²。世宗耶律阮在南北两院夷离堇的支持下发动军事政变夺得皇位是为“擅立”，然而契丹皇帝的产生除了自身的实力强大以外，还须得通过贵族会议来确认其继位的合法性。因此交战双方在潢河的横渡举行的会谈就是变相的“贵族会议”²³。世宗耶律阮通过横渡会谈为既成事实披上一层合法的外衣。耶律屋质为了避免契丹内部战乱再起，果断的站在世宗的阵营，最终帮世宗耶律阮获得了淳钦皇后的支持，承认其皇位继承的合法性。

通过上述分析可以发现，南北两院的夷离堇清楚李胡才是法定第一继承人的情况下毅然决定支持世宗耶律阮继承皇位。因此契丹最强两大军事集团首脑意见相同的时候可能就有能力无视或者推翻皇帝生前做出的决定。析分迭剌部为南北两院虽然使其实力有所削弱，但是南北两院仍然可以威胁皇权。世宗通过两院的支持夺得皇位，因此同样看到了南北两院夷离堇实力过于强大造成的危害。

三、契丹设立北枢密院

世宗耶律阮虽然通过南北两院夷离堇的支持才夺得契丹皇位，但是同样在此过程中见识到南北两院夷离堇权力过大引发的危害。南北两院夷离堇能裹挟其他部族的军队向其听命，从而直接无视太宗生前关于皇位继承人的安排。世宗虽然得益于两院的鼎力支持，但是同样对于两院夷离堇产生了忌惮。于是世宗耶律阮即位以后便着手设置枢密院，欲借此节制契丹的部族军队。

根据《辽史·百官志一》记载：

“契丹北枢密院，掌兵机、武铨、群牧之政，凡契丹军马皆属焉。”²⁴

根据《辽史·世宗本纪》记载：

“大同元年，八月癸未，始置北枢密院使，以安搏为之。”²⁵

枢密院并不是契丹原有的部族制度，而是通过学习中原制度并加以改造使其有契丹民族

¹⁹ 《辽史》卷七十七《耶律安团传》，第1390页。

²⁰ 《辽史》卷七十七《耶律洼传》，第1392页。

²¹ 《辽史》卷七十七《耶律屋质传》，第1385页。

²² 《辽史》卷五《世宗本纪》，第72页。

²³ 陈述：《契丹政治史稿》，人民出版社，1986年，第75页。

²⁴ 《辽史》卷四十五《百官志一》，第774页。

²⁵ 《辽史》卷五《世宗本纪》，第72页。



THE CULTURAL WAY

的特色。有学者认为，设立枢密院的目的在于集权，是为了削弱南北两府宰相的权力²⁶。笔者认为，设置枢密院的原始目的，在于进一步削弱南北两院夷离堇的权力。得此观点，主要因为以下几点原因。

首先，南北两院夷离堇虽然官位居于南北两府宰相之下，但是其掌握的实力却在南北两府宰相之上。南北两府宰相“掌佐理军国之大政”²⁷，但是南北两院的夷离堇却是“分掌部族军民之政”²⁸。可以发现，两府宰相只是帮助皇帝处理军国大事，手中并无军权。而两院夷离堇则是掌握着契丹最强两大军事集团，其实力当在两府宰相之上。世宗皇帝本人正是得益于两院夷离堇的共同支持，清楚两院实力强大引发的危害。因此要削弱也是首先削弱南北两院夷离堇的权力。

其次，太宗继位时由于南院夷离堇迭里公然表态支持皇太子耶律倍继承皇位使得南北两院夷离堇就皇位继承人的问题意见相左，险些引发内乱。世宗继位时由于南北两院夷离堇意见相同，于是仗着自己掌握的强大部族军队公然违背太宗生前定下的关于契丹皇位继承人的安排，险些引发大规模内战。然而世宗继位后经过若干的调整，不论是穆宗耶律璟还是景宗耶律贤继位，甚至是圣宗耶律隆绪继位都没有再发生南北两院夷离堇干涉皇位继承的事情。

第三，根据史料记载发现，枢密院是世宗即位的当年设制的。枢密院的设立就是用于节制两院部族军队的。首届枢密使则是世宗的心腹耶律安搏。世宗如此迫不及待的举动，无不是在宣告着要尽快削弱南北两院夷离堇的权力。

四、结语

通过上述分析可以发现，太祖阿保机面临迭刺部强大难治的问题，选择将其析分为南北两院并且各置夷离堇，欲借此达到削弱其势力的目的。析分迭刺部的同时再由皇帝直接任命两院夷离堇确实可以在一定程度上获得分其权、弱其势的效果，但是此举仍然存在些许隐患。因为析分以后的南北两院仍然是契丹内部的主体部族，因此他们的意见往往能在很大程度上影响契丹政治的走向。不论是其意见相同或者意见相左，所带来的负面影响都是巨大的。尤其是在皇帝统兵在外突然去世的时候，南北两院夷离堇爆发的能量更是巨大的。因此耶律阮在两院的支持下夺得皇位以后便迫不及待的最大限度的削弱南北两院夷离堇的权力。而北枢密院便是此种背景下的产物，是世宗学习中原制度并将其改造，使其适应契丹本民族的特色，更是世宗为有效掌握契丹部族军队的力量而产生的制度。

内蒙古大学硕士研究生

²⁶ 何天明：《枢密院制度》，《辽代政权机构史稿》，第29页。

²⁷ 《辽史》卷四十五《百官志一》，第778页。

²⁸ 《辽史》卷四十五《百官志一》，第780页。



THE CULTURAL WAY

ABSTRACT

Through the above analysis, it can be found that Taizu Abaoji faced the problem that the Diela tribe was powerful and difficult to govern, so he chose to divide it into two chambers, the North and the South, and set aside barbarians for each, in order to achieve the purpose of weakening its power. It is true that the emperor directly appoints Yi Lijin of the two courts while analyzing and analyzing the Diela tribe, which can achieve the effect of dividing power and weakening power to a certain extent, but there are still some hidden dangers in this move. Because after the analysis, the Northern and Southern Houses are still the main tribes within the Khitan, so their opinions can often influence the direction of Khitan politics to a great extent. The Northern Privy Council is the product of this background. It is the system that Sejong learned from the Central Plains system and transformed it to adapt to the characteristics of the Khitan nation. It is also the system that Sejong created to effectively control the power of the Khitan tribal army.

Keywords: *Abaoji, Dielabu, Yelu Ruan, Privy council*

НОМ ЗҮЙ

1. 【元】脱脱等著，刘浦江等校：《辽史》卷一《太祖本纪上》，中华书局修订本，2017
2. 《辽史》卷一百一十二《耶律辖底传》
3. 《辽史》卷一《太祖本纪上》
4. 《辽史》卷三十三《营卫志下》
5. 《辽史》卷三《太宗本纪上》
6. 《辽史》卷四十五《百官志一》
7. 何天明：《迭刺部与北南大王院》，《辽代政权机构史稿》，内蒙古大学出版社，2004
8. 《辽史》卷五《世宗本纪》
9. 陈述：《契丹政治史稿》，人民出版社，1986
10. 何天明：《枢密院制度》，《辽代政权机构史稿》

“СОЁЛЫН ЖИМЭЭР” эрдэм шинжилгээний сэтгүүлд

ӨГҮҮЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ

Ерөнхий шаардлага:

- Урьд өмнө хэвлэгдээгүй байх
- Монгол судлал ба түүх, соёлын чиглэлийн асуудлыг хөндсөн байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, шинэлэг үзэл санаа дэвшүүлсэн байх
- Судалгааны логик уялдаа, дэс дараалал тодорхой байх

Техник шаардлага:

- Кирил үсгээр бичигдсэн байх (үүний хамт гарчиг, товч агуулга, түлхүүр үг зэргийг англи хэл дээр бичих)
- Хэл зүй хийгээд найруулга зүйн ямар нэг алдаагүй байх
- Үг үсгийн алдаагүй байх
- Цаасны хэмжээ В5
- Үсгийн өндөр 12
- Эшлэл зүүлтийг тухайн хуудсанд хийх эсвэл АРА форматаар бичсэн байх (үсгийн өндөр 10)
- Нүүрийн тоо – 8-15

Судалгааны ажлын бүтэц:

Гарчиг

- Гарчиг англи хэл дээр (content)
- Судлаачийн овог нэр, эрдмийн цол зэрэг, эрхэлж буй ажил, и-мэйл хаяг, утасны дугаарыг бичих
- Товч агуулга
- Товч агуулга англи хэл дээр (abstract)
- Түлхүүр үг
- Түлхүүр үг англи хэл дээр (key word)
- Судалгааны үндсэн хэсэг
- Дүгнэлт
- Ном зүй
- Дагалдуулал (хэрвээ шаардлагатай бол үйлдэх)

Өгүүлэл хэвлэгдэх явц:

- Өгүүлэл хүлээн авна.
- Өгүүллийг редакцийн гишүүд шүүн хэлэлцэнэ.
- Хэвлэх ба үл хэвлэхийг шийднэ.
- Хэвлэгдэх боломжтой засварлах, өөрчлөх зүйлс буйг мэдэгдэнэ (тодорхой хугацаа өгнө).
- Өгүүлэл хэвлэгдэнэ.

8-15 – גיליון 15 – 2000

(10 עמודים)

העיתון "הארץ" – 10.10.2000

12 – עמודים

B5 – עמודים

העיתון "הארץ" – 10.10.2000

העיתון "הארץ" – 10.10.2000

העיתון "הארץ" – 10.10.2000

העיתון "הארץ" – 10.10.2000

הערות:

העיתון "הארץ" – 10.10.2000

העיתון "הארץ" – 10.10.2000

העיתון "הארץ" – 10.10.2000

העיתון "הארץ" – 10.10.2000

הערות:

העיתון "הארץ" – 10.10.2000

-> **לשון המהירות** ..

-> **לשון המהירות** היא מילה המיוערת לשימוש במסמכים המיוערים לשימוש במסמכים (למשל: **לשון המהירות**) ..

-> **לשון המהירות** ..

-> **לשון המהירות** ..

-> **לשון המהירות** ..

לשון המהירות :

-> **לשון המהירות** (לשון המהירות) ..

-> **לשון המהירות** ..

-> **לשון המהירות** ..

-> **לשון המהירות** ..

-> **לשון המהירות** (key word) ..

-> **לשון המהירות** ..

-> **לשון המהירות** (abstract) ..

-> **לשון המהירות** ..

-> **לשון המהירות** ..

-> **לשון המהירות** .. **E-mail** ..

-> **לשון המהירות** (content) ..

-> **לשון המהירות** ..

לשון המהירות :